



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Дашцэрэнгийн ЭНХТҮВШИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон

Утас: 26-27-71, Факс: 32-70-16

E-mail: Enkhtuvshin@parliament.mn

<http://www.parliament.mn>

2026.04.30 № УИХ-03/4865
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, О.Алтангэрэл, Р.Батболд, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд, Г.Уянгахишиг нар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Д.ЭНХТҮВШИН

О.АЛТАНГЭРЭЛ

Р.БАТБОЛД

Д.ПҮРЭВДАВАА

Л.СОРОНЗОНБОЛД

Г.УЯНГАХИШИГ

00000153



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Дашцэрэнгийн ЭНХТҮВШИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-71, Факс: 32-70-16
E-mail: Enkhtuvshin@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.04.08 № ЧИХ-03/3593
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай**

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт 88 хуудас.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Д.ЭНХТҮВШИН

00000133



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ЭНХТҮВШИН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025-12-26 № НХТ/3665

танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт ⁰³ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

• 000255018980

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 34 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“17.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингээс санаачлан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингээс санаачлан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэхдээ харгалзан үзэх нөхцөл байдлыг хэт ерөнхий байдлаар тусгасан нь хууль хэрэглээний хувьд ойлгомжгүй байдлыг бий болгох эрсдэлтэй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэх процессын шинжтэй хэм хэмжээ, түүнийг хэрэглэх үндэслэл, шалгуур нь тодорхой, үнэлэх боломжтой байх нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах суурь нөхцөл болдог.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу авах таслан сэргийлэх арга хэмжээ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагч саад учруулахгүй байх нөхцөлийг хангах зорилготой бөгөөд тухайн арга хэмжээг хязгаарлагдмал хүрээнд зайлшгүй шаардлагатай тохиолдолд авч хэрэгжүүлдэг.

Хуулийн төсөлд тусгасан нөхцөлүүд нь хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээний үр дагаврыг харгалзан шийдвэр гаргадаг байхад чиглэсэн нь зарчмын хувьд зөв боловч эдгээр нөхцөлийг ямар шалгуураар, хэрхэн үнэлэх талаар объектив шалгуур дутмаг байгаа нь хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэл учруулж болзошгүй байна.

Тухайлбал, хуулийн төсөлд тусгасан “ноцтой хохирол”, “илт хохирол учруулах” гэх зэрэг ойлголтыг хэрхэн ойлгож хэрэглэх, тухайн эрсдэл нь бодитой эсэхийг ямар шалгуураар тогтоох зэрэг нь тодорхойгүй байна. Иймд хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авахад харгалзан үзэх нөхцөлийг зорилгодоо нийцсэн, зайлшгүй шаардлагатай, зохистой байх, тухайн зорилгод хүрэх өөр хөнгөн арга хэмжээ авах боломжгүй байх, мөн хамгаалахыг зорьж байгаа эрх ашиг сонирхол болон учирч болзошгүй сөрөг үр дагаврын хоорондын тэнцвэрийг хангах зэрэг зарчимд тулгуурлан хуулийн төсөлд илүү тодорхой, бодит шалгуур, нөхцөлийг нарийвчлан тусгах шаардлагатай;

2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4, 5, 6 дахь хэсэгт хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах үндсэн хугацаа нэг сар хүртэл байх, таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл арилаагүй гэж үзвэл уг хугацааг тухай бүр нэг сар хүртэл хугацаагаар сунгах, нийт хугацаа 6 сараас хэтэрч болохгүй байхаар тусгасан боловч хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад энэ зохицуулалтыг тусгах болсон хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага, олон улсын сайн туршлага хангалттай тусгагдаагүй, тодорхой бус байна.

Хуулийн этгээдийн холбогдсон хэргийн нөхцөл байдал, цар хүрээнээс хамааран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа 6 сарын хугацаанд бүрэн шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдлыг анхаарч үзэх шаардлагатай. Тухайлбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээд дахин гэмт хэрэг үйлдэх, хууль бусаар олсон хөрөнгө, орлогын эх үүсвэрийг нуун далдлах, өөрчлөх, шилжүүлэх эрсдэл бий болохоос гадна хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд ноцтой хор хохирол учирч болзошгүй нөхцөл байдал үргэлжлэх боломжтой байдаг. Мөн хэргийн онцлогоос хамааран нотлох баримтад тусгай мэдлэг бүхий субъектээр дүгнэлт гаргуулах, шинжээчийн болон аудитын дүгнэлт авахад тодорхой хугацаа шаардагддаг нь мөрдөн шалгах ажиллагаа удаашрах бодит нөхцөлийг үүсгэдэг.

Нөгөө талаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах санал, хүсэлтийг шүүхэд гаргаж болно” гэж заасны дагуу таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх, хүчингүй болгуулах тухай хүсэлтийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд гаргах боломжтой байна.

Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн, шуурхай явагдах нөхцөлийг хангах, бодитойгоор саад учруулж байгаа, эсхүл саад учруулж болзошгүй үйлдлийг гаргуулахгүй байх, хэргийн бодит байдлыг тал бүрээс нь бодитой тогтоох зорилгын хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4, 5, 6 дахь хэсгийг тус тус хасах;

3.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 9, 10, 11, 12 дахь хэсэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.1 дүгээр зүйлд заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа “бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, бусад хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах эсэх”, “тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэх эсэх” нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэх, мөн тус ажиллагааны нийт хугацаа 6 сар хүртэл байхаар тус тус тусгажээ.

Дээрх мөрдөн шалгах ажиллагаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх” зорилгод нийцсэн, Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан “Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ”-г шүүх хэрэглэх урьдчилсан нөхцөлийг хангахад чиглэсэн, прокурорын зөвшөөрлийн үндсэн дээр явагддаг ажиллагаа юм.

Хуульд зааснаар аливаа иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлд байгаа хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагаа явуулахад


→ тухайн хөрөнгө нь гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон, эсхүл хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байх урьдчилсан нөхцөл заавал хангасан байх шаардлагатай.

Харин хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааны улмаас хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн, хөндөгдсөн, мөн хуулийн төсөлд тусгагдсан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу хүсэлт, гомдол гаргах замаар хязгаарлалтыг цуцлах асуудлыг шийдвэрлүүлэх боломжтой.

Мөн хуулийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч...яллах, цагаатгах,...нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтооно” гэж тус тус хуульчилсан.

Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах, хэргийн бодит байдлыг тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл арилах хүртэл хугацаанд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах шаардлагатай тул хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 9, 10, 11, 12 дахь хэсгийг бүхэлд нь хасах;

4.Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэрт тавигдах шаардлагыг бүрэн хангах шаардлагатай байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ЭНХТҮВШИН

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл шаардлага

1.1 Хууль зүйн үндэслэл

Манай улс 2015 оны Эрүүгийн хуульд “хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах”¹ буюу дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөөд буй “Corporate Criminal Liability” онолыг хуульчилсан нь олон улсын жишигт нийцсэн дэвшил болсон. Түүнчлэн энэ нь Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг НҮБ-ын конвенц² болон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц³-д нийцдэг. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад 34 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр байна. Эрүүгийн хариуцлагын төрлөөр нь авч үзвэл зөвхөн торгох ял оногдуулах долоон зүйл, торгох ял, эрх хасах арга хэмжээ оногдуулах 24 зүйл, татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэх хоёр зүйл, эдгээрийг хамтад нь хэрэглэх нэг зүйл байна.

Улмаар 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “ЭХХШТХ” гэх)-н зорилгод “... гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах...” гэж тусган, мөн хуулийн 20-р бүлгээр хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тусгайлсан бүлэг оруулж өгснөөр хуулийн этгээдийн гэм бурууг тогтоож, түүнд эрүүгийн хариуцлага оногдуулах асуудал процессын хэм хэмжээний хувьд “тодорхой хэмжээнд” зохицуулагдсан.

ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дах хэсэгт “оролцогч гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг хэлнэ” гэж хуулийн этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс хэргийн оролцогчийн хувьд ялгамжтай авч үзсэн. Энэ нь дэлхийн Загвар эрүүгийн процессын хууль⁴ болоод хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулдаг улс орнуудын жишигт нийцдэг. Хэдий тийм боловч ЭХХШТХ-д сэжигтэн, яллагдагчид хамаарах зарим зохицуулалтыг хуулийн этгээдэд нэгэн адил хэрэглэх байдлаар ерөнхийлөн тусгасан ба хуулийн этгээдийн онцлогт

¹ 2015 оны Эрүүгийн хуульд “хуулийн этгээдэд ял оногдуулах” гэж хуульчилсан байсныг 2017 оны нэмэлт өөрчлөлтөөр “хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах” болгон өөрчлөн найруулсан.

² Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 2003, 26 дугаар зүйл.

³ Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, 2004, 10 дугаар зүйлийн 2 дах хэсэг.

⁴ Model Codes for Post-Conflict Criminal Justice | United States Institute of Peace

тохирсон журам бүрэн тусгагдаагүй зохицуулалтууд бий. Тэдгээрийн нэг нь хуулийн этгээдэд авах таслан сэргийлэх арга хэмжээний зохицуулалт юм. Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны хуулийн этгээдийн субъектын онцлогт тохирсон нарийвчилсан зохицуулалт дутмаг байна.

Хуулийн этгээдэд авах таслан сэргийлэх арга хэмжээ

ЭХХШТХ-ийн 14.1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Яллагдагч, шүүгдэгчид энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу дараах таслан сэргийлэх арга хэмжээ авна” гэсний 1.1 дэх хэсэгт “хувийн баталгаа гаргах”, 1.2 дах хэсэгт “тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх”, 1.3 дах хэсэгт “хязгаарлалт тогтоох”, 1.4 дэх хэсэгт “барьцаа авах”, 1.5 дах хэсэгт “цагдан хорих”, 1.6 дах хэсэгт “цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах” таслан сэргийлэх арга хэмжээний төрлүүдийг хуульчилсан. Тус хуулийн 14.4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт зааснаас үзвэл шалгагдаж буй хуулийн этгээдэд “тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх” таслан сэргийлэх арга хэмжээг авч болохоор заасан. Ингэхдээ тус хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2 дах хэсэгт заасан “тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ”-ний нэг төрөл байдлаар хэрэгжиж байна.

ЭХХШТХ-ийн 14.4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасан хуулийн этгээдэд тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой журам дараах байдлаар хуульд зохицуулагдсан байна.

№	Журам	ЭХХШТХ-ийн зохицуулалт
1	Тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ (ТСАХ) авах үндэслэл	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагч саад учруулахгүй байх нөхцөлийг хангах
2	ТСАХ авагдах субъект	ЭХХШТХ-ийн 14.1 дүгээр зүйлийн 1.1-т дэх хэсэгт яллагдагч, шүүгдэгч гэж заасан боловч мөн хуулийн 14.4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт “хуулийн этгээд”-д хамааруулж зохицуулсан.
3	ТСАХ авах эрх бүхий этгээд	Прокурорын саналыг харгалзан шүүхийн зөвшөөрлөөр
4	ТСАХ авахад харгалзах үндэслэл, нөхцөл	Зохицуулагдаагүй
5	ТСАХ авах хугацаа	Зохицуулагдаагүй
6	ТСАХ авахыг хориглох нөхцөл	Зохицуулагдаагүй
7	ТСАХ зөрчсөнөөс үүсэх үр дагавар	Зохицуулагдаагүй
8	ТСАХ хүчингүй болгох, хугацаа сунгах, өөрчлөх үндэслэл, журам	Зохицуулагдаагүй

Дээрхээс үзэхэд ЭХХШТХ-д дараах хоёр журам огт тусгагдаагүй байна:

- Тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авахад харгалзах нөхцөл,
- Тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа.

Хуулийн этгээдийн хөрөнгийн шилжилт хөдөлгөөний хязгаарлах ажиллагаа

ЭХХШТХ-ийн 26.1 дүгээр зүйлд Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагааны талаар зохицуулсан байх ба тус зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөгч гэмт хэрэгт үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нуух, утсгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр дараах ажиллагаа явуулна” гээд 1.1-т “үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах” гэж заасан.

Хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэл, лицензийн шилжилт хөдөлгөөн хязгаарлах, банкны дансны гүйлгээг хязгаарлах ажиллагааг ихэвчлэн авдаг. Гэвч эдгээр ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл, шаардлага, хугацааны зохицуулалт мөн л тодорхой бус.

Иймд дээрх зохицуулалтуудыг нарийвчлан хуульчлах нь хууль зүйн хувьд дараах үндэслэлтэй:

1. Процессын тодорхой байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дэх хэсэгт тодорхойлсноор Монгол Улсын иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаатай эдлэхээр заасан. Шударга шүүхээр шүүлгэх эрхийн үндэс нь процессын шударга ёс бөгөөд процессын хэм хэмжээ нь хуульд үндэслэсэн, бүрэн, тодорхой бөгөөд хоёрдмол агуулгагүй байх нь тус зарчмыг хангах суурь нь юм. Тус зарчим нь ЭХХШТХ-ийн 1.6 дугаар зүйлд заасан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх зарчимтай нөхцөлддөг ба тус хуулийн 1.6 дугаар зүйлийн 6 дах хэсэгт “Энэ хуульд зааснаас өөрөөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх хэм хэмжээг тогтоосон журам гаргахыг хориглоно” гэж заасан. Мөн Монгол Улсын үндсэн хуулийн цэц нь “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэг нь шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах талаар ерөнхийд нь зохицуулсан боловч энэ талаарх үндэслэл, журмыг хуульд нарийвчлан тодорхойлоогүй, уг арга хэмжээг дур мэдэн хэрэгжүүлэхээс хангалттай хамгаалаагүй байна. Тодруулбал, шүүгдэгчийн цагдан хорих үндэслэлийг хуульд тодорхой заах, цагдан хоригдсон шалтгаан, үндэслэлээ мэдэх болон зохисгүй удаашралгүйгээр шүүлгэх эрхийг эдлүүлэх, цагдан хоригдсон, цагдан хоригдсон шийдвэрт гомдол гаргах болон давтамжтайгаар хянах журмыг

тусгах позитив үүргээ төр биелүүлээгүй байх тул энэ зохицуулалт нь Үндсэн хууль зөрчсөн” хэмээн дүгнэсэн байна⁵.

Энэ ч зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1 зүйлийн 1.8 дах хэсэгт “Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, шүүхийн шийдвэргүйгээр баривчлах, цагдан хорих, иргэний эрхийг хязгаарлах ажиллагааг зогсоон, хүний эрхийг хамгаалах, процессын шударга ёсыг хангах, мэргэжлийн байлгах чиглэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Таслан сэргийлэх ажиллагааны тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна” гэж тусгажээ.

Процессын тодорхой байдлыг хангах нь Монгол Улсын Үндсэн хууль болоод Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарчимд бүрнээ нийцэх ба хэм хэмжээний бус байдлаар иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахаас урьдчилан сэргийлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн биелэлтийг хангах суурь болно.

i. Нотлох үүргийн хуваарилалт

Эрүүгийн процессын үндсэн зарчмын нэг бол нотлох үүргийг төр хүлээх зарчим юм⁶. Гэтэл одоогийн зохицуулалтаар хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авахад харгалзах нөхцөлийг тодорхойлоогүйгээс хэргийн оролцогч өөрөө тус арга хэмжээнд харгалзаж үзэх нөхцөлийг тодорхойлж нотлох, нөгөө талаас хугацааны хязгаар байхгүйгээс арга хэмжээг хүчингүй болгуулах хүсэлтийг хэргийн оролцогч өөрөө гаргаж, түүнийхээ үндэслэлийг нотлох зэргээр нотлох үүргийг de facto хүлээж байдаг. Ингэснээр нотлох үүргийн хуваарилалт зөрчилдөж, иргэн, хуулийн этгээдийн эрх зөрчигдөх нөхцөл үүснэ.

Бусад улс орны туршлага

Хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн зохицуулалттай Франц, Испани, Эквадор зэрэг улсуудын процессын хуулиас үзвэл эдгээр улс оронд эрүүгийн гэмт хэрэгт шалгагдаж байгаа хуулийн этгээдийн хувьд хөрөнгө хамгаалах хэлбэрийн түр арга хэмжээнүүд авахаар хуульчлагдсан байна. Ингэхдээ ихэвчлэн нотлох баримт цуглуулах, нотлох баримтыг устгах, нуун дарагдуулахаас зайлсхийх, хохирогчийн хохирол барагдах боломжийг баталгаажуулах зэрэг зорилготой байна. Тухайлбал Франц улсын эрүүгийн процессын хууль (Code de procedure penale⁷)

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 6 сарын 13-ны өдрийн 07 дугаартай дүгнэлт

⁶ ЭХХШтХ-ийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй, 1.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Шүүх, прокурор, мөрдөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахыг хориглоно.

⁷ [Code of Criminal Procedure - Légifrance](#)

болоод Ялын код (Code pénal⁸)-д зааснаар хөрөнгө царцаах⁹, үйл ажиллагааг түр зогсоох¹⁰, компанийн дотоод үйл ажиллагааг хянаж хэрэгжүүлэх хэрэг гүйцэтгэгч томилох¹¹, компани дээр шүүхийн хяналт хэрэгжүүлэх¹² зэрэг түр арга хэмжээ авахаар хуульчилсан. Эдгээрээс хэрэг бүртгэгч томилох, шүүхийн хяналт хэрэгжүүлэх арга хэмжээний үеэр тухайн шалгагдаж буй эрүүгийн хэрэгтэй шууд хамааралтай үйл ажиллагааг зогсоох/түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсвэл тодорхой санхүүгийн хязгаарлалтууд тавигддаг. Эдгээр арга хэмжээг авахад дараах шаардлагууд тавигдана:

- Шүүхийн зөвшөөрөл авсан байх;
- Хууль ёсны зарчимд нийцсэн буюу зөвхөн хуульд заасан тохиолдолд тус арга хэмжээг авах;
- Тодорхой хүрээнд, тодорхой хугацаатай авагдах (жишээ нь хэрэг гүйцэтгэгч томилогдож байгаа бол 6 сар тутам шүүхээр хянагддаг);
- Хүний эрх, эрхэм чанарт үл халдах;
- Улс дамнасан мөрдөн шалгалтын тохиолдолд гадаад улсын хөрөнгөд онцгой хамгаалалт тогтоох;

Түүнчлэн Франц улсын хувьд банкны дансан дах мөнгийг царцаах (saisie pénale spéciale) ажиллагааг хийсэн бол 10 хоногийн дотор шүүхээс тус арга хэмжээг үргэлжлүүлэх эсэхийг шийддэг зохицуулалттай.

Эндээс үзвэл хуулийн этгээдийг эрүүгийн хэрэгт шалгаж байх хугацаанд түр арга хэмжээ авах зохицуулалт дэлхийн улс орнуудад янз бүрээр хуульчлагдсан байна. Гагцхүү тухайн арга хэмжээг авах үндэслэл, шаардлага, хугацаа, цаашлаад процедур журмыг дэлгэрэнгүй тусгаж, зайлшгүй шаардлагатай үед бөгөөд шалгаж буй эрүүгийн хэрэгт шууд хамааралтай байдлыг харгалздаг нь харагдаж байна.

1.2 Практик шаардлага

Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах зохицуулалт хуульчлагдсанаас хойш жил ирэх тусам хуулийн этгээдэд холбогдуулан шалгаж буй эрүүгийн хэргийн тоо өсөж байна¹³. Гэтэл холбогдох процессын хэм хэмжээг нарийвчлан тодорхойлж өгөөгүйгээс практикт хэргийн нөхцөл байдлаас үл хамааран тухайн хэргийг хянан шийдвэрлэж байх бүхий л

⁸ https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006070719/

⁹ Criminal of Criminal Procedure – 706-103, 706-141

¹⁰ Code of Penalty – 131-39

¹¹ Code of Penalty – 131-39-2

¹² Code of Penalty – 131-46 (Татан буулгах нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл боловч эцсийн шийдвэр гарахаас өмнө шүүхээс урьдчилсан байдлаар хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг түдгэлзүүлэх тохиолдол байдаг)

¹³ 2023 онд анхан шатны шүүхүүд нийт 23 хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хүлээн авснаас 18 хэрэгт хуулийн этгээдийг гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага оногдуулсан бол 2024 онд 27 хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хүлээн авснаас 15 хуулийн этгээдийг гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага оногдуулсан байна. (Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөл, "Монгол Улсын шүүхийн 2023, 2024 онуудын шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ")www.judcounsel.mn 2024, www.judcounsel.mn 2023

хугацаанд хуулийн этгээдийн үйл ажиллагааг бүрэн түдгэлзүүлэх, банкны данс дах мөнгө түгжигдэх тохиолдол гарч байна. Энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгоос давсан, эдийн засаг, нийгэмд хэт хохиролтой үр дагавар бий болгох эрсдэлтэй.

Таслан сэргийлэх арга хэмжээ нь эрүүгийн процессын онолд “сэжигтэн, яллагдагч нь мөрдөн шалгах, шүүхийн ажиллагаанаас зайлсхийх, дахин гэмт хэрэг үйлдэх, нотлох баримтыг устгах, хуулийн үйл явцад саад учруулахыг урьдчилан сэргийлэх” зорилготой. Мөрдөн шалгах ажиллагааны хувьд тухайн хэргийн талаар нотловол зохих байдлыг тогтооход чиглэсэн байх ёстой болохоос тус зорилгоосоо давсан байдлаар хэрэгжих, хугацаагүйгээр бусдын эрхийг хөндөх үндэслэл болж болохгүй. Гэвч хуульд хуулийн этгээдэд үйл ажиллагааг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаа хийхэд нөхцөл, шалгуур тодорхой тусгагдаагүйгээс практикт дараах хүндрэлүүд гарч байна:

- Үйлдвэрлэл, үйлчилгээ тасалдах, орлого олох эх үүсвэр бүрэн хаагдах;
- Түргэн муудах бүтээгдэхүүн чанараа алдах, нийлүүлэлтийн сүлжээ тасалдах;
- Нийтийн ашиг сонирхолд хохирол учрах (ялангуяа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр эсвэл концессоор үйл ажиллагаа явуулж буй бол);
- Ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт, тэдний өрхийн орлогод сөрөг нөлөө үзүүлэх;
- Хувийн хэвшил эргэлтийн хөрөнгөгүй болох, өдөр тутмын төлбөр тооцоо саатаж, бизнесийн хэвийн ажиллагаа алдагдах;
- Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой болох (татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, үйл ажиллагааны тайлан мэдээ хүргүүлэх үүрэг зэрэг);
- Зээлийн эргэн төлөлт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа доголдож, санхүүгийн нэр хүнд буурах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгоос давсан нийгэм, эдийн засгийн үр дагавар үүсэх;

ЭХХШТХ-д зааснаар хуулийн этгээдийн эрхийг тодорхой хэмжээнд хязгаарлах эрх зүйн боломжийг нээж өгсөн ч, энэ хязгаарлалт нь угтаа пропорциональ зарчимд нийцсэн буюу зайлшгүй бөгөөд хууль ёсны зорилгод нийцсэн хамгийн бага хязгаарлалтаар хэрэгжих ёстой.

Нөгөөтээгүүр, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын 4.1 дэх хэсэгт эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлт тасралтгүй нэмэгдсэн байх, бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадвар дээшилсэн байх, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байх зорилтуудыг дэвшүүлсэн. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3-р бүлэгт зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн

түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ гэсэн зорилгыг тусгасан.

Гэтэл хуулийн этгээдийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг ажиллагааг тодорхой хязгаарлалтгүй хэрэгжүүлэх нь зөвхөн тухайн компанийн бус, улсын эдийн засаг, татварын орлогын хувьд ч ноцтой үр дагавар дагуулна. Үүнд:

- **Бизнесийн эрсдэл:** Тодорхой хугацаанд компани үйл ажиллагаагаа бүрэн зогсоох, эргэлтийн хөрөнгөгүй болох зэрэг нь нийлүүлэлт тасалдах, харилцагч, хэрэглэгчдийн итгэл алдагдах, цаашлаад санхүүгийн нөхцөл байдал илтэд дордох шалтгаан болж байна. Ялангуяа үйлдвэрлэл, үйлчилгээний тасралттай ажиллагаа шаарддаг салбаруудад (эрчим хүч, хүнсний үйлдвэрлэл, эм ханган нийлүүлэлт гэх мэт) энэ нь улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд ч шууд нөлөөлөх эрсдэлтэй.
- **Ажил эрхлэлт:** Хуулийн этгээдийн үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар зогсоох, банкны дансыг удаан хугацаанд хаах зэрэг нь олон зуун, зарим тохиолдолд хэдэн мянган ажилтны хөдөлмөр эрхлэлтэд шууд нөлөөлнө. Энэ нь өрхийн орлого буурах, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт хоцрогдолд орж, өр үүсэх зэрэг олон сөрөг нөлөөтэй.
- **Татварын орлого:** Монгол Улсын Сангийн яамны 2024 оны төсвийн тайлангаас үзэхэд улсын төсвийн нийт орлогын 21.4%-г нэмэгдсэн өртгийн албан татвар, 23%-ийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар бүрдүүлдэг ба аж ахуйн нэгжээс улсын төсөвт 6.4 их наяд төгрөгийг төвлөрүүлжээ¹⁴. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа доголдох нь улсын төсөвт ордог голлох татваруудын (ААНОАТ, НӨАТ, гаалийн татвар) бүрдүүлэлтэд тасалдал үүсгэж, төсвийн орлогыг багасгах сөрөг үр дагавартай.
- **Хөрөнгө оруулалтын орчин:** Хуулийн этгээдийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх арга хэмжээг үндэслэлгүй, хэт өргөн хүрээнд хэрэглэх нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлд сөргөөр нөлөөлнө. АНУ-ын Төрийн департаментын “Investment Climate Statement: Mongolia 2024” тайланд Монголын бизнесийн орчныг тодорхойгүй хууль тогтоомж, тогтворгүй зохицуулалт нь хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж дүгнэсэн.¹⁵ Ингэснээр гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал саарч, бизнесийн өрсөлдөх чадвар буурах эрсдэлтэй.

Олон улсад хүлээн зөвшөөрөгддөг Allianz Risk Barometer – Бизнесийн томоохон эрсдлийг тодорхойлох нь 2025 тайланд бизнесийн тасалдал нь бизнесийн эрсдлүүдийн 2 дугаарт бичигдсэн. Бизнесүүдийн хувьд үйл ажиллагаа түр зогсох, доголдол, тасалдал үүсэх зэрэг тохиолдолд жижиг бизнесүүд санхүүгийн дарамт, эрэлт буурах зэрэгт хамгийн хурдан буюу дунджаар 1-3 сарын дотор хямралд ордог

¹⁴ Үндэсний статистикийн хороо, “Улсын нэгдсэн төсөв 2024 он”, 2025 <https://downloads.1212.mn/>

¹⁵ АНУ-ын Төрийн департамент, “Investment Climate Statement: Mongolia 2024”, 2025 он [U.S. Department of state 2024 mongolia investment climate statement](https://www.state.gov/department-of-state-2024-mongolia-investment-climate-statement)

бол дунд, том байгууллагуудын хувьд 3-6 сарын дотор санхүү, үйл ажиллагааны стресс мэдрэгдэж, үйл ажиллагааны онцлог, эрсдлийн удирдлага зэргээсээ хамааран хаалгаа барих хүртэл эрсдэлд ордог талаарх судалгаанууд бий.

Иймд хуулийн этгээдийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг арга хэмжээг авахдаа эдийн засаг, нийгмийн бодит үр дагаврыг хуульд тодорхой тусгаж, хугацааны зохицуулалтыг оновчтой болгох шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулийн төслийн зорилго нь ЭХХШтХ-д хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ, хөрөнгийн шилжилт хөдөлгөөн хязгаарлах ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсдэг зохицуулалтын дутагдлыг арилгах, эрх зүйн орчныг сайжруулахад оршино.

Уг хуулийн төслөөр хуулийн этгээдэд хамаарах таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөн хязгаарлах ажиллагааг хэрэгжүүлэхэд харгалзах нөхцөл, хугацааг тодорхой тогтоох замаар хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг бодитой, шударга байдлаар хамгаалах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож ЭХХШтХ-д нэмэлт оруулах юм.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1.2 дах хэсэгт заасны дагуу нэмэлт оруулах хуулийн төсөл хэлбэрээр боловсруулах бөгөөд төсөлд ЭХХШтХ-д нэмэлт оруулах зохицуулалтыг тусгана. Хуулийн төсөл нь нийт 2 зүйлээс бүрдэх бөгөөд 1 дүгээр зүйлд хуульд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах, 2 дугаар зүйлд дагаж мөрдөх хугацааг тусгасан.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

ЭХХШтХ-д нэмэлт оруулах хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаанд харгалзах нөхцөл, үндэслэл тодорхой бус, хугацааны хувьд тодорхой зохицуулаагүй байдлыг зохицуулж хуулийн этгээдийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг бий болгоно. Тогтвортой байдал бий болсноор хуулийн этгээдийн ашиг, алдагдал, эрсдэлийн хэмжээг бууруулах боломж бүрдэх ба улмаар Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт татах нийгэм, хууль зүйн эерэг үр дагавартай.

ЭХХШтХ-д нэмэлт оруулах Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад төсвийн дарамт учруулахгүй ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал өсөх зэрэг эдийн засгийн сөрөг үр дагавар гарахгүй болно. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоо хийх шаардлагагүй.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай

ЭХХШТХ-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулах бөгөөд Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн үзэл баримтлал, зорилго, цаг үеийн нөхцөл байдалтай уялдаж буй билээ. Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлага үүсэхгүй болно.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай
хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Эрүүгийн хуулийн 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн шинэчилсэн найруулгаар “хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах” буюу дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөөд буй “Corporate Criminal Liability” онолыг хуульчилсан. Улмаар 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “ЭХХШТХ” гэх)-н зорилгод “ ... гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах ...” гэж тусган, мөн хуулийн 20-р бүлгээр хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тусгайлсан бүлэг оруулж өгснөөр хуулийн этгээдийн гэм бурууг тогтоож, түүнд эрүүгийн хариуцлага оногдуулах асуудал процессын хэм хэмжээний хувьд “тодорхой хэмжээнд” зохицуулагдсан.

ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дах хэсэгт “оролцогч гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг хэлнэ” гэж хуулийн этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс хэргийн оролцогчийн хувьд ялгамжтай авч үзсэн. Энэ нь дэлхийн Загвар эрүүгийн процессын хууль болоод хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулдаг улс орнуудын жишигт нийцдэг. Хэдий тийм боловч ЭХХШТХ-д сэжигтэн, яллагдагчид хамаарах зарим зохицуулалтыг хуулийн этгээдэд нэгэн адил хэрэглэх байдлаар ерөнхийлөн тусгасан ба хуулийн этгээдийн онцлогт тохирсон журам бүрэн тусгагдаагүй. Тэдгээрийн нэг нь хуулийн этгээдэд авах таслан сэргийлэх арга хэмжээ (цаашид “ТСАХ” гэх)-ний зохицуулалт юм. Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны журамд ч хуулийн этгээдийн субъектын онцлогт тохирсон нарийвчилсан зохицуулалт дутмаг байна.

Тодруулбал, ЭХХШТХ-ийн 14.4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасан хуулийн этгээдэд тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой журамд ТСАХ авахад харгалзах үндэслэл, нөхцөл, хугацаа, ТСАХ авахыг хориглох нөхцөл, зөрчсөнөөс үүсэх үр дагавар, ТСАХ хүчингүй болгох, хугацаа сунгах, өөрчлөх үндэслэл, журам зохицуулагдаагүй. Мөрдөн шалгах ажиллагааны хувьд хуулийн этгээдэд голчлон хийгддэг мөрдөн шалгах ажиллагааны нэг бол ЭХХШТХ-ийн 26.1 дүгээр зүйлд Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагаа юм. Гэвч эдгээр ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл, шаардлага, хугацааны зохицуулалт мөн л тодорхой бус байна.

Бизнесийн байгууллагуудын хувьд үйл ажиллагаа түр зогсох, доголдол, тасалдал үүсэх зэрэг тохиолдолд жижиг бизнесүүд санхүүгийн дарамт, эрэлт буурах зэрэгт хамгийн хурдан буюу дунджаар 1-3 сарын дотор хямралд ордог бол дунд, том байгууллагуудын хувьд 3-6 сарын дотор санхүү, үйл ажиллагааны стресс мэдрэгдэж, үйл ажиллагааны онцлог, эрсдлийн удирдлага зэргээсээ хамааран хаалгаа барих хүртэл эрсдэлд ордог талаарх судалгаанууд бий. Иймд энэ үр дагаварт хүргэж болзошгүй хуулийн этгээдийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг арга хэмжээг авахдаа эдийн засаг, нийгмийн бодит үр

дагаврыг хуульд тодорхой тусгаж, хугацаа, журмын зохицуулалтыг оновчтой болгох зайлшгүй шаардлагатай.

Процессын тодорхой байдлыг хангах нь Монгол Улсын Үндсэн хууль болоод Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарчимд бүрнээ нийцэх ба хэм хэмжээний бус байдлаар иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахаас урьдчилан сэргийлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн биелэлтийг хангах суурь болно. Энэ ч зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1 зүйлийн 1.8 дах хэсэгт “Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, шүүхийн шийдвэргүйгээр баривчлах, цагдан хорих, иргэний эрхийг хязгаарлах ажиллагааг зогсоон, хүний эрхийг хамгаалах, процессын шударга ёсыг хангах, мэргэжлийн байлгах чиглэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Таслан сэргийлэх ажиллагааны тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна” гэж тусгажээ. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 07 дугаар дүгнэлтээр таслан сэргийлэх арга хэмжээний үндэслэл, журам тодорхой байх нь Үндсэн хууль зөрчсөн талаар дүгнээд холбогдох шийдвэрт давтамжтай хяналт тавих журмыг тусгах нь төрийн үүрэг мөн талаар дурджээ.

Эдгээр шаардлагыг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд дараах нэмэлтийг тусгалаа:

- Хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авахад харгалзах нөхцөл;
- Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах үндсэн болон нэмэлт, нийт хугацаа;
- Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа харгалзах нөхцөл;

ЭХХШТХ-д нэмэлт оруулах хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаанд харгалзах нөхцөл, хугацаа тодорхой болох бөгөөд ажиллагааны процессыг хуульчилснаар иргэн, хуулийн этгээдийн шударга шүүхээр шүүлгэх эрх, due-process-г хангах, пропорциональ зарчмыг хангах суурь болно. Нөгөө талаас эдийн засгийн гол хөшүүрэг болсон хувийн хэвшил, бизнесийн байгууллагуудын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад энэ нь хууль зүйн орчны тодорхойгүй байдлыг бууруулж, Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт татах зэрэг нийгэм, эдийн засгийн зэрэг үр дагавартай.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Эрүүгийн хуулийн 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн шинэчилсэн найруулгаар “хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах” буюу дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөөд буй “Corporate Criminal Liability” онолыг хуульчилсан. Улмаар 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “ЭХХШТХ” гэх)-н зорилгод “... гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах...” гэж тусган, мөн хуулийн 20-р бүлгээр хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тусгайлсан бүлэг оруулж өгснөөр хуулийн этгээдийн гэм бурууг тогтоож, түүнд эрүүгийн хариуцлага оногдуулах асуудал процессын хэм хэмжээний хувьд “тодорхой хэмжээнд” зохицуулагдсан.

ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дах хэсэгт “оролцогч гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг хэлнэ” гэж хуулийн этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс хэргийн оролцогчийн хувьд ялгамжтай авч үзсэн. Энэ нь дэлхийн Загвар эрүүгийн процессын хууль болоод хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулдаг улс орнуудын жишигт нийцдэг. Хэдий тийм боловч ЭХХШТХ-д сэжигтэн, яллагдагчид хамаарах зарим зохицуулалтыг хуулийн этгээдэд нэгэн адил хэрэглэх байдлаар ерөнхийлөн тусгасан ба хуулийн этгээдийн онцлогт тохирсон журам бүрэн тусгагдаагүй. Тухайлбал, хуулийн этгээдэд авах таслан сэргийлэх арга хэмжээ болон хуулийн этгээдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хуулийн этгээдийн субъектын онцлогт тохирсон нарийвчилсан зохицуулалт дутмаг байна.

ЭХХШТХ-д нэмэлт оруулах үндэслэл, шаардлага:

ЭХХШТХ-ийн 14.4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасан хуулийн этгээдэд тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ (цаашид “ТСАХ” гэх) авахтай холбоотой журамд тухайн ТСАХ авахад харгалзах үндэслэл, нөхцөл, хугацаа, ТСАХ авахыг хориглох нөхцөл, зөрчсөнөөс үүсэх үр дагавар, ТСАХ хүчингүй болгох, хугацаа сунгах, өөрчлөх үндэслэл, журам зохицуулагдаагүй. Мөрдөн шалгах ажиллагааны хувьд ч хуулийн этгээдэд ихэвчлэн хийгддэг ЭХХШТХ-ийн 26.1 дүгээр зүйлд заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл, шаардлага, хугацаа тодорхойгүй байна.

ЭХХШТХ-д хуулийн этгээдийн эрхийг тодорхой хэмжээнд хязгаарлах эрх зүйн боломжийг нээж өгсөн ч, энэ хязгаарлалт нь угтаа пропорциональ зарчимд нийцсэн буюу зайлшгүй бөгөөд хууль ёсны зорилгод нийцсэн хамгийн бага хязгаарлалтаар

хэрэгжих ёстой. Гэтэл ийнхүү тодорхой бус журмаар, тодорхой хугацаагүйгээр хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, тэдний хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах нь тухайн бизнесийн хувьд тасалдал бий болгох, ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогод сөрөг нөлөө үзүүлэх, хувийн хэвшлийг эргэлтийн хөрөнгөгүй болгох, хэвийн ажиллагааг алдагдуулах, цаашлаад хуулиар хүлээсэн татвар, нийгмийн даатгалын үүргээ биелүүлэх боломжгүй болгох үр дагавартай.

Иймд энэхүү процессын тодорхойгүй байдлыг тодорхой болгож зохицуулах нь аливаа хэм хэмжээний бус байдлаар иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахаас урьдчилан сэргийлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн биелэлтийг хангах суурь болно.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1 зүйлийн 1.8 дах хэсэгт “Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, шүүхийн шийдвэргүйгээр баривчлах, цагдан хорих, иргэний эрхийг хязгаарлах ажиллагааг зогсоон, хүний эрхийг хамгаалах, процессын шударга ёсыг хангах, мэргэжлийн байлгах чиглэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Таслан сэргийлэх ажиллагааны тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна” гэж тусгажээ.

Иймд уг хуулийн төсөл нь хуулийн этгээдэд авах таслан сэргийлэх арга хэмжээ болон мөрдөн шалгах ажиллагааны явцад хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаанд үндэслэл, нөхцөлийг тодорхой болгох, хугацаа, сунгах журмыг нарийвчлах, процессын тодорхой байдлыг хангах зорилгоор боловсруулагдсан болно.

ЭХХШтХ-д оруулах нэмэлт зохицуулалт:

Хуулийн төсөл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 болон 26.1 дүгээр зүйлд нэмэлт оруулах замаар хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ болон хуулийн этгээдийн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааны журмыг нарийвчлан зохицуулж байна.

Энэхүү зохицуулалтад нийцүүлэн ЭХХШтХ-д дараах нэмэлтийг оруулна:

14.4 дүгээр зүйл. Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ	
Заалт	Нэмэлт
14.4 дүгээр зүйлийн 6 дах хэсэг	“6.Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг дараах нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ.”

	<p>“6.1.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, бусад хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах эсэх;”</p> <p>“6.2.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн түүхий эд, бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэх эсэх;”</p>
14.4 дүгээр зүйлийн 7 дах хэсэг	“7.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах үндсэн хугацаа 1 сар хүртэл байна.”
14.4 дүгээр зүйлийн 8 дах хэсэг	“8.Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл арилаагүй гэж үзвэл хуулийн этгээдэд авсан тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.”
14.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг	“9.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах нийт хугацаа 6 сараас хэтэрч болохгүй.”
14.4 дүгээр зүйлийн 10 дах хэсэг	“10.Мөрдөгч хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах хугацааг сунгах тухай саналаа хугацаа дуусахаас 7-оос доошгүй хоногийн өмнө прокурорт хүргүүлэх ба прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах тухай саналаа даруй шүүхэд хүргүүлнэ.”
14.4 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг	“11.Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах хугацааг сунгах тухай прокурорын саналыг хугацаа дуусахаас 4-өөс доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 14.13 дугаар зүйлд зааснаар хянан хэлэлцэж, тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах, эсхүл сунгахыг татгалзах тухай шийдвэр гаргана.”
26.1 дүгээр зүйл. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах	
Заалт	Нэмэлт
26.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэг	<p>“3.Прокурор нь хуулийн этгээдэд холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ.</p> <p>“3.1.Бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, бусад хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах эсэх”</p>

“3.2.Тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэх эсэх.”

Бусад улс орны туршлага

Хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн зохицуулалттай Франц, Испани, Эквадор зэрэг улсуудын процессын хуулиас үзвэл эдгээр улс оронд эрүүгийн гэмт хэрэгт шалгагдаж байгаа хуулийн этгээдийн хувьд хөрөнгө хамгаалах хэлбэрийн түр арга хэмжээнүүд авахаар хуульчлагдсан байна. Ингэхдээ ихэвчлэн нотлох баримт цуглуулах, нотлох баримтыг устгах, нуун дарагдуулахаас зайлсхийх, хохирогчийн хохирол барагдах боломжийг баталгаажуулах зэрэг зорилготой байна. Тухайлбал Франц улсын эрүүгийн процессын хууль (Code de procedure penale¹) болоод Ялын код (Code pénal²)-д зааснаар хөрөнгө царцаах³, үйл ажиллагааг түр зогсоох⁴, компанийн дотоод үйл ажиллагааг хянаж хэрэгжүүлэх хэрэг гүйцэтгэгч томилох⁵, компани дээр шүүхийн хяналт хэрэгжүүлэх⁶ зэрэг түр арга хэмжээ авахаар хуульчилсан. Эдгээрээс хэрэг бүртгэгч томилох, шүүхийн хяналт хэрэгжүүлэх арга хэмжээний үеэр тухайн шалгагдаж буй эрүүгийн хэрэгтэй шууд хамааралтай үйл ажиллагааг зогсоох/түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсвэл тодорхой санхүүгийн хязгаарлалтууд тавигддаг. Эдгээр арга хэмжээг авахад дараах шаардлагууд тавигдана:

- Шүүхийн зөвшөөрөл авсан байх;
- Хууль ёсны зарчимд нийцсэн буюу зөвхөн хуульд заасан тохиолдолд тус арга хэмжээг авах;
- Тодорхой хүрээнд, тодорхой хугацаатай авагдах (жишээ нь хэрэг гүйцэтгэгч томилогдож байгаа бол 6 сар тутам шүүхээр хянагддаг);
- Хүний эрх, эрхэм чанарт үл халдах;
- Улс дамнасан мөрдөн шалгалтын тохиолдолд гадаад улсын хөрөнгөд онцгой хамгаалалт тогтоох;

Түүнчлэн Франц улсын хувьд банкны дансан дах мөнгийг царцаах (saisie réelle spéciale) ажиллагааг хийсэн бол 10 хоногийн дотор шүүхээс тус арга хэмжээг үргэлжлүүлэх эсэхийг шийддэг зохицуулалттай.

Эндээс үзвэл хуулийн этгээдийг эрүүгийн хэрэгт шалгаж байх хугацаанд түр арга хэмжээ авах зохицуулалт дэлхийн улс орнуудад янз бүрээр хуульчлагдсан

¹ Code of Criminal Procedure - Légifrance

² https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006070719/

³ Criminal of Criminal Procedure – 706-103, 706-141

⁴ Code of Penalty – 131-39

⁵ Code of Penalty – 131-39-2

⁶ Code of Penalty – 131-46 (Татан буулгах нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл боловч эцсийн шийдвэр гарахаас өмнө шүүхээс урьдчилсан байдлаар хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг түдгэлзүүлэх тохиолдол байдаг)

байна. Гагцхүү тухайн арга хэмжээг авах үндэслэл, шаардлага, хугацаа, цаашлаад процедур журмыг дэлгэрэнгүй тусгаж, зайлшгүй шаардлагатай үед болон шалгаж буй эрүүгийн хэрэгт шууд хамааралтай байдлыг харгалздаг нь харагдаж байна.

ЭХХШтХ-д шинээр тусгагдсан нэр томъёо, ухагдахуун:

Дээр дурдсанчлан ЭХХШтХ-д хуулийн этгээдийн онцлогт тохирсон журам дутмаг байгаагаас түүнтэй холбоотой ухагдахуун ч төдийлөн тусгагдаагүй байдаг. Энэ шалтгаанаар таслан сэргийлэх арга хэмжээ авахад “харгалзах” үндэслэлийг хуулийн этгээд гэх эрх зүйн субьекттэй нь уялдуулж шинээр томъёолох шаардлага үүссэн. Гэвч эдгээр нь бусад хууль тогтоомжид хэдийнээ тусгагдаж, практик хэрэгжилт, албан ёсны тайлбараар тодорхойлогдсон байдаг. Процессын хэм хэмжээ тодорхой байх шаардлагатайн хувьд нэр томъёо нь хоёрдмол утгагүй, хэрэгжих боломжтой, нэг мөр хэрэглээг бий болгох боломжтой байх шаардлагатай. Эдгээр шалтгаанаар дараах нэр томъёог тус хуулийн төсөлд шинээр тусгасан болно. Үүнд:

- Бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах эсэх - Энэ ойлголтыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-т Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нэг тохиолдол байдлаар хуульчилсан байдаг. Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2023 оны 4 сарын 14-ний өдрийн хуралдааны 18 дугаар тогтоолоор “ноцтой хохирол” гэдгийг “... хэргийн оролцогч иргэний хувьд болон маргаан бүхий актын үйлчлэл шууд хандаж буй бусад иргэний ам нас нь эрсдэлд орох, эрүүл мэнд нь доройтох, эд хөрөнгө нь зориулалтын дагуу ашиглах боломжгүй болох, тухайн этгээд түүнийг өөрийн хүчээр эргүүлэн сэргээх боломжгүй, эсхүл сэргээсэн ч өмнөх байдлаасаа чанар байдлын хувьд дордохоор сөрөг үр дагавар үүсэхийг ойлгоно” гэжээ.
- Хуулийн этгээд эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах эсэх – Мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-т энэ томъёоло туссан бөгөөд “илт хохирол” гэдгийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн 2023 оны 4 сарын 14-ний өдрийн хуралдааны 18 дугаар тогтоолоор “хэргийн оролцогч хуулийн этгээдийн мөнгө болон мөнгөөр үнэлэгдэхүйц баялаг, эд хөрөнгөөр хэмжигдэх эрх, болон хөрөнгө, мөнгөөр хэмжигдэхгүй эдийн бус эрхэд их хэмжээний алдагдал бий болох нь илэрхий, тодорхой, нотлогдохуйц байхыг, эсхүл нийтийн ашиг сонирхлыг эргэж сэргээх боломжгүйгээр хохироохуйц сөрөг үр дагавар учрах нь бодитой, нотлох шаардлагагүй байхыг тус тус ойлгоно” гэж тайлбарласан байдаг.
- Үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн түүхий эд, бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэх – Энэ томъёоллыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5-д заасан шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах хязгаарлалт байдлаар хуульчилж, хэрэглэж байна.

- “Шүүх ... харгалзан шийдвэрлэнэ.” – Хуульд нөхцөлийг хатуу хориг байдлаар бус “харгалзаж үзэх нөхцөл” байдлаар тусгах нь 1-т хууль зүйн техникийн хувьд ЭХХШТХ-ийн бичилтэд нийцэх, 2-т хүний эрхийг хязгаарлах нь хамгийн сүүлийн бөгөөд хууль ёсны хамгийн бага хязгаарлалтаар хэрэгжих зарчимд нийцэх, 3-т шүүхийн дотоод итгэлийг хүлээн зөвшөөрөх, 4-т мэтгэлцэх зарчмыг хангана гэж дүгнэж байна.

ЭХХШТХ-д нэмэлт оруулах хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаанд харгалзах нөхцөл, хугацаа тодорхой болох бөгөөд ажиллагааны процессыг хуульчилснаар иргэн, хуулийн этгээдийн шударга шүүхээр шүүлгэх эрх, due-process-г хангах, пропорциональ зарчмыг хангах суурь болно. Нөгөө талаас эдийн засгийн гол хөшүүрэг болсон хувийн хэвшил, бизнесийн байгууллагуудын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад энэ нь хууль зүйн орчны тодорхойгүй байдлыг бууруулж, Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт татах зэрэг нийгэм, эдийн засгийн эерэг үр дагавартай.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/14.4 дүгээр зүйлийн 6-11 дэх хэсэг:

“6.Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг дараах нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ:

6.1.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, бусад хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах эсэх;

6.2.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн түүхий эд, бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэх эсэх;

7.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах үндсэн хугацаа 1 сар хүртэл байна.

8.Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл арилаагүй гэж үзвэл хуулийн этгээдэд авсан тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

9.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах нийт хугацаа 6 сараас хэтэрч болохгүй.

10.Мөрдөгч хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах хугацааг сунгах тухай саналаа хугацаа дуусахаас 7-оос доошгүй хоногийн өмнө прокурорт хүргүүлэх ба прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах тухай саналаа даруй шүүхэд хүргүүлнэ.

11.Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах хугацааг сунгах тухай прокурорын саналыг хугацаа дуусахаас 4-өөс доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 14.13 дугаар

зүйлд зааснаар хянан хэлэлцэж, тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах, эсхүл сунгахыг татгалзах тухай шийдвэр гаргана.”

2/26.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Прокурор нь хуулийн этгээдэд холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ:

3.1.Бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, бусад хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах эсэх;

3.2.Тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэх эсэх.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА:

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

- 2.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох
- 2.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох
- 2.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАХ

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

- 5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа
- 5.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа
- 5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа
- 5.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ДОЛОО. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН БАЙДАЛ

- 7.1. Дүгнэлт, зөвлөмж

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын зорилт нь тодорхой асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбарыг тодорхойлж, эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр үр нөлөөг урьдчилан тооцож, уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг хууль санаачлагчид санал болгоход оршино. “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл” боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал¹ (цаашид Аргачлал гэх)-ын 2.1-д заасан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх,
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолсон байдал,
3. Асуудлыг зохицуулах хувилбар, эерэг сөрөг талыг харьцуулах,
4. Хувилбаруудын үр нөлөөг тандах,
5. Хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт.

ХОЁР. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл”-ийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын хүрээнд

- Хууль зүйн яам
- Улсын Их Хурлын тамгын газар
- Монгол Улсын Ерөнхий прокурорын газар
- Цагдаагийн Ерөнхий газрын дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтэс
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи
- Татварын ерөнхий газар
- Нийгмийн даатгалын ерөнхий газар
- Монгол улсын үндэсний статистикийн хороо
- Хууль зүйн үндэсний хүрээлэн
- Нээлттэй нийгэм форум
- Легал Дата ХХК зэрэг газруудаас “Хуулийн этгээдэд авсан таслан сэргийлэх арга хэмжээний талаарх судалгаа, тоон судалгаа болон бусад мэдээлэл”-ийг цуглуулж тухайн асуудалд дүн шинжилгээ хийсэн болно.

2.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох;

Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “ЭХХШТХ” гэх)-н зорилгод “ ... гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах ...” гэж тусган, мөн хуулийн 20-р бүлгээр хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тусгайлсан бүлэг оруулж өгснөөр

¹Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

хуулийн этгээдийн гэм бурууг тогтоож, түүнд эрүүгийн хариуцлага оногдуулах асуудал процессын хэм хэмжээний хувьд “тодорхой хэмжээнд” зохицуулагдсан байна. ЭХХШТХ-д сэжигтэн, яллагдагчид хамаарах зарим зохицуулалтыг хуулийн этгээдэд нэгэн адил хэрэглэх байдлаар ерөнхийлөн тусгасан ба хуулийн этгээдийн онцлогт тохирсон журам бүрэн зохицуулагдаагүй байна. Тухайлбал, хуулийн этгээдийн онцлогт тохирсон хуулийн этгээдэд авах таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, таслан сэргийлэх арга хэмжээ авахад харгалзан үзэх нөхцөл байдал, таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа, хугацаа сунгах, авч болохгүй нөхцөл гэх мэт асуудлыг нарийвчлан зохицуулаагүйгээс хуулийн этгээд, цаашлаад тухайн хуулийн этгээдэд ажиллаж буй иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байна.

Асуудал 1: Процессын тодорхой байдал

Хуулийг хэрэгжүүлэхэд холбогдох албан тушаалтны санаатай, санамсаргүй алдаа гарч, хуулийн зохицуулалт зөрчигдөж байхыг үгүйсгэхгүй ч аль болох алдаа гаргахгүйгээр уншаад нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой, хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн үндэслэлтэй, тодорхой зохицуулалт бүхий хуулийг батлах нь төрийн үндсэн үүрэг юм.²

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дэх хэсэгт тодорхойлсноор Монгол Улсын иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаатай эдлэхээр заасан. Шударга шүүхээр шүүлгэх эрхийн үндэс нь процессын шударга ёс бөгөөд процессын хэм хэмжээ нь хуульд үндэслэсэн, бүрэн, тодорхой бөгөөд хоёрдмол агуулгагүй байх нь тус зарчмыг хангах суурь нь юм.

ЭХХШТХ-ийн 14.4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасан хуулийн этгээдэд тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой журам дараах байдлаар хуульд зохицуулагдсан байна.

№	Журам	ЭХХШТХ-ийн зохицуулалт
1	Тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ (ТСАХ) авах үндэслэл	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагч саад учруулахгүй байх нөхцөлийг хангах
2	ТСАХ авагдах субъект	ЭХХШТХ-ийн 14.1 дүгээр зүйлийн 1.1-т дэх хэсэгт яллагдагч, шүүгдэгч гэж заасан боловч мөн хуулийн 14.4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт “хуулийн этгээд”-д хамааруулж зохицуулсан.
3	ТСАХ авах эрх бүхий этгээд	Прокурорын саналыг харгалзан шүүхийн зөвшөөрлөөр
4	ТСАХ авахад харгалзах үндэслэл, нөхцөл	Зохицуулагдаагүй
5	ТСАХ авах хугацаа	Зохицуулагдаагүй
6	ТСАХ авахыг хориглох нөхцөл	Зохицуулагдаагүй
7	ТСАХ зөрчсөнөөс үүсэх үр дагавар	Зохицуулагдаагүй
8	ТСАХ хүчингүй болгох, хугацаа сунгах, өөрчлөх үндэслэл, журам	Зохицуулагдаагүй

² Цэцийн дүгнэлт, № 07, 2025 он

Дээрхээс үзэхэд хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээнд ЭХХШтХ-д дараах хоёр журам огт тусгагдаагүй байна:

- Тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авахад харгалзах нөхцөл;
- Тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа;

Асуудал 2: Хуулийн этгээдэд авах таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, харгалзах нөхцөл, хугацаа

Одоогийн мөрдөж буй хуулийн дагуу хэрэгт шалгагдаж байгаа хуулийн этгээдэд холбогдуулан таслан сэргийлэх арга хэмжээ болон мөрдөн шалган бусад ажиллагааны хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэл, лицензийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, банкны дансны гүйлгээг хязгаарлах зэрэг ажиллагаа хийгддэг. Гэвч эдгээр ажиллагааг авах цар хүрээ, хэрэгжүүлэх нөхцөл, шаардлага, харгалзан үзэх нөхцөл байдал, дээрх арга хэмжээг авч болохгүй нөхцөл байдал, хугацааг огт зохицуулаагүй болохыг дахин дурдах нь зүйтэй юм.

- Хуулийн этгээдийн таслан сэргийлэх арга хэмжээ

ЭХХШтХ-ийн 14.4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт зааснаас үзвэл шалгагдаж буй хуулийн этгээдэд “тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх” таслан сэргийлэх арга хэмжээг авч болохоор заасан. Ингэхдээ тус хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2 дах хэсэгт заасан “тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ”-ний нэг төрөл байдлаар хэрэгжиж байна.

- Хуулийн этгээдийн хөрөнгийн шилжилт хөдөлгөөний хязгаарлах мөрдөн шалгах ажиллагаа;

ЭХХШтХ-ийн 26.1 дүгээр зүйлд Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагааны талаар зохицуулсан байх ба тус зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөгч гэмт хэрэгт үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр дараах ажиллагаа явуулна” гээд 1.1-т “үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах” гэж заасан.

Хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэл, лицензийн шилжилт хөдөлгөөн хязгаарлах, банкны дансны гүйлгээг хязгаарлах ажиллагааг ихэвчлэн авдаг байна. Гэвч эдгээр ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл, шаардлага, хугацааны зохицуулалт мөн тодорхой бус байна.

2.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох

Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах зохицуулалт хуульчлагдсанаас хойш жил ирэх тусам хуулийн этгээдэд холбогдуулан шалгаж буй

эрүүгийн хэргийн тоо өсөж байна. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2017-2024 он, 2025 оны эхний 07 сарын байдлаар нийт 445 хуулийн этгээдийг яллагдагчаар татсанаас 238 буюу 53.5 хувь нь нийслэлд 207 буюу 46.5 хувь нь орон нутагт тус тус бүртгэгдсэн байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулиар нийт 34 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байх ба зөвхөн торгох ял оногдуулах 7 зүйл, торгох ял, эрх хасах арга хэмжээ оногдуулах 24 зүйл, татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэх 2 зүйл, эдгээрийг хамтад нь хэрэглэх 1 зүйл байна.

Иймд хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг шалгах, түүнд холбогдуулан авч хэрэгжүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ болон мөрдөн шалгах ажиллагааны процессын хэм хэмжээг нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Процесс тодорхойгүйгээс практикт хэргийн нөхцөл байдлаас үл хамааран тухайн хэргийг хянан шийдвэрлэж байх бүхий л хугацаанд хуулийн этгээдийн данс битүүмжлэх, үйл ажиллагааг зогсоох, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, үйл ажиллагаа явуулах үндсэн эд хөрөнгийг битүүмжлэх тохиолдол гарч байгаагаас гадна өсөх эрсдэлтэй байна. Энэ нь хуулийн этгээд, бизнесийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, наад захын санхүүгийн нөхцөл байдал доголдож, цаашлаад хувийн хэвшлийн тогтвортой байдал, тухайн байгууллагын олон мянган ажилтны эрхийг зөрчихөөр байна. Тодорхой цаг хугацаанд давтамжтай хяналтгүйгээр хуулийн этгээдийн үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа албадлагын шинжтэй шийдвэр агуулгаараа улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлөх бөгөөд зохицуулалтын хувьд тодорхой, бодит нөхцөл байдалд тохирсон, үндэслэл бүхий байх шаардлагатай.

2.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох

Таслан сэргийлэх арга хэмжээ нь эрүүгийн процессын онолд “сэжигтэн, яллагдагч нь мөрдөн шалгах, шүүхийн ажиллагаанаас зайлсхийх, дахин гэмт хэрэг үйлдэх, нотлох баримтыг устгах, хэргийн оролцогчдод нөлөөлөх, хэрэг мөрдөх ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцөлийг хангах” зорилготой. Мөрдөн шалгах ажиллагааны хувьд тухайн хэргийн талаар нотолбол зохих байдлыг тогтооход чиглэсэн байх шаардлагад нийцүүлж хийгдэх бөгөөд тус зорилгоосоо давсан байдлаар хэрэгжих, хугацаагүйгээр бусдын эрхийг хөндөх үндэслэл болж болохгүй юм. Гэвч хуульд хуулийн этгээдэд үйл ажиллагааг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаа хийх нөхцөл, шалгуур хуульд тодорхой тусгагдаагүйгээс практикт дараах хүндрэлүүд гарч байна:

- Үйлдвэрлэл, үйлчилгээ тасалдах, орлого олох эх үүсвэр бүрэн хаагдах;
- Түргэн муудах бүтээгдэхүүн чанараа алдах, нийлүүлэлтийн сүлжээ тасалдах;
- Нийтийн ашиг сонирхолд хохирол учрах (ялангуяа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр эсвэл концессоор үйл ажиллагаа явуулж буй бол);
- Ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт, тэдний өрхийн орлогод сөрөг нөлөө үзүүлэх;
- Хувийн хэвшил эргэлтийн хөрөнгөгүй болох, өдөр тутмын төлбөр тооцоо саатаж, бизнесийн хэвийн ажиллагаа алдагдах;
- Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох (татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, үйл ажиллагааны тайлан мэдээ хүргүүлэх үүрэг зэрэг);
- Зээлийн эргэн төлөлт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа доголдож, санхүүгийн нэр хүнд буурах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгоос давсан нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэх;

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ

Хуулийн төслөөр хуулийн этгээдэд хамаарах таслан сэргийлэх арга хэмжээ болон мөрдөн шалгах ажиллагааны явцад хуулийн этгээдэд холбогдуулан авч буй хязгаарлалт тогтоох ажиллагааг хэрэгжүүлэхэд харгалзах нөхцөл байдал, тодорхой хугацаа тогтоох, хугацаа сунгах, шүүхийн хяналтад оруулах замаар хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг бодитой, шударга байдлаар хамгаалах, хуулийг боловсронгуй болгож, эрх зүйн орчныг сайжруулна.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАХ

Энэхүү үнэлгээний тайлангийн 2.1-д заасан асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, " Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл"-ийн зорилтыг хангаж чадах эсэх, зардал үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2.	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгаа хийх	Асуудлыг шийдвэрлэх боломжгүй	Зардал шаардагдана. Асуудалд нөлөөлж чадахгүй.	Үр дүн сөрөг
3.	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зохицуулалтын замаар шийдвэрлэх боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудалд нөлөөлж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй, үр дүн сөрөг
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх аргаар зохицуулах боломжгүй.	Зардал шаардана. Асуудалд нөлөөлж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй, үр дүн сөрөг
5.	Төрийн бус байгууллага хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Боломжгүй.	Асуудлыг шийдвэрлэх боломжгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
6.	Захиргааны шийдвэр гаргах	Боломжгүй	боломжгүй	Тодорхой үр дүнд хүрэхгүй
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	улсын төсөвт дарамт учрахгүй, иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй, улсын төсөвт шинээр нэмэлт зардал бий болохгүй болно	Үр дүнтэй

Дээрх хувилбараас 7-р хувилбар буюу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг судалгаагаар дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой гэж үзэн сонгож байна.

7-р хувилбарын эерэг болон сөрөг талыг тус бүрд нь авч үзвэл;

- Зорилгод хүрэх байдал

Олон улсад хүлээн зөвшөөрөгддөг Allianz Risk Barometer 2025 тайланд бизнесийн тасалдал нь бизнесийн эрсдэлүүдийн 2 дугаарт бичигдсэн байх ба аж ахуйн нэгжийг богино хугацаанд хямралд оруулдаг болохыг харуулсан байна. Мөн АНУ-ын Төрийн департаментын "Investment Climate Statement: Mongolia 2024"³ тайланд Монголын бизнесийн орчныг тодорхойгүй хууль тогтоомж, тогтворгүй зохицуулалт нь хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж дүгнэсэн.

Мөн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын 2023 оны Бизнесийн орчны судалгаагаар Засаглал хууль эрх зүйн орчны үнэлгээ (-0.26 нэгжээр, 10% хувь) буурсан нь өмнөх үеэс буурсан, сөрөг үзүүлэлттэй байна. Үүнд, бизнесийг зогсоох, татан буулгах, бизнестэй холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэх үзүүлэлтээр 2.47, 2.49 буюу муу гэж үнэлэгдсэн байна.

Иймд бизнесийг зогсоох, тасалдуулах эрх зүйн орчны тодорхой болгох үүднээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахад харгалзах нөхцөл, үндэслэл тодорхой бус байгаа зохицуулалтын дутагдлыг арилгах шаардлагатай. Энэхүү зорилгыг харгалзан Хуулийн төслийн зохицуулалт нь Хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь сонголоо.

- Зардал, үр өгөөжийн харьцаа

Энэхүү Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын төсөвт дарамт учрахгүй, иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй, улсын төсөвт шинээр нэмэлт зардал бий болохгүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нэмэгдэхгүй. Иймд энэ Хуулийн төслийн зохицуулалт нь практикт шууд хэрэгжих боломжтой.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Хууль, тогтоомжийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын дагуу "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл"-ийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлахдаа аргачлалд заасан дор дурдсан суурь асуултуудыг ашиглан судалгааг хийлээ. (Хүснэгт 1, 2, 3, 4-т харуулав)

5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: (Хүснэгт1)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
------------------	------------------	---------	---------

³ АНУ-ын Төрийн департамент, "Investment Climate Statement: Mongolia 2024", 2025 он [U.S. Department of state 2024 mongolia investment climate statement](#)

1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх;	Тийм		
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх;		Үгүй	
	1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх;		Үгүй	
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх;	Тийм		
	1.2.2. Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх;	Тийм		
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх;	Тийм		
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх;	Тийм		
1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх;		Үгүй		
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх;	Тийм		
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх;	Тийм		
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх;	Тийм		
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх;		Үгүй	
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх;		Үгүй	
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон		Үгүй	

	мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй);			
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх;	Тийм		
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх;		Үгүй	
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх;		Үгүй	

5.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: (Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх;	Тийм		
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан);	Тийм		
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх;	Тийм		
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх;		Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх;		Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополыг бий болгох эсэх;		Үгүй	
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх;		Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх;		Үгүй	

	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх;		Үгүй	
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх;		Үгүй	
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх;		Үгүй	
5. Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх;		Үгүй	
	5.2. Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх;		Үгүй	
	5.3. Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх;		Үгүй	
6. Инновац болон судалгаа шинжилгээ	6.1. Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх;		Үгүй	
	6.2. Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх;		Үгүй	
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1. Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.2. Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх;		Үгүй	
	7.3. Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх;		Үгүй	
	7.4. Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх;		Үгүй	
	8.2. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	8.3. Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
9. Төрийн захиргааны байгууллага	9.1. Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	9.2. Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх;		Үгүй	

	9.3. Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх;		Үгүй	
10. Макро эдийн засгийн хүрээнд	10.1. Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	10.2. Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх;		Үгүй	
	10.3. Инфляц нэмэгдэх эсэх;		Үгүй	
11. Олон улсын харилцаа	11.1. Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх;	Тийм		

5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: (Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1. Шинээр ажлын байр бий болох эсэх;	Үгүй	
	1.2. Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх;	Үгүй	
	1.3. Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх;	Үгүй	
	1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх;	Үгүй	
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх;	Үгүй	
	2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх;	Үгүй	
	2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх;	Үгүй	
	2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх;	Үгүй	
	2.5. Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх;	Үгүй	
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх;	Үгүй	
	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт;	Үгүй	
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх;	Үгүй	
4. Төрийн удирдлага, сайн	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх;	Үгүй	

засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх;	Тийм		
	4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх;	Тийм		
	4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх;		Үгүй	
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1. Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	5.3. Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх;		Үгүй	
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх;		Үгүй	
	6.2. Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	6.3. Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	6.4. Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	6.5. Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх;		Үгүй	
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх;	Тийм		
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
8. Соёл	8.1. Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	8.2. Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	

	8.3. Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх;		Үгүй	
--	---	--	------	--

5.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: (Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх;	Үгүй	
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх;	Үгүй	
	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх;	Үгүй	
	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх;	Үгүй	
	2.4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх;	Үгүй	
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх;	Үгүй	
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх;	Үгүй	
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх;	Үгүй	
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх;	Үгүй	
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх;	Үгүй	
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх;	Үгүй	
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх;	Үгүй	
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх;	Үгүй	
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх;	Үгүй	
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх;	Үгүй	
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх;	Үгүй	
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх;	Үгүй	
7. Нөхөн сэргээгдэх /нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх;	Үгүй	
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх;	Үгүй	

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, хуулийн этгээдийг олж тогтоон хуульд заасан хариуцлага оногдуулах, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой. Хуулийн этгээд нь эрх зүйн субъектийн хувьд бусад хэргийн оролцогчоос онцлогтой бөгөөд түүнд холбогдох мөрдөн шалгах ажиллагаа субъектийн онцлогт тохирсон байх шаардлагатай.

Монгол Улсын ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дах хэсэгт "оролцогч гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг хэлнэ" гэж хуулийн этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс хэргийн оролцогчийн хувьд ялгамжтай авч үзсэн. Энэ нь дэлхийн Загвар эрүүгийн процессын хууль⁴ болоод хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулдаг улс орнуудын жишигт нийцдэг.

Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Турк, Франц, Испани, Серб зэрэг бусад улс орнуудын хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагын төрлөөс үзэхэд эрүүгийн, захиргааны, холимог хэлбэрийн гэсэн хариуцлага хүлээлгэдэг байна. Эрүүгийн хариуцлагын хэлбэрийн хувьд манайхтай ижил төстэй улс орнуудын эрүүгийн процесс хуулиудаас үзэхэд;

Бүгд Найрамдах Франц Улсын "Эрүүгийн процессын хууль"-ийн хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тусдаа бүлэг болгон зохицуулсан. Франц улсын эрүүгийн процессын хууль (Code de procedure penale⁵) болоод Ялын код (Code pénal⁶)-д зааснаар хөрөнгө царцаах⁷, үйл ажиллагааг түр зогсоох⁸, компанийн дотоод үйл ажиллагааг хянаж хэрэгжүүлэх хэрэг гүйцэтгэгч томилох⁹, компани дээр шүүхийн хяналт хэрэгжүүлэх¹⁰ зэрэг түр арга хэмжээ авахаар хуульчилсан. Эдгээрээс хэрэг бүртгэгч томилох, шүүхийн хяналт хэрэгжүүлэх арга хэмжээний үеэр тухайн шалгагдаж буй эрүүгийн хэрэгтэй шууд хамааралтай үйл ажиллагааг зогсоох/түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсвэл тодорхой санхүүгийн хязгаарлалтууд тавигддаг. Эдгээр арга хэмжээг авахад дараах шаардлагууд тавигдана:

- Шүүхийн зөвшөөрөл авсан байх;
- Хууль ёсны зарчимд нийцсэн буюу зөвхөн хуульд заасан тохиолдолд тус арга хэмжээг авах;
- Тодорхой хүрээнд, тодорхой хугацаатай авагдах (жишээ нь хэрэг гүйцэтгэгч томилогдож байгаа бол 6 сар тутам шүүхээр хянагддаг);
- Хүний эрх, эрхэм чанарт үл халдах;
- Улс дамнасан мөрдөн шалгалтын тохиолдолд гадаад улсын хөрөнгөд онцгой хамгаалалт тогтоох;

⁴ Model Codes for Post-Conflict Criminal Justice | United States Institute of Peace

⁵ [Code of Criminal Procedure - Légifrance](#)

⁶ https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006070719/

⁷ Criminal of Criminal Procedure – 706-103, 706-141

⁸ Code of Penalty – 131-39

⁹ Code of Penalty – 131-39-2

¹⁰ Code of Penalty – 131-46 (Татан буулгах нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл боловч эцсийн шийдвэр гарахаас өмнө шүүхээс урьдчилсан байдлаар хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг түдгэлзүүлэх тохиолдол байдаг)

Түүнчлэн Франц улсын хувьд банкны дансан дах мөнгийг царцаах (saisie pénale spéciale) ажиллагааг хийсэн бол 10 хоногийн дотор шүүхээс тус арга хэмжээг үргэлжлүүлэх эсэхийг шийддэг зохицуулалттай.

Бүгд Найрамдах Серби Улс нь хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагыг тусдаа хуулиар зохицуулдаг бөгөөд хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тусгайлсан хууль буюу “Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын тухай хууль”-ийн 2 дугаар бүлгээр зохицуулагддаг ба дараах онцлог харилцааг агуулсан байна.¹¹

- Шүүхийн харьяаллыг тогтоож өгсөн;
- Урьдчилсан арга хэмжээг зохицуулсан. Үүнд гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хожим нь хураах нь хүндрэлтэй, боломжгүй үед хураах, нэг болон хэд хэдэн бүртгэлтэй үйл ажиллагааг нь хориглох, хуулийн этгээдийг бүртгэлээс хасахтай холбоотой үйлдлийг хориглох гэх мэт арга хэмжээ хамаарах ба үүнийг прокурор санал гаргасны үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ;
- Тусгай процессын талаар тусгасан. Үүнд нөхөн сэргээх, дахин нийгэмшүүлэх арга хэмжээнээс гадна хуулийн этгээдийн тодорхой чиг үүрэг, үйл ажиллагааг нь хязгаарлах гэх мэт хамгаалалтын арга хэмжээг авч болохоор зохицуулсан;¹²

Бүгд Найрамдах Серби Улсын эрүүгийн процесс хуулиас үзэхэд хуулийн этгээдэд холбогдох хөрөнгө хураахтай холбоотой ажиллагаа болон хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлахад тодорхой нөхцөл байдлыг харгалзахаар зохицуулсан байна. Мөн уг ажиллагааг прокурорын санал гаргасны үндсэн дээр шүүх шийдвэрлэхээр тусгажээ.

Эндээс үзвэл хуулийн этгээдийг эрүүгийн хэрэгт шалгаж байх хугацаанд түр арга хэмжээ авах зохицуулалт дэлхийн улс орнуудад янз бүрээр хуульчлагдсан байна. Гагцхүү тухайн арга хэмжээг авах үндэслэл, шаардлага, хугацаа, цаашлаад процедур журмыг дэлгэрэнгүй тусгаж, зайлшгүй шаардлагатай үед бөгөөд шалгаж буй эрүүгийн хэрэгт шууд хамааралтай байдлыг харгалздаг нь харагдаж байна.

ДОЛОО. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН БАЙДАЛ

7.1. Дүгнэлт

ЭХХШТХуульд хуулийн этгээдэд авагдах таслан сэргийлэх арга хэмжээний холбогдох процессын хэм хэмжээг нарийвчлан зохицуулаагүйгээс практикт хэргийн нөхцөл байдлаас үл хамааран тухайн хэргийг хянан шийдвэрлэж байх бүхий л хугацаанд хуулийн этгээдийн үйл ажиллагааг бүрэн түдгэлзүүлэх, банкны данс дах мөнгөний шилжилтийг хязгаарлах тохиолдол гарч байгаагаас гадна процесс тодорхойгүйгээс өсөх эрсдэлтэй байна. Мөрдөн шалгах ажиллагааны хувьд тухайн хэргийн талаар нотолбол зохих байдлыг тогтооход чиглэсэн байх шаардлагад нийцүүлэн хийгдэх бөгөөд тус зорилгоосоо давсан байдлаар хэрэгжих, хугацаагүйгээр бусдын эрхийг хөндөх үндэслэл болж болохгүй.

Гэвч хуульд хуулийн этгээдэд үйл ажиллагааг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаа хийхэд нөхцөл, шалгуур

¹¹ Legaldata.mn О.Энххүслэх Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа “магистрын ажил” 2023

¹² Мөн судалгааны ажил

тодорхой тусгагдаагүйгээс практикт үйлдвэрлэл, үйлчилгээ тасалдах, орлого олох эх үүсвэр бүрэн хаагдах, түргэн муудах бүтээгдэхүүнүүд чанараа алдах зэрэг хүндрэлүүд гарч үүнээс үүдэж нийгэмд бизнесийн эрсдэл, татварын орлого, хөрөнгө оруулалтын орчинд ноцтой сөрөг үр дагавар үзүүлдэг байна.

Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 сарын 13-ны өдрийн 07 дугаартай дүгнэлтээр ЭХХШТХ-ийн 14.1 дугаар зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээний цагдан хорих арга хэмжээ авахаар заасан хуулийн заалтууд нь хэт ерөнхий өргөн хүрээг хамарсан агуулгатайгаас болж хүний Үндсэн хуулиар олгогдсон эрхүүд зөрчигдөж байгаа талаар дүгнэлт гаргасан байна. Тодруулбал Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж төрийн хариуцах гурван үүргийг хуульчилсан байна. Нэгд, "хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх" нь үндсэн эрхийг эдлүүлэхэд шаардлагатай хууль батлах, улсын төсвөөс хуваарилах, мөн үндсэн эрхийг хамгаалах, дэмжих, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зэрэг арга хэмжээ авах төрийн позитив үүрэг юм. Хоёрт, "хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх" нь үндсэн эрхийг хүндэтгэх төрийн уламжлалт негатив үүрэг болон үндсэн эрхийг хамгаалах позитив үүргийг багтаана. Нэг талаас, энэ заалт нь үндсэн эрхийг иргэн бүр эдэлнэ гэж үзэж, эдгээр эрхэд халдахгүй байх үүргийг төрд хүлээлгэдэг. Нөгөө талаас, төрийн байгууллага, албан тушаалтан, эсхүл бусад этгээд (байгууллага, хувь хүн зэрэг)-ээс хүний үндсэн эрхийг зөрчихөөс хамгаалах агуулгатай. ...шүүгдэгчийг цагдан хорих үндэслэлийг хуульд тодорхой заах, цагдан хоригдсон шалтгаан, үндэслэлээ мэдэх болон зохисгүй удаашралгүйгээр шүүлгэх эрхийг эдлүүлэх, цагдан хорьсон шийдвэрт гомдол гаргах болон давтамжтайгаар хянах журмыг тусгах позитив үүргээ төр биелүүлээгүй байх тул энэ зохицуулалт нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэснийг зөрчсөн байна хэмээн дүгнэсэн байна.

Үндсэн хуулийн цэцийн 07 дугаар дүгнэлтэд тусгагдсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаарх "үндэслэлийг хуульд тодорхой заах, зохисгүй удаашралгүйгээр шүүлгэх эрхийг эдлүүлэх, шийдвэрт гомдол гаргах болон давтамжтайгаар хянах журмыг тодорхой болгох" гэсэн дүгнэлт нь хуулийн этгээдэд холбогдуулан авч буй таслан сэргийлэх арга хэмжээ болон мөрдөн шалгах ажиллагааны явцад хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлалт тогтоох ажиллагаанд нэгэн адил хамаарах юм.

Иймд ЭХХШТХ-ийн зохицуулалтын дутагдлыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулах, ялангуяа хуулийн этгээдэд хамаарах процессын хэм хэмжээг тодорхой болгох хуулийн нэмэлтийг оруулах зайлшгүй шаардлагатай байна.

-----o0o-----

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА:

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

- 3.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоосон байдал
- 3.2 “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоосон байдал
- 3.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоосон байдал
- 3.4 “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоосон байдал

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

- 4.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал
- 4.2 “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал
- 4.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал
- 4.4 “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

- 5.1 Үнэлэлт, дүгнэлт
- 5.2 Зөвлөмж

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл (цаашид “Хуулийн төсөл” гэх) нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан Хуулийн төслийн өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулагдсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах зорилгоор Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-д заасны дагуу дараах үе шатаар хийсэн.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ үндсэн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан Хуулийн төслийн зохицуулалт нь уг Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, Хуулийн төслийн зорилгод нийцэх эсэх, зорилгод хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэх, Хуулийн төсөл нь ойлгомжтой, зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг дүгнэж, тэдгээрийн үр дүнд үндэслэн анхаарах асуудлын талаар хууль санаачлагчид зөвлөмж өгөхийг зорьсон болно.

Энэхүү үнэлгээгээр Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн орчин хэрхэн сайжрах боломжтой эсэхийг тодорхойлно.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ Хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, Аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс Хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
5. Зардал;
6. Харилцан уялдаа.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг Хуулийн төсөл нь Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн зорилгод хүрэх байдлыг тодорхойлж чадахуйц заалт, зохицуулалтыг тусгасан эсэхийг тогтоох зорилгоор сонгосон болно.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийг тухайн Хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд практикт хэрэгжих боломж байгаа эсэхийг шалгах аар сонгож авав.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, тодорхой байх, Хуулийн төслийн бичвэр нь нэр томъёо, хэл зүй, найруулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс сонгов.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн нэгж, байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзэв.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төсөл батлагдсанаар зардал бий болох эсэхийг тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов. Энэхүү Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын төсөвт дарамт учрахгүй, иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй, улсын төсөвт шинээр нэмэлт зардал бий болохгүй болно.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, шинээр орсон зүйл, заалтууд нь бусад зүйл, заалттайгаа уялдаж байгаа эсэхийг үнэлэхээр зорьсон болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэ хэсэгт Хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгон авлаа. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуульд нэмэлтээр орж буй голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл заалтын үр нөлөөг судлах болно.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

3.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоосон байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, Хуулийн төслийн

зорилгод Хуулийн төслийн зохицуулалт нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс Хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, Хуулийн төслийн зорилго нь Хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхийг шалгах, Хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалтыг Хуулийн төслийн зорилготой харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахад харгалзах нөхцөл, үндэслэл тодорхой бус байгаа зохицуулалтын дутагдлыг арилгах шаардлагатай байна. Энэхүү зорилгыг харгалзан Хуулийн төслийн зохицуулалт нь Хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь сонголоо.

3.2 “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоосон байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломж байна уу гэдгийг үнэлэх үүднээс хуулийн этгээдийн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой Хуулийн төслийн дараах хэсгийг сонгож авлаа.

26.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэг:

“3. Прокурор нь хуулийн этгээдэд холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ.”

26.1 дүгээр зүйлийн 3.1 дэх хэсэг:

“3.1. Бусдын амь нас эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээдэд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол;”

26.1 дүгээр зүйлийн 3.2 дах хэсэг:

“3.2. Тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэхээр бол;”

26.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.

“4.Хуулийн этгээдэд холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулах нийт хугацаа 6 сараас хэтэрч болохгүй.”

3.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоосон байдал

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэх, түүнчлэн хэрэглэх,

хэрэгжүүлэх субъектүүд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулсан эсэхийг шалгахын тулд Хуулийн төслийг бүхэлд нь сонгон авч баталгаажууллаа.

3.4 “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоосон байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас Хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд бид тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хууль тогтоомжтой нийцтэй байдлыг шалгана.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх, сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 26.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэг, 3.1 дэх заалт, 3.2 дах заалт, 4 дэх хэсэг	Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх, дүн шинжилгээ хийх. Хуулийг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц) байгаа эсэхийг судалж тодорхойлох.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4.	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдааг холбох.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу Хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

4.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү Хуулийн төслийн үзэл баримтлалаас харахад хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь 2015 оны Эрүүгийн хуульд шинээр нэвтэрсэн эрх зүйн ойлголт юм. Үүнтэй холбоотойгоор зохицуулалтын тодорхойгүй байдал бий болж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах зайлшгүй шаардлага үүссэнийг онцлон тэмдэглэсэн байна. Хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг ажиллагааг хэрэгжүүлэхэд харгалзах нөхцөл, хугацааг тодорхой тогтоох замаар хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг бодитой, шударга байдлаар хамгаалах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход энэхүү Хуулийн төслийн зорилго оршиж байна.

Хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэх, тэдгээр нь зорилгыг хангах боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэлэхээр дүн шинжилгээ хийлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг энэ зүйлд заасны дагуу түдгэлзүүлж болно”, “1.Мөрдөгч гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр дараахь ажиллагаа явуулна” гэж заасан боловч, энэхүү таслан сэргийлэх арга хэмжээ болон мөрдөн шалгах ажиллагааг ямар үндэслэлээр, ямар хугацаанд авах талаар тодорхой тусгаагүй байна. Хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь өөрөө хэд хэдэн сөрөг үр дагавартай. Тухайлбал, зарим үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нэгэнт эхлүүлсний дараа зогсоох боломжгүй байдгаас болж үйлдвэрлэл бүрэн зогсон, дахин сэргээгдэхгүй болох, улмаар хүний эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах эрсдэл бий болдог.

Ийм нөхцөлд таслан сэргийлэх арга хэмжээ нь өөрийн зорилго болох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай, саадгүй явуулах үүргээ биелүүлэхийн оронд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буйтай адил нөлөө үзүүлж байна. Өөрөөр хэлбэл, уг арга хэмжээ нь хуулийн этгээдэд шударга бус дарамт болж хэрэгжих нөхцөл үүсэж байна. Энэхүү зохицуулалтын дутагдлыг арилгахаар хуулийн төсөлд дараах байдлаар тусгажээ.

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, зүйл, заалт нэмсүгэй:

1/14.4 дүгээр зүйлийн 6 дах хэсэг:

“6. Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг дараах нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ.”

2/14.4 дүгээр зүйлийн 6.1 дэх заалт:

“6.1. Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, бусад хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах эсэх;”

3/14.4 дүгээр зүйлийн 6.2 дах заалт:

“6.2.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэх эсэх;”

4/14.4 дүгээр зүйлийн 7 дах хэсэг:

“7.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах үндсэн хугацаа 1 сар хүртэл байна.”

5/14.4 дүгээр зүйлийн 8 дах хэсэг:

“8.Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл арилаагүй гэж үзвэл хуулийн этгээдэд авсан тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.”

6/14.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:

“9.Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах нийт хугацаа 6 сараас хэтэрч болохгүй.

7/14.4 дүгээр зүйлийн 10 дах хэсэг:

“10.Мөрдөгч хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах хугацааг сунгах тухай саналаа хугацаа дуусахаас 7-оос доошгүй хоногийн өмнө прокурорт хүргүүлэх ба прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах тухай саналаа даруй шүүхэд хүргүүлнэ.”

8/14.4 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг:

“11.Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах хугацааг сунгах тухай прокурорын саналыг хугацаа дуусахаас 4-өөс доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 14.13 дугаар зүйлд зааснаар хянан хэлэлцэж, тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах, эсхүл сунгахыг татгалзах тухай шийдвэр гаргана.”

Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагаа нь хуулийн этгээдийн үйл ажиллагааны үндсэн нөөц болох хөрөнгийг эргэлтэд оруулах боломжийг хааж, үйл ажиллагаанд нь шууд хязгаарлалт учруулдаг. Энэ төрлийн ажиллагаа нь практикт түгээмэл хэрэглэгддэг боловч, дээр дурдсанчлан хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагаанд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг. Гэсэн хэдий ч хуулийн этгээдэд зориулсан нарийвчилсан, тусгай зохицуулалт хуульд одоогоор байхгүй байна. Хуулийн төсөлд энэхүү ажиллагааг хуулийн этгээдэд холбогдуулан доорх байдлаар оруулсан байна.

9/26.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэг:

“3.Прокурор нь хуулийн этгээдэд холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ.

10/26.1 дүгээр зүйлийн 3.1 дэх хэсэг:

“3.1.Бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, бусад хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах эсэх”

11/26.1 дүгээр зүйлийн 3.2 дэх хэсэг:

“3.2.Тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэх эсэх.”

12/26.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.

“4.Хуулийн этгээдэд холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулах нийт хугацаа 6 сараас хэтэрч болохгүй.”

Хуулийн төслийн зохицуулалтууд нь бүхэлдээ уг төслийн зорилготой уялдан хэрэгжихээр боловсруулагдсан байна. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үүсэж байсан зохицуулалтын хийдлийг арилгаж, эрх зүйн орчныг тодорхой болгоход чиглэсэн ач холбогдолтой.

Хуулийн төсөл батлагдсанаар:

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэг мөр, тодорхой журам тогтож, мөрдөн шалгах ажиллагааг илүү үр нөлөөтэй, шуурхай явуулах боломж бүрдэнэ.
- Хуулийн этгээдэд ногдуулах таслан сэргийлэх арга хэмжээний үндэслэл, хугацаа, хэрэгжүүлэх нөхцөл тодорхой болсноор хэт өргөн тайлбарлах, дур мэдэн хэрэглэх эрсдэл буурна.
- Хуулийн этгээдийн эдийн засгийн үйл ажиллагаа үндэслэлгүйгээр зогсонги байдалд орох, эсвэл хөрөнгийн шилжилт хөдөлгөөний хязгаарлалт зэргээс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд сөрөг үр дагавар учрах эрсдэлээс сэргийлэх боломжтой болно.
- Хамгийн чухал нь хуулийн этгээдийн эрх зүйн байдал илүү бодитой, шударга байдлаар хамгаалагдаж, эрх зүйн зохицуулалт улам боловсронгуй болж, олон улсын жишигт ойртох нөхцөл бүрдэнэ.

Иймд уг хуулийн төсөл нь зөвхөн эрх зүйн орчныг шинэчлэх төдийгүй, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах, шударга ёсыг хангах, цаашлаад бизнесийн тогтвортой байдлыг хадгалах чухал ач холбогдолтой байна.

4.2 “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслөөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт “Прокурор нь хуулийн этгээдэд холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ” хэмээн зохицуулж, 26.1 дүгээр зүйлийн 3.1 болон 3.2 дах хэсгүүдээр эдгээр нөхцөлийг тодорхойлсон.

Мөн 26.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хуулийн этгээдэд холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулах нийт хугацаа 6 сараас хэтэрч болохгүй.” гэж зохицуулсан нь практикт шууд хэрэгжих боломжийг бүрдүүлж, мөрдөн шалгах ажиллагаанд тодорхой хугацааны дээд хязгаар тогтоох замаар хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хамгаалах бодит баталгаа болж байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд хуулийн этгээдийн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаа хийхэд холбогдох процессын хэм хэмжээг нарийвчлан тодорхойлж өгөөгүйгээс шалтгаалан практикт хэргийн нөхцөл байдлаас үл хамааран тухайн хэргийг хянан шийдвэрлэж байх бүхий л хугацаанд хуулийн этгээдийн банкны данс дах мөнгө түгжигдэх тохиолдол цөөнгүй гарч байна. Энэ нь тухайн компанийн үйл ажиллагаанд хүндрэлийг бий болгохоос гадна улсын эдийн засаг, татварын орлогын хувьд ч ноцтой үр дагавар дагуулна.

Иймд хуулийн этгээдийн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааг явуулахдаа эдийн засаг, нийгмийн бодит үр дагаврыг хуульд тодорхой тусгаж, хугацааны зохицуулалтыг оновчтой болгох шаардлагатай. Тодорхой нөхцөл, шалгуур тогтоосноор хуулийн этгээдийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, ашиг, алдагдал, эрсдэлийн хэмжээг бууруулах эерэг үр нөлөө бий болохоор байна.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад төсвийн дарамт учруулахгүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нэмэгдэхгүй. Иймд Хуулийн төслийн зохицуулалт нь практикт шууд хэрэгжих боломжтой төдийгүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэг болно 4 дэх хэсэг нь хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг бодитой, шударга байдлаар хамгаалах эрх зүйн баталгаа болон хэрэгжинэ.

4.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс Хуулийн төслийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгасан болно. Үүнд:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага
--

Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Шаардлага хангасан эсэх
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлагагүй.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Шаардлагагүй.
29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.	Шаардлага хангасан.
29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.	Шаардлагагүй.
29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.	Шаардлага хангасан.

29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

4.4 “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Аргачлалын 4.10-д заасны дагуу Хуулийн төслийн уялдаа холбоог дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх Аргачлалын 4.10-д заасан Хуулийн төслийн уялдаа холбоог тогтооход тавих нийтлэг шаардлага	
Шаардлага	Шаардлага хангасан эсэх
4.10.1.хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм.
4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм.
4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тийм.
4.10.4.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм.
4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй.

4.10.6.хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм.
4.10.7.хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
4.10.8.хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй.
4.10.10.татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй.
4.10.11.тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй.
4.10.12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
4.10.13.хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Уг асуудлыг хөндөөгүй.
4.10.14.хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
4.10.15.хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
4.10.16.хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Уг асуудлыг хөндөөгүй.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.

5.1 Үнэлэлт, дүгнэлт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг чанд баримтлан, шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэлт хийж, зөвлөмж боловсрууллаа

Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төслийн зохицуулалт нь Хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага, үндэслэлтэй уялдсан бөгөөд үзэл баримтлалд тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэх, мөн Хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд зорилгодоо хүрэх байдлын шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэх, хэрэгжүүлэх субъект, байгууллага тодорхой эсэх, мөн тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд эдгээр байгууллагад шаардлагатай боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэхэд практикт хэрэгжих боломжийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж, хоёрдмол утгатай, хүч оруулсан үг хэллэг, ойлголтын зөрүү үүсгэхээр томъёологдсон байдал илрээгүй тул ойлгомжтой байдлын шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр: Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан асуултад тулгуурлан шалгахад харилцан уялдаатай байдлыг хангаж байна.

5.2 Зөвлөмж

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан үзэхэд, шалгуур үзүүлэлтүүдийн хувьд бүгд нийцсэн хэмээн дүгнэгдсэн тул хуулийн төслийг зохих хууль тогтоомжид нийцүүлэн Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэн батлуулах шаардлагатай гэж зөвлөж байна. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлж холбогдох зөвлөмжийг хууль санаачлагчид өгсөн болно.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

*/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төсөл/*

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг баталснаар үүсэх зардлын тооцоог гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу дараах байдлаар үнэлж, тодорхойлно” гэж заасны дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу тооцож үзэхэд;

- Хуулийн төсөл нь иргэн, хуулийн этгээдэд аливаа үүрэг үүсгэх зохицуулалт агуулаагүй бөгөөд шинээр зардал үүсэхгүй болно.
- Төрийн байгууллагын хувьд “харгалзах нөхцөл байдал, хугацаа тогтоосон зохицуулалт нэмэгдэж байгаа нь одоо гүйцэтгэж буй үүрэгтэй нь шууд хамааралтай байх бөгөөд шинээр зардал үүсгэхгүй батлагдсан төсвийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах боломжтой байна.
- Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайланд “хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын төсөвт дарамт учрахгүй, иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй, төрийн байгууллагад төсвийн дарамт учруулахгүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нэмэгдэхгүй. Иймд Хуулийн төслийн зохицуулалт нь практикт шууд хэрэгжих боломжтой байна.” гэж тусгажээ.

Иймд хуулийн төсөл батлагдахад иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй, улсын төсөвт шинээр нэмэлт зардал бий болохгүй болно.

-----oO-----

Parliament

Билэгүүдийг үргэлжлэн үзэх | Өмнөх үзэгдэл | Өмнөх үзэгдэл | Өмнөх үзэгдэл | Өмнөх үзэгдэл | Өмнөх үзэгдэл | Өмнөх үзэгдэл | Өмнөх үзэгдэл | Өмнөх үзэгдэл | Өмнөх үзэгдэл | Өмнөх үзэгдэл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХИЯАН ШИЙДЭГДЭХ ТУХАЙ ХУУЛЬД НӨМӨЛТ ӨРҮҮЛЭХ ТУХАЙ

1 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдэгдэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дөрвөн хэсэг, тусгай заалт нэмэгдүй

1/14.4 дугаар зүйлийн 6 дэх хэсэг:

"1) Шүүх үргэлж эл хэргийн төрөлжсөн хэргийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй тулгаруулах туслах ёстойгоор эрх, хэмжээ, ажил, үүрэг, хариуцаж байгаа хэргийн шийдвэрийг"

2/14.4 дугаар зүйлийн 6.1 дэх заалт:

"6.1. Эрүүгийн эрх зүйлийн хэргийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй тулгаруулах туслах ёстойгоор эрх, хэмжээ, ажил, үүрэг, хариуцаж байгаа хэргийн шийдвэрийг"

3/14.4 дугаар зүйлийн 6.2 дэх заалт:

"6.2. Хуульд эл хэргийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй тулгаруулах туслах ёстойгоор эрх, хэмжээ, ажил, үүрэг, хариуцаж байгаа хэргийн шийдвэрийг"

4/14.4 дугаар зүйлийн 7 дэх хэсэг:

"Эрүүгийн эл хэргийн төрөлжсөн хэргийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй тулгаруулах туслах ёстойгоор эрх, хэмжээ, ажил, үүрэг, хариуцаж байгаа хэргийн шийдвэрийг"

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛОН
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН НЭГТГЭЛ**

Агуулга;

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх төрийн байгууллагаас ирүүлсэн санал болон шийдвэрлэсэн байдал;
2. Хуулийн төслийг олон нийтэд хэлэлцүүлсэн талаар холбогдох материал;
3. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд D.parliament.mn байршуулж санал авсан байдал;

Нэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлтэй холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3 дах хэсгүүдэд заасны дагуу хуулийн Засгийн газар болон хуулийн төслийг хэрэгжүүлэх төрийн байгууллагаас ирүүлсэн санал болон шийдвэрлэсэн байдал;

Д/д	Санал ирүүлсэн байгууллага	Ирүүлсэн санал	Саналын шийдвэрлэсэн байдал
1	Монгол Улсын Засгийн газар 2025.12.26 ХЭГ/3665	1. Хуулийн төслийн 1-р зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэхдээ харгалзан үзэх нөхцөл байдлыг хэт ерөнхий байдлаар тусгасан нь хууль хэрэглээний хувьд ойлгомжгүй байдлыг үүсгэх эрсдэлтэй. Тухайлбал, хуулийн төсөлд тусгасан “ноцтой хохирол”, “илт хохирол учруулах” гэх зэрэг ойлголтыг хэрхэн ойлгож хэрэглэх, тухайн эрсдэл нь бодитой эсэхийг ямар шалгуураар тогтоох зэрэг нь тодорхойгүй байна. Иймд хуулийн төсөлд илүү тодорхой, бодит шалгуур, нөхцөлийг нарийвчлан тусгах шаардлагатай.	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт хэрэглэсэн “ноцтой хохирол”, “илт хохирол учруулах” зэрэг ойлголт нь Монгол Улсын процессын эрх зүйн тогтолцоонд шинэ, тодорхойгүй ойлголт биш бөгөөд 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль зэрэг бусад процессын хуулиудад тусгагдаж, хэрэглэгдэж ирсэн эрх зүйн ойлголт юм. Тухайлбал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62.1-р зүйлд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөлийг тодорхойлж 62.1.1-т захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхийг хориглохоор хуульчилсан байдаг.

Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн 2023 оны 4 сарын 14-ний өдрийн хуралдааны №18 дугаар тогтоолд “ноцтой хохирол” гэдгийг “захиргааны актыг түдгэлзүүлснээр хэргийн оролцогч иргэний хувьд болон маргаан бүхий актын үйлчлэл шууд хандаж буй бусад иргэний амь нас нь эрсдэлд орох, эрүүл мэнд нь доройтох, эд хөрөнгө нь зориулалтын дагуу ашиглах боломжгүй болох, тухайн этгээд түүнийг өөрийн хүчээр эргүүлэн сэргээх боломжгүй, эсхүл сэргээсэн ч өмнөх байдлаасаа чанар байдлын хувьд дордохоор сөрөг үр дагавар үүсэхийг ойлгоно.” гэж, “илт хохирол” гэдгийг “хэргийн оролцогч хуулийн этгээдийн мөнгө болон мөнгөөр үнэлэгдэхүйц баялаг, эд хөрөнгөөр хэмжигдэх эрх, болон хөрөнгө, мөнгөөр хэмжигдэхгүй эдийн бус эрхэд их хэмжээний алдагдал бий болох нь илэрхий, тодорхой, нотлогдохуйц байхыг; эсхүл нийтийн ашиг сонирхлыг эргэж сэргээх боломжгүйгээр хохироохуйц сөрөг үр дагавар учрах нь бодитой, нотлох шаардлагагүй байхыг тус тус ойлгоно.” гэж тайлбарласан байна.

Дээрх тайлбар нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай холбоотой хэдий ч “ноцтой хохирол”, “илт хохирол учруулах” гэх ойлголтын агуулга, шалгуурыг тодорхойлсон шүүхийн тогтсон практик гэж үзэх үндэслэлтэй. Монгол Улсын Дээд шүүхийн практикт эдгээр ойлголтыг хийсвэр байдлаар бус, тухайн хэргийн нөхцөл байдал, нотлох баримтын хүрээнд шүүхийн үнэлгээ хийх замаар тодорхойлж ирсэн. Өөрөөр хэлбэл, “ноцтой” болон “илт” хохирол нь заавал тоон хэмжигдэхүүнээр илэрхийлэгдэх бус харин учрах эрсдэлийн бодит байдал, хохирлын шинж чанар, цар хүрээ, эргэлт буцалтгүй үр дагавар үүсэх эсэх, гуравдагч этгээд болон нийтийн ашиг сонирхолд үзүүлэх нөлөө зэрэг шалгуурыг цогцоор нь үнэлэх замаар тогтоогддог ойлголт болохыг шүүхийн практик харуулж байна.

<p>Иймд эдгээр ойлголтыг хуулийн төсөлд хэт нарийвчилсан, хатуу тоон шалгуураар тодорхойлох нь шүүхийн эрх мэдлийн хүрээнд хийгдэх ёстой үнэлгээний уян хатан байдлыг алдагдуулах, хэрэг бүрийн онцлогийг харгалзан үзэх боломжийг хязгаарлах эрсдэлтэй. Харин хуулийн төслөөр тусгасан зохицуулалт нь бусад процессын хууль тогтоомжтой уялдсан, шүүхийн тогтсон практик, тайлбарт нийцсэн байдлаар хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Дээрх агуулгын хүрээнд хуулийн төслийн 1-р зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалт нь хууль хэрэглээний хувьд ойлгомжгүй байдал үүсгэхээргүй бөгөөд харин Монгол Улсын процессын хууль тогтоомжийн нийтлэг ойлголт, шүүхийн тогтсон практикт нийцсэн зохицуулалт гэж үзэж байна.</p>	<p>Таслан сэргийлэх арга хэмжээ нь эрүүгийн процессын онолд "сэжигтэн, яллагдагч нь мөрдөн шалгах, шүүхийн ажиллагаанаас зайлсхийх, дахин гэмт хэрэг үйлдэх, нотлох баримтыг устгах, хуулийн үйл явцад саад учруулахыг урьдчилан сэргийлэх" зорилготой. Гэтэл холбогдох процессын хэм хэмжээг нарийвчлан тодорхойлж өгөөгүйгээс практикт хэргийн нөхцөл байдлаас үл хамааран тухайн хэргийг хянан шийдвэрлэж байх бүхий л хугацаанд хуулийн этгээдийн үйл ажиллагааг бүрэн түдгэлзүүлэх эрсдэлтэй. Мөрдөн шалгах ажиллагааны хувьд тухайн хэргийн талаар нотолбол зохих байдлыг тогтооход чиглэсэн байх ёстой болохоос тус зорилгоосоо давсан байдлаар хэрэгжих, хугацаагүйгээр бусдын эрхийг хөндөх үндэслэл болж болохгүй. Таслан сэргийлэх арга хэмжээнд хугацааны дээд хязгаар тогтоох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах бус, харин уг арга хэмжээ нь тухайн мөрдөн шалгах ажиллагааны зорилгод нийцэж байгаа эсэхийг тогтмол хянуулах, шаардлагагүйгээр сунжрах, хэргийг шийдтэл үргэлжлэх байдлаар хэрэгжих эрсдэлийг</p>
<p>2. Хуулийн төслийн 1-р зүйлийн 4, 5, 6 дахь хэсэгт хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах хугацааг тусгасан боловч зохицуулалтыг тусгах болсон хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага, олон улсын сайн туршлага хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад хангалттай тусгагдаагүй, тодорхой бус байна. Хуулийн этгээдийн холбогдсон хэргийн нөхцөл байдал, цар хүрээнээс хамааран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа 6 сарын хугацаанд бүрэн шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдлыг анхаарч үзэх шаардлагатай. Тухайлбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдэх, хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас ноцтой хор хохирол учирч болзошгүй нөхцөл байдал үргэлжлэх боломжтой бөгөөд хэргийн онцлогоос хамааран шинжээчээр дүгнэлт гаргуулах, дүгнэлт авах зэрэг ажиллагаанд хугацаа шаардагддаг тул мөрдөн шалгах ажиллагаа удаашрах бодит нөхцөлийг үүсгэдэг. ЭХХШТХ-ийн 14.13-р зүйлийн 1-т заасны дагуу</p>	<p>Таслан сэргийлэх арга хэмжээ нь эрүүгийн процессын онолд "сэжигтэн, яллагдагч нь мөрдөн шалгах, шүүхийн ажиллагаанаас зайлсхийх, дахин гэмт хэрэг үйлдэх, нотлох баримтыг устгах, хуулийн үйл явцад саад учруулахыг урьдчилан сэргийлэх" зорилготой. Гэтэл холбогдох процессын хэм хэмжээг нарийвчлан тодорхойлж өгөөгүйгээс практикт хэргийн нөхцөл байдлаас үл хамааран тухайн хэргийг хянан шийдвэрлэж байх бүхий л хугацаанд хуулийн этгээдийн үйл ажиллагааг бүрэн түдгэлзүүлэх эрсдэлтэй. Мөрдөн шалгах ажиллагааны хувьд тухайн хэргийн талаар нотолбол зохих байдлыг тогтооход чиглэсэн байх ёстой болохоос тус зорилгоосоо давсан байдлаар хэрэгжих, хугацаагүйгээр бусдын эрхийг хөндөх үндэслэл болж болохгүй. Таслан сэргийлэх арга хэмжээнд хугацааны дээд хязгаар тогтоох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах бус, харин уг арга хэмжээ нь тухайн мөрдөн шалгах ажиллагааны зорилгод нийцэж байгаа эсэхийг тогтмол хянуулах, шаардлагагүйгээр сунжрах, хэргийг шийдтэл үргэлжлэх байдлаар хэрэгжих эрсдэлийг</p>

	<p>таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх, хүчингүй болгуулах тухай хүсэлтийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд гаргах боломжтой. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн шуурхай явагдах нөхцөлийг хангах, бодитойгоор саад учруулж байгаа, эсхүл саад учруулж болзошгүй үйлдлийг гаргуулахгүй байх, хэргийн бодит байдлыг тал бүрээс нь бодитой тогтоох зорилгын хүрээнд хуулийн төслийн 1-р зүйлийн 4, 5, 6 дахь хэсгийг хасах.</p>	<p>хязгаарлахад чиглэсэн зохицуулалт болно. Өөрөөр хэлбэл, таслан сэргийлэх арга хэмжээ нь “хэргийг шийдтэл” бус, харин тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулах хугацаанд хэрэгжих ёстой бөгөөд энэ зарчмыг бодитоор хэрэгжүүлэхэд хугацааны зохицуулалт зайлшгүй шаардлагатай.</p>
	<p>3. Хуулийн төслийн 1-р зүйлийн 9, 10, 11, 12 дахь хэсэгт ЭХХШТХ-ийн 26.1-р зүйлд заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа харгалзах нөхцөл байдал, мөн тус ажиллагааны нийт хугацаа 6 сар хүртэл байхаар тус тус тусгажээ. Хуульд зааснаар тус мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тухайн хөрөнгө нь гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон, эсхүл хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байх урьдчилсан нөхцөл заавал хангасан байх шаардлагатай. Харин тус мөрдөн шалгах ажиллагааны улмаас хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн, хөндөгдсөн, мөн хуулийн төсөлд тусгагдсан нөхцөл байдал үүссэн тохиолдолд ЭХХШТХ-ийн 15-р бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу хүсэлт, гомдол гаргах замаар хязгаарлалтыг цуцлах асуудлыг шийдвэрлүүлэх боломжтой. Иймд хэрэг хянан шийдвэрлэх</p>	<p>Хугацаатай холбоотой саналыг хүлээн авч төслийн 1 зүйлийн 12 дугаар хэсгийг хассан.</p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16.14 дэх хэсэгт тодорхойлсноор Монгол Улсын иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаатай эдлэхээр заасан. Шударга шүүхээр шүүлгэх эрхийн үндэс нь процессын шударга ёс бөгөөд процессын хэм хэмжээ нь хуульд үндэслэсэн, бүрэн, тодорхой бөгөөд хоёрдмол агуулгагүй байх нь тус зарчмыг хангах суурь нь юм. Процессын тодорхой байдлыг хангах нь Монгол Улсын Үндсэн хууль болоод Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарчимд бүрнээ нийцэх ба хэм хэмжээний бус байдлаар иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахаас урьдчилан сэргийлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн биелэлтийг хангах суурь болно.</p>

		<p>ажиллагааны зорилтыг хангах, хэргийн бодит байдлыг тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээний үндэслэл арилах хүртэл хугацаанд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах шаардлагатай тул хуулийн төслийн 1-р зүйлийн 9, 10, 11, 12 дахь хэсгийг бүхэлд нь хасах.</p> <p>4. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28-р зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэрт тавигдах шаардлагыг хангах шаардлагатай.</p>	<p>Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 28-р зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэрт тавигдах шаардлагыг баримталсан болно. Тухайлбал, хуулийн төслийн гарчиг, зүйл, зүйлийн доторх хэсэг, заалт, дэд заалтын дугаарлалт, агуулгын дараалал нь тус хуулийн 28.1-28.10-д заасан бүтэц, хэлбэрийн шаардлагад нийцсэн бөгөөд нэмэлт оруулах зохицуулалтыг 28.8-д заасан дарааллын дагуу нэг зүйлд нэгтгэн тусгасан. Мөн шинээр нэмэгдэж буй зохицуулалтууд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалттай салшгүй утга агуулгатай тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.9, 28.10-д нийцүүлэн дугаарлалт, найруулгын хувьд анхдагч эх бичвэртэй уялдуулсан байдлаар боловсруулагдсан.</p> <p>Санал тодорхойгүй байна.</p>
2	<p>Монгол Улсын Ерөнхий прокурорын газар 2025.12.03 02/5249</p>	<p>1. Хуулийн төслийн 1-р зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхэд харгалзан үзэх нөхцөл байдлыг нарийвчлан тодорхойлж томъёолох. (Засгийн газраас ирүүлсэн саналтай ижил)</p> <p>2. Хуулийн төслийн 1-р зүйлийн 4, 5, 6, 7, 8 дахь хэсэгт таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа заасан зохицуулалтад өөрчлөлт оруулж, үндэслэл, үр дагавар, арилсан тохиолдолд таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгохоор томъёолох нь зүйтэй. (Засгийн газраас ирүүлсэн саналтай ижил)</p>	<p>1 дэх хэсгийн тайлбараас харах</p> <p>1 дэх хэсгийн тайлбараас харах</p>

		<p>3. Хуулийн төслийн 1-р зүйлийн 9, 10, 11, 12 дахь хэсгийг бүхэлд нь хасах. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах, хэргийн бодит байдлыг тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээний үндэслэл арилах хүртэл хугацаанд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах шаардлагатай тул уг заалтыг бүхэлд нь хасах. (Засгийн газраас ирүүлсэн саналтай ижил)</p>	<p>Хугацаатай холбоотой саналыг хүлээн авч төслийн 1 зүйлийн 12 дугаар хэсгийг хассан.</p>
<p>3</p>	<p>Цагдаагийн ерөнхий газар 2025.11.20 01/1510</p>	<p>1. Хуулийн төслийн 1-р зүйлийн 2 дахь хэсгийн “14.4 дүгээр зүйлийн 6.1 дэх заалт”-ын “Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь бусдын” гэснийг “Хүний” гэж өөрчлөх.</p>	<p>Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 28-р зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэрт тавигдах шаардлагыг баримталсан бөгөөд зохицуулалтууд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалттай салшгүй холбоотой, найруулгын хувьд анхдагч эх бичвэртэй уялдуулсан байдлаар боловсруулагдсан.</p> <p>“Бусдын” гэснийг “Хүний” гэж өөрчлөх санал нь хуулийн төслийн зохицуулалтын хамрах хүрээг хэт явцуу болгох эрсдэлтэй байна. Учир нь тухайн таслан сэргийлэх арга хэмжээ нь зөвхөн хувь хүний төдийгүй хуулийн этгээд, нийтийн ашиг сонирхолд учирч болзошгүй хохирлыг хамтад нь харгалзан үзэх зорилготой. Иймд “бусдын” гэх ойлголт нь зохицуулалтын зорилгод нийцэж байгаа тул уг саналыг хүлээн авах боломжгүй гэж үзэв.</p> <p>Энэ хэсэгт хууль ёсны үйлдвэрлэл, үйлчилгээ гэж нэмсэн.</p> <p>Хуулийн этгээдийн” гэх үгийг хасах, мөн “эзэмшигчийн амьжиргаанд шууд нөлөөлөх” гэх агуулгыг нэмэх санал нь хуулийн этгээдэд чиглэсэн таслан сэргийлэх арга хэмжээний эрх зүйн мөн чанарыг хувь хүний амьжиргаатай шууд холбож, зохицуулалтын хүрээг тодорхой бус болгох эрсдэлтэй. Хуулийн төсөл нь хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөг үнэлэхэд чиглэсэн тул хувь хүний амьжиргааны асуудлыг энэ хүрээнд оруулах нь оновчгүй гэж үзэж байна.</p>
		<p>2. Хуулийн төслийн 1-р зүйлийн 3 дахь хэсгийн “14.4 дүгээр зүйлийн 6.2 дахь заалт” -ын “Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь тухайн хуулийн этгээдийн” гэснийг хасах, “эх үүсвэрийг хаах”, гэсний дараа “эзэмшигчийн амьжиргаанд шууд нөлөөлөх”, гэж нэмэх.</p>	

	<p>3. Хуулийн төслийн 1-р зүйлийн 6 дахь хэсгийн “14.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг”-ийн “6 сараас” гэснийг “18 сараас” гэж өөрчлөх. ЭХХШТХ-д заасан цагдан хорих нийт хугацаатай нийцүүлэх нь зүйтэй.</p>	<p>Таслан сэргийлэх арга хэмжээ авах нийт хугацааг “18 сар” болгон сунгах санал нь хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хэт удаан хугацаанд хязгаарлалт тогтоох боломжийг бүрдүүлж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгоос давсан, эдийн засаг, нийгмийн сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй. Олон улсад хүлээн зөвшөөрөгддөг Allianz Risk Barometer – Бизнесийн томоохон эрсдэлийг тодорхойлох нь 2025 тайланд бизнесийн тасалдал нь бизнесийн эрсдэлүүдийн 2 дугаарт бичигдсэн. Бизнесүүдийн хувьд үйл ажиллагаа түр зогсох, доголдол, тасалдал үүсэх зэрэг тохиолдолд жижиг бизнесүүд санхүүгийн дарамт, эрэлт буурах зэрэг хамгийн хурдан буюу дунджаар 1-3 сарын дотор хямралд ордог бол дунд, том байгууллагуудын хувьд 3-6 сарын дотор санхүү, үйл ажиллагааны стресс мэдрэгдэж, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн удирдлага зэргээсээ хамааран хаалгаа барих хүртэл эрсдэлд ордог талаарх судалгаанууд бий. (Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан)</p> <p>Иймд таслан сэргийлэх арга хэмжээг 18 сар хүртэл хугацаагаар үргэлжлүүлэх нь хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг хэт удаан хугацаанд хязгаарлах, улмаар эдийн засаг, нийгэмд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй юм.</p>
	<p>4. Хуулийн төслийн 1-р зүйлийн 9 дэх хэсгийн “26.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэг”-ийн “хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах” гэсний дараа “арилжааны банкинд эзэмшдэг, хамтран эзэмшдэг, дансыг хязгаарлах” гэж нэмэх.</p>	<p>Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26 дугаар бүлэгт заасан мөрдөн шалгах бусад ажиллагаанд хамаарах бөгөөд уг ажиллагааны зорилго нь гэмт хэргийн талаарх нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэхэд оршдог. Өөрөөр хэлбэл, уг ажиллагаа нь таслан сэргийлэх арга хэмжээ биш бөгөөд зөвхөн хуульд заасан урьдчилсан нөхцөл бүрдсэн тохиолдолд, тодорхой хүрээнд, зайлшгүй шаардлагын хэмжээнд хэрэгжих ёстой процессын ажиллагаа юм.</p>

		<p>Хуульд зааснаар хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тухайн хөрөнгө нь гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон, эсхүл хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байх урьдчилсан нөхцөл заавал хангасан байх шаардлагатай. Гэтэл практикт эдгээр шаардлагыг ялган тодорхойлохгүйгээр, гэмт хэрэгтэй шууд холбоогүй тохиолдолд ч хуулийн этгээдийн арилжааны банк дахь дансыг бүхэлд нь, удаан хугацаагаар хаах, хязгаарлах байдлаар хэрэгжүүлж, уг мөрдөн шалгах ажиллагааг бодит байдал дээр шийтгэлийн шинжтэй арга хэмжээ болгон ашиглах явдал гардаг.</p> <p>Ийм нөхцөлд “арилжааны банкинд эзэмшдэг, хамтран эзэмшдэг дансыг хязгаарлах” гэсэн агуулгыг хуулийн төсөлд нэмэх нь мөрдөн шалгах ажиллагааны хамрах хүрээг хэт өргөжүүлж, гэмт хэрэгтэй шууд хамааралгүй хөрөнгө, дансанд хүртэл удаан хугацааны хязгаарлалт тогтоох хууль зүйн үндэслэл болж болзошгүй. Энэ нь бизнесийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, ажил эрхлэлт буурах, татварын орлого тасалдах, хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлөх зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгоос давсан, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг үүсгэх эрсдэлтэй.</p> <p>Хуулийн төслийн зохицуулалтууд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалттай салшгүй холбоотой, найруулгын хувьд анхдагч эх бичвэртэй уялдуулсан байдлаар боловсруулагдсан. “Бусдын” гэснийг “Хүний” гэж өөрчлөх санал нь дээр дурдсанчлан зохицуулалтын хамрах хүрээг явцуу болгох бөгөөд нийтийн болон хуулийн этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах боломжийг хязгаарлана.</p>
	<p>5. Хуулийн төслийн 1-р зүйлийн 10 дах хэсгийн “26.1 дүгээр зүйлийн 3.1 дэх заалт”-ын “Бусдын” гэснийг “Хүнийг” гэж өөрчлөх.</p>	
	<p>6. Хуулийн төслийн 1-р зүйлийн 11 дэх хэсгийн “26.1 дүгээр зүйлийн 3.2 дахь заалт”-ын “эх</p>	<p>Хуулийн этгээд нь бие даасан эрх зүйн субъект бөгөөд түүний үйл ажиллагаанд авч буй таслан сэргийлэх болон мөрдөн шалгах ажиллагааны үр</p>

	<p>үүсвэрийг хаах,” гэсний дараа “эзэмшигчийн амьжиргаанд шууд нөлөөлөх,” гэж нэмэх.</p> <p>7. Хуулийн төслийн 1-р зүйлийн 12 дахь хэсгийн “26.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг”-ийн “6 сараас” гэснийг “18 сараас” гэж өөрчлөх.</p> <p>8. Хуулийн төсөлд хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг хугацаатай хэрэгжүүлэх талаарх ойлголтыг тус хуульд заасан яллагагч, шүүгдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээнүүдийн төрлүүдэд хэрэглэх зохицуулалтыг нэмэлтээр тусгах нь зүйтэй байна.</p>	<p>дагаврыг үнэлэхдээ хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүүгийн тогтвортой байдал зэрэг объектив шалгуурт үндэслэх нь зүйтэй.</p> <p style="text-align: center;">Энэ зүйлийг хассан.</p> <p>Хуулийн төслийн үзэл баримтлал нь хуулийн этгээдэд холбогдох таслан сэргийлэх болон хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааны процесстой холбогдох бөгөөд яллагдагч, шүүгдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээнүүдийн зохицуулалттай адилтган хэрэглэх нь субъектийн онцлогт тохирохгүй.</p>
<p>4</p> <p>Авилгатай тэмцэх газар 2025.11.18 01/19569</p>	<p>Хуулийн төслийг бүхэлд нь дэмжих боломжгүй гэж хариу ирүүлсэн.</p>	<p>Хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалттай холбогдох үндэслэл бүхий санал, тайлбарыг ирүүлээгүй гэж үзэж байна.</p>

Хоёр. Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын танхимд Монголын Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Хүний эрхийн үндэсний комисс, хуулийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага, судлаач, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан хийсэн болно. Оролцогчид хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжсэн бөгөөд сайжруулах талаар санал гаргасан болно. Мөн хуулийн төслийг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр МҮХАҮТ-ын удирдах зөвлөл, хувийн хэвшлийн төлөөллийн байгууллагуудад танилцуулсан бөгөөд дэмжсэн болно.

Хурлын тэмдэглэл Хавсралт 1.

Гурав. Хуулийн төслийг D.parliament.mn цахим сүлжээнд 2026 ны 01 дүгээр сарын 21-ний өдөр байршуулж санал хүлээн авах ажлыг зохион байгуулсан бөгөөд санал ирээгүй болно.

Холбогдох баримт Хавсралт 2.

**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай
хуулийн төслийн хэлэлцүүлэг /2026.03.12/**

УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин: Манай ажлын албанаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бэлдсэн байгаа. Энэ хуулийн төслийн талаар саналаа танилцуулна. Мөн байгууллагуудаас манайх санал авсан. 2016 оноос өмнө хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулдаггүй байсан бол 2015 оны Эрүүгийн тухай хуульд энэ зүйл маань хуульчлагдаж 2017 оноос процессын тухай хууль нь батлагдаж, хуулийн этгээдийн гэм бурууг тогтоох, эрүүгийн хариуцлага оногдуулах харилцаа маань хуульчлагдсан. Гэсэн хэдий ч өнгөрсөн хугацаанд хэрэглэж байгаа процессыг харвал сайжруулах зүйл нэлээн харагдаж байна. Тухайлбал компаниудын дансыг нь хаачаад үйл ажиллагааг нь түдгэлзүүлчхээд буцаад хэзээ сэргээх нь тодорхойгүй байдалтай үлдчихдэг энэ байдлаас болоод аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд доголдол учирдаг ба зарим нь дампуурах хэмжээнд очдог. Иргэн бол тодорхой хэмжээнд хариуцлага хүлээчхээд сүүлийн субъект болоод өндөрлөдөг бол хуулийн этгээд нэлээн төвөгтэй нийлмэл харилцаанд ордог. Жишээлбэл ажилчид цалин авах, бэлтгэн нийлүүлэгчид төлбөр тооцооны асуудал, банк санхүүгийн байгууллагаас зээл авсан, татвар тооцоотой холбоотой гэх мэт нэлээн нийлмэл харилцаануудад ордог учраас тухайн харилцааг тодорхой болгож өгөхгүй бол буцаад энэ аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа дам дамаар өөр этгээдүүд хариуцлага хүлээх мөн дампуурах нөхцөл байдалд хүрэх асуудал үүсэж байна. Иймд энэхүү харилцааг илүү процессжуулах гэсэн гол агуулгатай. Мөн хуулийн этгээдтэй холбоотой харилцааг тодорхой болгосноор илүү хурдан шийдэгдэнэ гэж үзэж байгаа. Энэ хуулийн хариуцлагын хэсгийг харвал 34 хариуцлагын арга хэмжээ байна. Үүний 32 нь хөнгөн шинжтэй торгох, эрх хасах хариуцлагууд байдаг. Иймээс энэхүү харилцааг тодорхой болговол эдийн засгийн хурдад тустай гэж бодож байна.

Танилцуулга:

УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин: Аж ахуйн шинжтэй харилцаа маань эдийн засгийн гол суурь байгаа учраас хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, гэм буруутайг нь нотолж байгаа процессуудыг сайжруулах орон зай байна гэж харж байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой 12 зүйлтэй хуулийн төсөл санаачилсан. Энэхүү хэлэлцүүлэгт хуулийн төсөлд санал авсан байгууллагуудын төлөөллүүд, өмгөөлөгч нар, аж ахуйн нэгжийн төлөөллүүд, хүний эрхийн үндэсний комиссын гэх мэт төлөөллүүд оролцож байна. Хуулийн төсөлтэй холбоотой саналаа идэвхтэй хуваалцаарай гэж хүсэж байна.

Монголын Олон Улсын арбитрын арбитрч Хонгор: Миний хувьд бол арбитраар маш их хэмжээний арилжааны маргаантай асуудлаар улс хоорондын болон дотоодын аж ахуйн нэгжүүд маргаанаа шийдвэрлүүлдэг. Ер нь бол олон улсын практик нь арилжааны маргаан бол олон улсад тогтсон 100 гаруй жилийн түүхтэй нэгдсэн платформ байдаг. Энэ нь НҮБ-ын холбогдох конвенцод бүх улс орон нэгдэн орж хүлээн зөвшөөрсөн. Манай улсын хувьд бизнес хийх нь эрсдэл байдаг. Эрсдэл гаргахдаа зарим аж ахуйн нэгжүүд өөрсдөө мэдэлгүй эрсдэлд орж эрүүгийн хариуцлага хүлээдэг. Энийг бол бизнесийн эрсдэл гэнэ. Манай улсын

Эрүүгийн хууль бол улсын эдийн засгийн дэмжсэн , баялаг бүтээхэд зориулагдсан, аж ахуйн нэгжүүдэд ээлтэй хууль бол биш гэдэг нь өнгөрсөн олон жишээнүүдэд харагддаг. Өнөөдөр бид хэд бизнесийн үйл ажиллагаанд саад болж байгаа хор хөнөөлтэй, цаг хугацаагаар хэмжигддэг байтал дандаа асуудлыг хойшлуулдаг хүнд суртлын ээлтэй бус зохицуулалтыг таягдан авч хаяж дэвшил авчрах нь зүйтэй. Би хуулийн төсөлтэй өчигдөр танилцлаа. Хуулийн төслийг сайжруулж боловсруулах шаардлагатай харагдаж байна. Үүнтэй холбоотой санал болон асуулт асууя.

1. Хууль бол иргэндээ үйлчилдэг байх ёстой гэж би ойлгодог. Тэгээд хуулийн төслийн танилцуулга дээр гадаадад ийм хууль үйлчилдэг гээд санааг нь хуулбарлаж авах гэж байгаа юм шиг хандлага байна. Гадаадын сайн практикийг судлаад авах нь зүйтэй байх гэхдээ бид нар өөрсдөө дэлхий дээр байхгүй шинэ зохицуулалтыг тусгах нь болохгүй гэсэн зүйл байхгүй. Тиймээс өөрсдөдөө тохирсон зохицуулалт хийж зоримог байгаарай гэж хэлмээр байна. Энэ хуулийн төсөлд иргэнийг орхигдуулсан байгаа ба хуулийн этгээдийг онцгойлон авч үзсэн байна. Үндсэн хуульд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн байгууллага нь нэг статустай байдаг. Үүнийг анзаараарай. Хиймэл оюун ухаан гээд дэлхий ертөнц өөр болж байна. Манайд явцуу аж ахуйн нэгжүүд л бизнес хийх ёстой юм шиг төсөөлөл байгаад байна. Одоо хиймэл оюун ухааны хүч чадлаар бол иргэн Дорж хуулийн этгээдээс илүү үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж нь бүрэлдэж байна. Иймээс иргэн гэдгийг оруулж болдоггүй юм уу? Үүнийг харгалзаж үзсэн үү? гэдэг асуулт байна.
2. Нэр томьёотой 6.1-тэй холбоотой асуулт асууя. Захиргааны хуулиас санаа аваад нийтийн ашиг сонирхол гэдэг зүйлийг дурдсан байна. Миний хувьд бол нийтийн эрх ашиг, ашиг сонирхол гэдэг хуулийн тодорхойлолт бүхий заалтыг оруулбал зүйтэй юм шиг санагдаж байна. Яагаад гэвэл эрх ашиг, ашиг сонирхлын эрэмбийн ялгааг юу гэж ойлгож байгаа вэ?
3. Хохирол бол тодорхой үйлдлээс үүдэлтэй үр дагаварт үүсдэг нөхцөл байдал нөгөө талаас нийтийн гэдэг асуудлыг хөндөж байгаа бол нийтийн эрх ашиг, ашиг сонирхолд аюул занал гэдэг ойлголтыг оруулах хэрэгтэй. Хохирол гэдэг бол хохирол үүсээгүй байхад хохирол үүссэн хойно чамд хариуцлага тооцно гэдэг нь хоцрогдонгүй хандлага гэж харагдаж байна. Энэ хуулийн санаа нь нийгмийн аюул, занал зайлшгүй оруулах ёстой байх. Хамрах хүрээг нь өргөн болгож нийгмийн нийтийн өнцгөөс харах хэрэгтэй. Цаг хугацаа бол яах вэ олонхын саналаар тогтох байх.
4. Салбар салбарууд их өөр байдаг. Ялангуяа санхүүгийн IPO компанийн үйл ажиллагааг нь зогсооно гэдэг бол жоомоо алах гэж байгаад байшингаа шатаана гэдэг шиг нөхцөл үүсэж магадгүй байна. Ийм эрсдэлийг харгалзаж үзсэн үү? салбар салбараар энэ хууль яаж үйлчлэх вэ, эрүүл мэндийн салбар, санхүүгийн салбар, дэд бүтцийн салбарын хуулийн этгээд гэх зэрэг ирээдүйд энэ хууль батлагдвал ямар болзошгүй нөхцөл байдал үүсэх вэ? Сценаруудыг нь сайн, муу, дунд гэж гаргаж судалж үзсэн үү?

УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин: Баярлалаа. Таны иргэнтэй холбоотой заалтуудыг бага хөндсөн байна гэдэгт энэ санаачилсан хуулийн төсөл маань илүү хуулийн этгээдэд чиглэсэн иргэнтэй холбоотой харилцааг ЭХХШТХ-д маань хуулийн этгээдийг бодвол илүү тодорхой тусгасан байдаг. Тэгэхээр энэ түвшинд

хуулийн этгээдэд холбогдох хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой болгох агуулгатай өөрчлөлтүүд байгаа. Тэгэхээр тодорхой хэмжээнд зохицуулалт байгаа учраас тэр асуудлыг хөндөөгүй сайжруулах зүйл байна гэвэл тусдаа өөр байдлаар үзэл баримтлалаар өөрчлөх боломжтой. Гэхдээ энэ хуулийн төсөл дээр бол илүү хуулийн этгээдийн дутуу зохицуулалтыг зохицуулах шаардлагатай учраас энэ хуулийн төслийг бэлдсэн байгаа. Бусад асуултууд дээр Батбаяр хуульч хариулна.

Батбаяр хуульч: Сайн байцаана уу? Нийтийн эрх ашигт илт хохирол гэдэг дээр энэ бол Эрүүгийн процессын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар бид нар ярьж байгаа. Тэгэхээр иргэн, захиргааны процесс, арбитра хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа хувийн эрх зүй байгаа. Тиймээс зохицуулалт нь тусдаа байдаг. Эрүүгийн процесс дээр бол энийг хориглосон байдлаар зохицуулалт ороогүй ба орох боломжгүй. Гэмт хэрэг шалгаж байгаа тохиолдолд дараах арга хэмжээнүүд авагдана. Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх асуудал байна. Гэхдээ харгалзаж үзэх нөхцөл байдлуудыг нь оруулж өгье. Ямар ч харгалзах зүйл байгүй болохоор процессгүй, мэтгэлцэх зарчим үйлчлэхгүй байна. Өөрөөр хэлбэл хуулийн этгээдийн үйл ажиллагааг тодорхой хугацаанд түдгэлзүүлье гэдэг асуудал дээр тэр нь нийтийн эрх ашигтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг байж болно эсвэл бизнесийн өөр чиглэлийн юм уу ямар ч үйл ажиллагаа байж болно. Гэхдээ тэр этгээдүүд бидний үйл ажиллагааг зогсооход, данс хаахад юуг харгалзах нь хуульд байхгүй бол мэтгэлцэх зарчим байхгүй, мэтгэлцэх зарчим байхгүй бол шударга процессын талаар ярих шаардлагагүй гэсэн үг. Бид нар тэгэхээр харьцангуй тогтсон байгаа захиргааны болон иргэний процесс дээрээс хуулийн этгээдтэй холбоотой түр хөрөнгө хамгаалах, зогсоох арга хэмжээнүүд дээр хэрэглэдэг УДШ-ээс гарсан дүгнэлтийг Эрүүгийн процесс дээр хэрэглэе гэсэн агуулгатай. Хэтэрхий тоочвол урт болно. Ямар ч байсан хууль дотор хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоосноор гадагшаа ямар эрсдэл үүсэх вэ? Бусдын амь нас, эрүүл мэнд, нийтийн эрх ашиг харин дотоод буюу тухайн аж ахуйн нэгжид түргэн муудах бүтээгдэхүүн, үйл ажиллагаа нь яаж доголдох гээд байгаа вэ? талаар энэ асуудлыг аль аль талаас харж үзэх шаардлага байна. Ингэж байж ядаж асуудал процесстой болох юм байна. Дээр нь хугацаа зааж өгье. Ямар ч хугацаагүйгээр үйл ажиллагааг нь зогсоочихдог хэзээ хэрэг нь шийдэгдэх нь тодорхойгүй ажилчид нь тараад явчихсан, тоног төхөөрөмжүүд нь муудчихсан, ноу-хау нь алдагдчихсаны дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь дууслаа гээд тэр хүмүүсийн зөрчигдсэн эрх нь хэзээ ч эргэж сэргэдэггүй. Тиймээс энийг сэргээх талаас нь шүүхийн хяналтад оруулах шаардлагатай. Яг цагдан хорио шиг цагдан хорио бол шүүхийн хяналтад 1 сар хугацаа болгон дээр прокурор санал, өмгөөлөгч хүсэлтээ гаргаад явдаг. Хугацаагаар нь хөнгөн хэрэг дээр 6 сар гээд лимит тавьж өгсөн. Хуулийн этгээдэд үйл ажиллагаагаа хаалгана гэдэг бол хүнээр бол цагдан хоригдсон гэсэн үг. Яагаад гэвэл юу ч хийж болохгүй хамаг ажилчид нь цалингүй болно. Үйл ажиллагааг нь бүр татан буулгана гэдэг нь хүнээр бол ялын дээд хэмжээ авч байгаагаар адил гэсэн үг. Энэ утгаараа процесстой байхгүй бол хуулийн этгээд болохгүй байна. Хүнтэй холбоотой асуудал бол Эрүүгийн процессын хууль дээр үеийн үед хөгжиж сайжирсаар ирсэн. 2017 оноос хэрэгжиж байгаа Эрүүгийн процессын хууль дээр хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, эрүүгийн хариуцлага оногдуулах, үйл ажиллагааг хөрөнгө хамгаалах ажиллагааны хүрээнд түр зогсоох ийм процессууд нэмэлтээр орж ирсэн. Ингэхдээ процессоо дэлгэрэнгүй биш, сая Эрхбаяр тодорхой хэллээ зохицуулалтгүй гээд хугацаа байхгүй, нөхцөл шаардлага байхгүй гээд тэр дээр бол авах нь үнэн гэдгээс бусад нь бол хуулийг нь харвал байхгүй. Тэгэхээр 14 дүгээр зүйл дээр хуулийн этгээдэд энэ хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гээд

энэ нь түдгэлзүүлэх дээр байгаа юм. Энийг бол бид нар нөхцөл шаардлагыг нь тодорхой болгоё гэдэг л зорилготой байгаа юм.

Эрхбаяр зөвлөх: Илүү өөрсдийн ахуйн соёл талдаа хүрсэн зохицуулах олон улсын жишиг харилцааг судалсан эсэх дээр энэ дээр бол нэлээн судалсан. Сая би танилцуулга дээр хэлсэн Франц, Испанийн жишээ яг манайхтай ижил эх газрын системтэй улсууд бол хуулийн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлэгддэггүй. Зөвхөн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг чиглүүлсэн удирдлага буюу эрх бүхий албан тушаалтанд эрүүгийн хариуцлага тооцдог. Энэ нь нөгөө талаараа хуулийн этгээдийг хамгаалдаг. Лиценз нь хууль биш бол компани, хуулийн этгээд ямар ч үед үйл ажиллагаа явуулна. Тэгэхээс эрүүгийн хариуцлагыг тухайн шийдвэр гаргасан албан тушаалтан хүлээнэ. Манайд бол 2014 онд хуулийн этгээд гэж нэр томьёо орж ирсэн ба үүнийг дагаад процесст нь эд хөрөнгө битүүмжлэхтэй холбоотой зохицуулалтууд орж ирсэн. Процесс нь дутмаг байна.

Өмгөөлөгч Ц.Баярмаа: Хуулийн төсөлтэй танилцахад хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа мөн хөрөнгийн шилжих хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагаа гэсэн 2 гол ойлголт байна гэж харж байна. Тэгэхээр энэ 2 ойлголт маань хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ нийт хугацаа 6 сараас хэтрэхгүй, мөн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах хугацаа 6 сараас хэтрэхгүй гэж оруулсан байна. Магадгүй хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох гэдэг бол танилцуулга дээр хэлсэнчлэн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, ажилчид ба түүний ар гэр гээд маш олон хүмүүсийн эрх ашиг байдаг учраас энийг тодорхой хугацаагүйгээр зогсоогоод байж болохгүй гэдэг дээр санал нэгдэж байгаа. Гэтэл хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ гэдэг маань агуулга нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан болон өөртөө шилжүүлж авсан тусгай зөвшөөрөл, компанийн эрх, хувьцаа цаашид бусдад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шалгах явцад бусдад бас шилжүүлээд үрэн таран хийхээс сэргийлээд авч байгаа ажиллагаа байгаа. Прокурорын тогтоолоор явагддаг ажиллагаа байгаа учраас энэ 2-ыг нэлээн ялгаа заагтай явахгүй бол өнөөдөр манай ЭХХША маань хэрхэн яаж удааширч явагддаг билээ. Бид нар бүгд практик дээр ажилладаг хүмүүсийн хувьд мэддэг. Тэр хооронд дээрх арга хэмжээг авчаад гэм буруутай эсэх шийдэгдтэл цаашаа улам бүр хохирогчийн эрх зөрчигдөж хохирохоос л хамгаалж байгаа заалт юм. Тэгэхээр энийг зургаахан сараар хязгаарлахаар нөгөө нэг үндсэн мөрдөн шалгах арга хэмжээ маань сар, сараар прокурор сунгаад л яваад байдаг. Магадгүй 2 жил 3 жил үргэлжилдэг гэтэл энэ шилжилт хөдөлгөөн чинь зургаахан сар байхаар эргээд үрэн таран болох асуудал үүснэ. Ер нь ажиллагаа удаашраад явах тохиолдолд бидний гомдол гаргаад шалгуулж байгаа компани маань аль хэдийн тусгай зөвшөөрлөө зарна гээд ар худгаар явж байдаг. Ийм учраас энэ 2 ойлголтоо ялгаж салгаж лимит хугацаагаа тавихгүй бол миний хувьд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах хугацаа 6 сар байх нь их эрсдэлтэй. Хуулийн гол орж ирсэн агуулгатай зөрчилдөх юм байна гэж харж байна. 26.1 дээр тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах орлого олох эх үүсвэрийг хаах гээд энэ саяны хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах асуудал буюу эрх патент гэрчилгээ, дансны шилжилт хөдөлгөөнийг хааж байгаа асуудал шүү дээ. Тэгэхээр энэ дээр бол бүтээгдэхүүн муудаж чанараа алдах үр дагаварт хүргэх гэдэг бол илүүц санагдаж байна. Энэ яг агуулгатай хамааралгүй байх. Харин хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох гэсэн асуудалтай бол чанар муудах, алдагдах байдал орж ирнэ. Энэ гэхдээ дээшээ заалт руугаа орж ирсэн байх шиг байна. Тэгэхээр миний хувьд 2 өөр хуулийн зохицуулалтынхаа тавих хугацаан дээр анхаарч өгөөрэй. Өөрөөр хэлбэл

хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ бол мөрдөн шалгах нийт хугацаатай адилаар гэм буруугийн асуудал шүүх дээр шийдэх хүртэл байсан нь зөв байх. Харин үйл ажиллагааг зогсоох 6 сар хүртэл бол байж болох хугацаа байна.

УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин: Хугацаа байхгүй байсныг хугацаатай болгоё гэсэн хуулийн төслийн агуулга байгаа. Хугацаа харин хэд байх вэ? гэдэг дээр энэ хэлэлцүүлгийн явцад оролцогч талуудын саналуудыг сонсож тодорхой хэмжээгээр ярилцах боломжтой.

Батбаяр хуульч: 26.2 дээр бол ажиллагаа маань бол МШ бусад ажиллагаа гэж хийгддэг. МШ бусад ажиллагаанууд хугацаатай байгаа. 26 дээр байгаа ажиллагаа хугацаагүй байна. Ялангуяа хугацаагүй хэрэглээд яваад байгаа нь хуулийн этгээдэд хохиролтой туссан үндэслэлээр хугацаа оруулж байгаа. Энэ 6 сар гэсэн хугацаа бол бодож байж хэлэлцүүлэхээр мэдээж үүн дээр маргаан гарах нь тодорхой асуудал юм. Яагаад 6 сар гэж оруулсан гэхээр хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, дансыг хаах, үндсэн чиглэлийг нь зогсоох нь хүнээр бол цагдан хоригдож байгаа юм шиг байдалд орж байна. Цалингаа олгож чадахгүй, үйл ажиллагаагаа явуулж чадахгүй хэцүү байдалд ордог. Тэгэхээр бид нар хөгжлийн банкны хэргийг ямар удаан явж байгааг харж байна. Тэд нар энэ хурлын дараа үйл ажиллагаагаа явуулах хэд үлдэх бол мэдэхгүй. Тэгэхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаатай уячихаар зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа өөрсдөө яаравчлахаа больчихдог гэж ойлгож байгаа. Тэгэхээр 6 сарын дотор хуулийн этгээдтэй холбоотой хэргээ шийдэх хэрэв сунавал сунасан хугацаанд нь шийдэх. Тэрнээс биш мөрдөн шалгах бусад ажиллагааг хэрэг хянах ажиллагааны хугацаатай уячихаар жишээлбэл дансанд нь хууль бусаар орсон 10 сая төгрөг байна гэж бодъё тэгэхээр тэр дансан дахь мөнгийг битүүмжлээд тусгай дансанд нь хийдэг юм уу тусгай зохицуулалтаар тэгээд байгууллагын дансыг буцаагаад нээмээр байгаа юм. Гэтэл тэрнээс болоод хэрэг дуустал дансаа хаалгасан сууж баймааргүй байна. Энэ агуулгаараа зохицуулалт хэрэгтэй байна гэж үзсэн. Таслан сэргийлэх арга хэмжээний хувьд та хугацаатай байна гэдэгт санал нэг байна гэж ойлголоо. Хохирол барагдуулах, хуульд бусаар олсон хөрөнгө орлогыг хураах зүйл бол байгаа. Үүнтэй холбоотой саналуудыг тусгаад явах нь зөв байх. 26 дугаар зүйл бол прокурорын авдаг арга хэмжээ үүнд харгалзах нөхцөлийг тусгаж өгсөн ба ямар нэгэн үүрэг болгосон зүйл байхгүй.

Доктор Гантөмөр: Би ДХИС, ОТИС-ыг төлөөлж энэ хэлэлцүүлэгт оролцож байна. Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудлыг нэлээн шинжлэх ухаан, онолын үндэстэй авч үзэхгүй бол манайд шинэлэг асуудал учраас бид институтийнхээ мөн чанарыг ойлгохгүй хуулийн зохицуулалт өөрчлөлт хийх нь нэлээн алдаатай байдалд хүргэж болзошгүй. Энэ нь хуулийн этгээдийн эрх ашгийг хохироох, хувийн бизнес, эдийн засгаа хумих асуудалтай учраас шинжлэх ухааны үндэстэй хандах нь зүйтэй гэж бодож байна. Таслан сэргийлэх арга хэмжээ бол процессын албадлагын арга хэмжээ юм. Тэгэхээр хуулийн этгээдэд хүлээлгэдэг ял, хуулийн этгээдэд хэрэглэдэг эрүүгийн бусад арга хэмжээнээсээ ялгахгүй таслан сэргийлэх арга хэмжээ маань ял болох боломжтой. Эрүүгийн бусад арга хэмжээний зорилгыг давхар агуулчих боломжтой учраас таслан сэргийлэх арга хэмжээний зорилгыг хуулийн этгээдийн хувьд тусгайлан авч үзэх. Ер нь хуулийн этгээдэд хүлээлгэх таслан сэргийлэх арга хэмжээг тусад нь зүйл болгомоор байна. Нийтлэг хувь хүнд хэрэглэдэг таслан сэргийлэх арга хэмжээнд чимэг, зүүлт болгож оруулах нь нэгдсэн зохицуулалт болж чадах уу? Хуулийн этгээдийн мөрдөн шалгах ажиллагаа, шүүн таслах ажиллагаа явуулах нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тусгай ажиллагааны журамтай байх ёстой. Насанд хүрээгүй хүүхэд, сэтгэц мэдрэлийн

өвчтэй хүний үйлдсэн гэмт хэрэгт хэрэглэдэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа гэдэгтэй адил хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх байцаан шийтгэх ажиллагааг тусгай ажиллагааны журмаар эрүүгийн процессын хуульд тусдаа бүлэг болж байж нэгдсэн нарийн зохицуулалттай болгохгүй бол хувь хүний үйлдсэн хэрэгт авагддаг ажиллагааны дунд шигтгээд оруулах нь болохгүй санагдаж байна.

Хуулийн этгээдэд хүлээлгэх таслан сэргийлэх арга хэмжээнд тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх гэдэг нь ерөнхий байна. Тэгэхээр үүнд ямар үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх вэ? хугацаа, төрөл нь ямар байх вэ? гэдгийг нарийвчлан зааж өгөх хэрэгтэй. Жишээлбэл, таслан сэргийлэх арга хэмжээ дээр нэг зүйл нэмэх хэрэгтэй. Манай том групп компаниуд маань салбар охин компаниудтай тэр нь 21 аймагт юм уу, зарим Казакстан, Киргизэд үйл ажиллагаа явуулдаг. Тэгэхээр орон нутагт ажиллаж байгаа охин компани эсвэл Киргизэд байгаа салбар нэгжийн үйл ажиллагааг түдгэлзүүлдэг таслан сэргийлэх арга хэмжээ баймаар байна. Тэгэхгүй бол компанийн бүх үйл ажиллагааг түдгэлзүүлчихээр саяны ярьдаг асуудал үүснэ. Тиймээс аль нэгжид ямар гэмт хэрэг гарснаас хамаараад салбар, нэгжийн үйл ажиллагааг түр хаадаг зохицуулалт байх хэрэгтэй. Ял дээр ч ийм байдаг. Манайх хуулийн этгээдэд зөвхөн торгох ялтай байгаа гэвч зарим улсад Францад 5,6 төрлийн ялтай бизнесийн нэр хүндэд халддаг, хуулийн этгээдэд хүлээлгэсэн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг олон нийтэд хүргэх эсвэл салбарын нэгжийг хаах гээд ялыг нарийвчлан зүйчилсэн байдаг. Энэ шиг биш гэхэд тодорхой нэгж, салбарын үйл ажиллагааг түр түдгэлзүүлэх гэж оруулах саналтай байна. Бас хугацаан дээр 1 сар хүртэл байна гэхээр манай прокурорууд, шүүгч нар 1 сараа л оногдуулна. Тэгэхээр үүнийг доод минимум нь 7 хоног ч гэдэг юм уу. Баярмаа өмгөөлөгчтэй санал нэг байна. Зарим арга хэмжээний төрлөөсөө хамаараад дээд хугацаа нь 6 сар биш зарим хугацаа нь урт байж болох байдлаар хуульчлах хэрэгтэй. Тэгээд таслан сэргийлэх арга хэмжээний төрлүүдийг нарийвчлан заах, үндэслэлүүд, хугацааг нь нарийн зохицуулсан зохицуулалт оруулах хэрэгтэй. Хуулийн этгээдэд хүлээлгэх таслан сэргийлэх арга хэмжээний зорилгыг зааж өгмөөр байна. Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн албадлагын арга хэмжээнээс ялгахын тулд таслан сэргийлэх арга хэмжээний зорилгыг хуулийн этгээдэд тусгайлан зааж өгөх хэрэгтэй. Хувь хүнд бол заасан байдаг. Дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх, хэрэг илрүүлэхэд саад учруулахгүй байх, оргон зайлуулахгүй байх гэдэгтэй адилхан хуулийн этгээдийн зорилгыг нарийвчлан зааж зохицуулах хэрэгтэй байна. Би өөрөө энэ чиглэлийн судлаач хүн 2002 онд хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудлыг монголд анх хөндөж өгүүллэг бичиж байсан. 2009 онд олон улсын хуралд эрүүгийн хуульд хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг ямар арга замаар хуульчлах уу? Гэдэг арга замыг тодорхойлсон илтгэл тавьж хэлэлцүүлж байсан. 2015 оны хуулийн төсөлд тодорхой хэмжээнд оролцож хуулийн этгээдэд хүлээлгэх хуулийн хариуцлагыг хуульчлахад оролцож байсан. Одонгэрэл гээд доктор ДХИС-д хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын чиглэлээр докторын зэрэг хамгаалахад нь би эрдмийн ажлын удирдагч багшаар ажиллаж байсан. ДХИС-д хүний эрхийн үндэсний комисст байгаа Цэлмэн гэдэг доктор хуулийн этгээдийн үйлдсэн хэргийг нотлох ажиллагаагаар бас доктор хамгаалж байсан. Тэгэхээр одоо ч гэсэн хуулийн этгээдэд авах таслан сэргийлэх арга хэмжээ бол доктор, магистрын судалгааны ажил харагдаж байна. Энийг цааш нь харьцуулсан эрх зүйн судлах хэрэгтэй байна. Манайх шиг ром германы орны жишиг биш гэдэг үе өнгөрсөн нэгэнт хуульчлагдсан. Хуулийн этгээдийг гэмт хэргийн субъектэд тооцох асуудал чинь социалист Хятад, Вьетнам, лалын шашинтай, муслим шашинтай орнуудад байна. Дэлхийн эрх зүйн тогтолцооны нийтлэг жишиг болсон учраас үүнээс ухрах, эргэлзэх зүйл байхгүй. Харин энийг

яаж нарийвчлан хуульчлах уу? Бүр эрүүгийн байцаан шийтгэх хуульдаа цогц байдлаар хуульчлах боломжтой гэж үзэж байна.

УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин: Гантөмөр докторт баярлалаа. Заримыг нь шууд аваад оруулчихмаар саналууд байна.

Батбаяр хуульч: Тусдаа зохицуулалтаар хуулийн этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тусдаа яаж явагдах юм бэ? гэдэг дээр би 100 хувь санал нэг байна. Манайд процессын хуулийг эхнээс нь уншихаар байхгүй юм байна лээ. Яаж явах нь тодорхойгүй. Тиймээс бид ядаж таслан сэргийлэх арга хэмжээ дээр ойлгомжтой болгох үүднээс явж байгаа юм. Талсан сэргийлэх ажиллагаа тусдаа байх асуудал дээр нэлээн том ажил болох байх. Эрдэмтэн, докторууд оролцоод хийхгүй бол цаашдаа өсөн нэмэх хандлагатай байгаа. Хуулийн этгээдүүд 2023 онд 27 хуулийн этгээд шүүхээр ороод ял авсан байна. Тэгэхээр энэ дээр нухацтай байх ёстой гэж бодож байна. 14.1 дээр “Яллагдагч, шүүгдэгч дээр энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу таслан сэргийлэх арга хэмжээ авч болно” энэ дотор хуулийн этгээд гэж үг байхгүй энэ мэтчилэн бараг зүйл болгон дээр утгагүй биччихсэн байгаа юм. 14.4 дээр “Хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг энэ зүйлд заасны дагуу түдгэлзүүлж болно” гэсэн нь яг юу гэсэн үг юм мэдэхгүй. Энэ зүйл гэсэн нь 14.4-д заасны дагуу түдгэлзүүлээд бай гэсэн ойлголт юм шиг байгаа юм. Үүн дээр харин бид тодорхой үйл ажиллагаа гэдэг үгний дунд нь тодорхой төрлийн үйл ажиллагаа гэж оруулсан. Тухайлбал нэг байгууллага IT-ийн чиглэлээр эсвэл хүний нөөцийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бол гэмт хэрэг гарсан гэж үзэж байгаа салбар төрлийн хэмжээнд нь таслан сэргийлэх арга хэмжээ авахгүй бол ерөнхийд нь бүгдийг зогсоочих хандлагатай байсан. Тиймээс бид нар тодорхой төрлийн үйл ажиллагааг дараах харгалзан үзэх нөхцөлтэйгөөр харж шийдвэрлэнэ гээд нарийвчилж оруулахыг хичээсэн. Таслан сэргийлэх арга хэмжээний хугацаан дээр нийтлэг жишиг, хуулийн нэр томъёоны зохицуулалтыг авч хэрэглэж байгаа учраас 30 хоног гэж оруулсан. Жишээлбэл Францад данс хаасан бол шүүх 10 хоногийн дотор эргэн хардаг гэх мэтчилэн хурдан шуурхай эргэж хардаг. Түүний цаана татвар төлөгч, олон хүний ажлын байр байдаг учраас арай илүү ялгамжтай байгаа. Хуулийн этгээдэд бид нар яагаад хугацааны хувьд аль болох богино тавьж байгаа вэ? гэхээр хуулийн этгээдэд холбогдох нийт 34 зүйл анги эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга дотор байгаа. Тэр зүйл заалт маань эрүүгийн хуулийг бүхэлд нь авч үзвэл эрүүгийн хуулийн ерөнхий ангид хөнгөн төрлийн гэмт хэрэгт орохоор ялын санкцтай. Тэгэхээр бид хөнгөн төрлийн гэмт хэргийг заавал удаан шалгаж, удаан дансыг нь хаах шаардлага байна уу? 6 сар гэдэг чинь хөнгөн хэрэг дээр хүнийг цагдан хорих дээд хугацаа шүү дээ. Тэгэхээр хүнийг хөнгөн хэрэг дээр 6 сараас дээш хугацаанд хорьдоггүй шиг хуулийн этгээдтэй холбоотой асуудал дээр 6 сараас дээш таслан сэргийлэх арга хэмжээ хөрөнгө хамгаалах ажиллагаа авахаар чинь үйл ажиллагааг нь дампууруулахтай адилхан зүйл болох учраас баримжааны хугацаа оруулсан.

Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Энхболд: Манай дээр энэ хуулийн төсөл дээр санал авахаар ирүүлсэн. Комиссын хурлаар хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаад хуулийн төслийн агуулгыг дэмжиж санал өгсөн. Яагаад гэвэл хуулийн этгээдийн үйл ажиллагаа түдгэлзүүлэх тухай асуудал яригдаж байгаа боловч бизнесийн үйл ажиллагаа, хүний эрхийн зарчмуудтай давхар холбогдож байдаг харилцаа юм. Нэгдүгээрт, хуулийн этгээдтэй холбоотой өмчлөгч, тодорхой хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас ашиг орлого олдог хүмүүс, хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс гээд олон эрх ашиг сонирхол холбогддог учраас процессыг маш нарийн зохицуулах ёстой учраас дэмжиж саналаа хүргүүлсэн. Таслан сэргийлэх арга хэмжээний зорилгыг тодорхойлохгүй бол ТСА авсан өдрөөсөө эхлээд яг ял шиг байдаг. Өөрөөр хэлбэл шууд орлого нь хаагдаад

үйл ажиллагаа нь зогсоод, олон нийтийн дунд бизнесийн үйл ажиллагаатай холбоотой нэр хүндийн асуудал давхар яригддаг учраас яг ямар асуудлыг шийдвэрлэхийн тулд энэ ТСА авах вэ? гэдгийг маш тодорхой бичих шаардлага байна. ЭХХШТХ-ийн 20 дугаар бүлэгт байгаа хуулийн этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх тусгай журам гэсэн бүлэг байна. Тэгэхээр энэ бүлэг дээр ТСА-ний төрлүүдийг маш тодорхой 14 дүгээр бүлгээс ялгаад тэнд оруулаад зорилготой нь нарийвчилж бичээд мөн МШТА-аас хэрхэн ялгагдах вэ гэдгийг 20 дугаар бүлэгтээ илүү нарийн сайн тусгах шаардлага байна. Хуулийн этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлж шийдвэр гаргасан хүний хэрэг хамт мөрдөн шалгагддаг. Тэгэхээр хуулийн этгээд гээд зөвхөн субъектийг шалгаад байгаа асуудал биш удирдлага, буруутай шийдвэр гаргасан хүний үйл ажиллагаа хамт шалгагдаад явдаг. Иймд энэ хэсгийг хэсэгчлэн ямар арга хэмжээ, хэн дээр яаж авах вэ гэдгийг зүй зохистой болгох ёстой. Практик дээр манай дээр ирсэн гомдол бол үйл ажиллагааг нь түдгэлзүүлээгүйтэй холбоотой хор уршиг, хохирол нь нэмэгдэж байгаа учраас яг ямар хуулийн этгээд ямар санхүүгийн эх үүсвэрээр үйл ажиллагаагаа явуулаад байгаа вэ? гэдэгт нь тохирсон таслан сэргийлэх арга хэмжээний төрлүүдийг нөхцөл дээрээ харгалзах шаардлага байна. Анхнаасаа хууль ёсны компани үйл ажиллагаагаа явуулдаг, тохиолдлоор гэмт хэрэгт холбогдох нөхцөл байдал байж болно. Энэ бол өөр зүйл харин анхнаасаа залилангийн зориулалтаар хөрөнгө босгоод үйл ажиллагаа явуулж байгаа бол энэ хуулийн этгээдэд авах ТСА хэмжээ болон хугацаа ямар байх вэ? гэдгийг нарийвчлан тусгах шаардлагатай байна. Мөн хуулийн этгээдийн хөрөнгийг битүүмжлэх, дансыг хязгаарлах, эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хаах гээд эдгээр асуудлуудыг давхар процессжуулаад явахгүй бол эд хөрөнгийн асуудлууд нь эргэлтэд ороогүйгээс маш их хохирол учраад байдаг асуудал үүсэж байна. Хугацаан дээр 6 сар гэдгийг эргэж харах ёстой. Мөрдөн шалгах байгууллагууд практикт ямар хүндрэлүүд учирдаг талаар ярих байх. Ер нь зарчим хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, нийтийн эрх ашиг сонирхлыг хамгаалах тухайлбал байгаль орчинд учирсан хохирол тэдгээрийг нөхөн сэргээх, авлигын хөрөнгө, татварыг буцаан төвлөрүүлэхтэй холбоотойгоор дийлэнх тохиолдлуудад энэ хязгаарлалтууд хийгдэж байгаа. Энэ зорилгын хүрээнд ТСАХ-үүд нь хэт богино хугацаатай байх юм бол буцаад эрүүгийн хариуцлагынхаа зорилгод хүрэхгүй байх сөрөг дагаврууд үүсэж байгаа учраас хугацааны асуудлыг шүүхэд шилжүүлснээр эсвэл шүүхийн анхан шатны шийдвэр гарснаар зогсоох асуудлыг олон улсын практиктэй нийцүүлж эргэж харах шаардлага байна гэж үзэж байна. Хуулийн төслийг дэмжиж байгаа.

АТГ-ын мөрдөн шалгах хэлтсийн ахлах ажилтан Жаргалбаатар:

Иргэний хуулийн 69 дээр яг л энэ төрлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг. Энэ хуулийн хугацааг одоогийн дэвшүүлж байгаа хуулийн төслийн хугацаатай харьцуулсан судалгаа хийсэн үү? Эрүүгийн хууль болон, ЭХХШТХ-ийн хийдэлтэй зохицуулалттай холбоотой сүүлийн 2017 оноос хойш маш олон хуулийн судалгаанууд, эрдэм шинжилгээний байгууллагууд дээр хэлэлцэгдсэн. Энэ судалгааны тайлангуудыг авч танилцсан болов уу? Тэр тусмаа ДХИС-д жил болгон энэ төрлийн эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулагддаг. Практик байгууллагуудын судалгааны нэгжүүд дээр энэ төрлийн судалгаанууд хийгдэж байгаа. Энэ судалгаануудыг авч үзсэн болов уу? Сөрөг бүхий кейс, нөхцөл байдал яг хэд гарсан бэ? Хэрэгцээ шаардлагаа сөрөг кейс дээр тодорхойлсон болов уу? Гэж бодож байна. Олон улсын сайн жишиг буюу Монгол улсад авч хэрэгжүүлэх боломжтой нөхцөл байдал бол хөрөнгийн менежментийн тухай хууль гэж олон улсад одоогоос Францад, Швейцарт ийм хуулиуд байдаг. Энэ хуультай холбоотойгоор пат болон НҮБ, мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага Монгол улсад жил болгон санал болон шаардлага

тавьж байдаг. Тэгээд хамтын ажиллагааны зөвлөл болон үндэсний зөвлөлөөс судалгаа авсан уу? Энэ харилцааг зохицуулах гэж боловсруулагдаж байгаа хуулийн төслүүд ямар түвшинд явж байгаа вэ? зэрэгцээд ижил хуулийн төслүүд өргөн баригдах уу? Би Монголбанк болон Сангийн яамнуудаас энэ чиглэлийн хуулийн төслүүд боловсруулагдаж байгаа сонсож байсан учраас эндээс та бүхэн мэдээлэл авсан уу? Дээр нь бид хэргээ бас харах хэрэгтэй шүү. Өнөөдөр Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалттай гадаадын аж ахуйн нэгжүүд зөндөө болсон. Гэмт хэрэг үйлдэхэд яг үүрэг чиглэл өгсөн албан тушаалтан, ТУЗ нь гадаад улсад байдаг Монголд ирдэггүй. Ганцхан гүйцэтгэх захирал байж байдаг, санхүүгийн баримт бичгүүдийн аваад монгол хэл дээр орчуулах, санхүүгийн шинжилгээ хийлгэх, олон улсын нэр томъёогоор бизнесийн үйл ажиллагаанд бохир мөнгийг холих гэсэн ойлголт байдаг. Энэ холигдсон мөнгийг яаж ялгах вэ? шинжилгээ хийлгэх, гадаадаас мэдээлэл авах, шинжээч нар ажиллах цаг хугацаа гэдэг асар их хугацаа байдаг шүү. Түүнээс зүгээр хүний хөрөнгийг үзэмжээр очоод битүүмжлэх гэх зүйл байхгүй. Гарч байгаа гэмт хэргүүд дээр тодорхой төрлийн цагдаагийн байгууллага маань судалгаагаа хэлэх байх. Ямар хэргүүд дээр тодорхой төрлийн үйл ажиллагааг хязгаарлаад байна гэхээр миний төсөөллөөр хуулийн этгээд байгуулаад ашигт малтмалын салбарт хүүхэд хөдөлмөрлүүлж байгаа тохиолдлууд байдаг. Хууль бусаар ашигт малтмал олборлож байгаа үйл ажиллагаатай холбоотой үйлдлийг тухайн хууль бус олборлолтуудыг таслан зогсоох чиглэлтэйгээр энэ таслан сэргийлэх арга хэмжээг зарим тохиолдолд хэрэглэж байгаа байх. Татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэргүүд дээр харьяаллын хувьд хэрэглэгдэж байгаа байх. АТГ-ын хувьд бохир мөнгийг цэвэр бизнестэй хольсон хөрөнгүүдийг ялгах ажиллагаанууд хийгдэж байна. Мөнгө угаах гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг мөнгөн хөрөнгүүдийн эх үүсвэр нь тодорхой биш гэмт хэрэг үйлдээд олсон хөрөнгө орлогоос бусад банк хадгаламжид байршуулаад хүү, орлого олоод байх. Энэ нөхцөл байдалтай холбоотойгоор хуулийн этгээдийн дансанд байгаа хөрөнгө мөнгийг битүүмжлэх, царцаах энэ төрлийн ажиллагаанууд хийгддэг. Ийм учраас эрсдэлтэй гэмт хэргээ энгийн гэмт хэргээс зааглаж ялган харгалзан үзсэн судалгаа хийсэн үү? давхар энэ хуулийн зохицуулалтын хийдлээр зарим төрлийн нийгэмд аюултай гэмт хэргүүдэд сэжигтэн, яллагдагч нар ашиглаад явчих хийдэл үүсгэх зохицуулалтууд болчихвий гэсэн эргэлзээ байна.

Батбаяр хуульч: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх арга хэмжээ бол шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ байдаг. Энэ арга хэмжээ бол Эрүүгийн процессоос өөр онцлогтой арга хэмжээ юм. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилготой. Гэмт хэрэг үйлдсэн, зэвсэг техник хэрэгсэл гэсэн агуулга байдаггүй. Дээр нь шүүхийн шийдвэр гарах хүртэл хүчинтэй байдаг. Гэхдээ иргэний процессоор гомдол гаргах процесс нь онцлогтой тусдаа. 69 дүгээр зүйлийн арга хэмжээ дээр харгалзаж үзэх нөхцөлүүд дэлгэрэнгүй, шүүхийн практик нь тодорхой тогтсон байдаг. 69 дүгээр зүйлийн арга хэмжээ авхуулсан тал хэрэв хэрэг хэрэгсэхгүй болбол нөгөө талдаа учирсан хохирлыг төлдөг. Харин манай Эрүүгийн процесс дээр ийм процесс байхгүй. Өөр онцлогтой учраас харьцуулагдах боломжгүй гэж харагдаж байна. Хуулийн этгээдтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түрүүн хэлсэнчлэн бүхэлдээ зохицуулалт нэн шаардаж байна. Энийг бүхэлд нь хийнэ гэвэл цаг хугацаа, ажлын хүч шаардана. Нэн яаралтай ТСА-д зохицуулалт оруулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнтэй холбоотой Баярсайхан докторын хуулийн этгээдэд хүлээлгэх хуулийн хариуцлага гэдэг номуудаас эхлээд Монголд хийгдсэн судалгаануудыг харсан. Жишээ нь 2007 оны Дэлхийн эрүүгийн загвар хууль, Дэлхийн эрүүгийн загвар хуулийн процессын хууль гэж байгаа. Дэлхийн эрүүгийн

загвар хуулийн процессын хуулийн дагуу бидний судалсан АНУ-ын нийт мужуудын талаас дээш хувь байсан байх. Тэр дээр хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагад таслан сэргийлэх арга хэмжээг авдаггүй гэж ойлгосон. Гэхдээ хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах зохицуулалт байгаа. Хуулийн этгээдийг МША-ны субъект болгоно гэсэн ойлголт байхгүй. Харин улсуудад байгаа. Тэгэхээр манайд хуулийн этгээдийг МША-ны субъект болгосон ч юм шиг, болгоогүй ч юм шиг ойлгомжгүй байгаа юм. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэж байснаа гэнэт хуулийн этгээд гээд гараад ирдэг. Яагаад зарим дээр нь гарч ирээд, зарим дээр нь байхгүйг ойлгохгүй байгаа юм. Хэрэгцээ шаардлагын хувьд шүүхийн практик болон Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д хүн шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэж байна. Шударга шүүхээр шүүлгэнэ гэдэг нь процессын шударга ёсыг ойлгоно гэж процессын шударга ёс яаж хэрэгждэг вэ? гэхээр процессын тодорхой байдлаар хэрэгжинэ. Тэгэхээр хуулийн этгээдэд энэ зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэдэг бол процессын шударга ёс, тодорхой байдал биш байна. Энийг бид тодорхой болгож байж Үндсэн хууль, процессын шударга ёс, тодорхой байдлын хүрээнд хэргийн оролцогч нар, субъектүүдийн тэгш эрх хангагдана. Энэ нь хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

Хуулийн этгээдтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар гүйцэтгэх захирал нь гэж хүн байж байдаг. Бүр гүйцэтгэх захиралгүй ч хэргийг манайхан шалгаж байгаа шүү дээ. Миний мэдэх зарим хэргүүд дээр орчуулагч, жолооч нь хууль ёсны төлөөлөгч нь болчихсон явж байдаг. Гэтэл гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигч, ТУЗ гэдэг хүмүүс нь хаана байгаа нь тодорхойгүй. Жишээлбэл жолоочид хууль ёсны төлөөлөгчийн итгэмжлэл өгөөд процесс хуулийн 9.5-аар томилоод явуулчихаар хууль ёсны төлөөлөгчөөр тогтоочихно. Тэгээд тэр хүнээс мэдүүлэг авахаар би энэ компанид жолооч хийдэг гэдэг. Тэгэхээр энэ төлөөлөл гэдэг маань маш ойлгомжгүй. Компанийн хуулийн 84 дүгээр зүйлээр төлөөлөл юм уу? Эсвэл тэр хүмүүсийн томилсон хүмүүсийг процесс хуулийн 9.5-аар хууль ёсны төлөөлөгч гэж үзэх юм уу? Тэгэхээр энэ процессын хийдлүүдийг нэг талаасаа хуулийн этгээдүүд нь ашигладаг байх нөгөө талаасаа процесс дутмаг байна гэдэг хүний эрх, хуулийн этгээдийн эрх ашиг хохирох нөхцөл байдлууд аль аль талдаа байна. Үүнийг би их өргөн хүрээтэй ойлголт гэж үзэж байна. Уг асуудлыг шийдэхийн тулд 2-3 хүн санал гаргасанд олзуурхаж байна. Тэр нь ТСАХ, хөрөнгө хамгаалах гээд бүгдийг нь 20 дугаар бүлэг рүүгээ оруулаад цогцоор шийдэж өгье гэж бид бас ярьж байсан. Тэгэхээр бид нар өөрсдийн даахгүй зүйл болгочих юм биш үү гээд ТСАХ дотроо ядаж хуулийн этгээдийг бүр тусад нь гаргах уу? Гэсэн боловч ТСАХ анх хийхдээ доод талд нь яллагдагч, шүүгдэгчид хамааралтай гэж оруулчихсан. Тэгэхээр бид байхгүй зүйлийг бүр шинээр нэмж хуулийн этгээдийн ТСАХ-г өргөтгөж байгаа юм шиг зүйл хийх нь бизнес эрхлэгч нарт гай болох мэт ойлголт өгчихвий гэж санаа зовсон. Тэгэхээр энэ мэтчилэн асуудлууд байгаа. ТСАХ-г манай хуулиар зорилгыг яг тодорхой тодорхойлоогүй юм байна лээ. Яагаад гэвэл 14.1-д ямар ч зорилго байхгүй, хувийн баталгаа гаргах ТСАХ-д зорилго байхгүй боловч тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг түдгэлзүүлэх, цагдан хорион дээр зорилго нь “Хэрэг хянан шийдвэрлэх хэвийн нөхцөлийг хангах, МША-д саад учруулахгүй байх” гээд байна. тэгэхээр зарим ТСАХ зорилготой зарим нь зорилгогүй ч юм шиг байна. Хуулийн этгээд дээр бол нийтлэг 2 зорилго байгаа байх. “Хэрэг хянан шийдвэрлэх хэвийн нөхцөлийг хангах, МША-д саад учруулахгүй байх” энэ зорилгын хүрээнд ТСАХ-үүд авагдаж байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр бид энэ зорилгыг оруулж болох байх гэсэн саналтай байна.

ЦЕГ-ын МША-ны Дэд бөгөөд Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, цагдаагийн хурандаа Батдэлгэр: Манай байгууллагаас төсөлтэй

танилцаад саналаа ирүүлсэн байгаа. Мөрдөх чиг үүрэг бүхий байгууллагууд маань иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдолтой бол хамгийн түрүүнд нүүр учирч үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнтэй ч уялдаад цаг хугацаатай уралдсан олон МША-ууд явагддаг. Тэгэхээр бид хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх ТСАХ-ний тухайд үндэслэлүүдийг тодорхой болгож өгөхгүй бол судлаач нар, санаачлагчид бүгд дурдаж байна. Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд төвөгтэй байдал үүсэх магадлал маш өндөр. Үүний эсрэг талд гэмт хэргийн замаар үйлдэж байгаа үйл ажиллагаа маань өшөө илүү цаг хугацаатай уралдаад ашиг олох, хохирсон иргэдийн эрх зөрчигдөх эрсдэл маш өндөр байдаг. Иргэдээс ч гэсэн иймэрхүү хүсэлтүүдийг МША-ны явцад их тавьдаг. Бид нар битүүмжилсэн байсан ч гэсэн зөрчөөд битүүмжилсэн үйл ажиллагааг явуулсан тохиолдлууд байдаг. Хугацааны хувьд бид нар МША явуулаад прокурорын байгууллагад шилжээд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хооронд аль эрт бидний яригдаад байгаа үйл ажиллагаа явагдаагүйгээс болоод тэр иргэний зөрчигдсөн эрх зөрчигдөөд дуусаад эцсийн байдалдаа хүрсэн тохиолдол ч байдаг. Хуулийн байгууллага шийдээд дуусдаг. Магадгүй хүчтэй техникүүд оруулаад олборлоод дууссан ч зүйл байдаг. Эсвэл цаг хугацаатай үргэлжлүүлээд МША явагдах болон дараа дараагийн шатны байгууллагууд руу шилжих хооронд гомдолд дурдагдаад байгаа гэмт үйлдэл нь үргэлжилсээр байдаг. Тэгэхээр эрсдэлтэй болоод гэмт үйлдлийг таслан зогсоох үндэслэлүүдийг маш тодорхой болгож өгөхгүй бол эрсдэлүүд гарах ба ААН-үүдтэй холбоотой эрх ашиг яригдана. Эсрэгээрээ гэмт үйлдлүүд таслан зогсоогдохгүй байдаг. Тэгэхээр үндэслэлийг тодорхой болгож өгөх мөн хугацааг 6 сардаа баригдах нь зөв үү? гэдэг дээр эргэж харарх саналтай байна.

Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Данзанноров: Гол ЭХХШТХ-ийг илүү боловсронгуй болгох, хийдэл зөрчлийг арилгах шаардлага нэлээн байгаа. Тодорхой зохицуулалтгүй харилцааг нь зохицуулалттай болгох, илүү тодорхой болгох үр дүн гарах болов уу гэж бодож байна. Манай холбоо төсөлд үзэл баримтлалын хүрээнд дэмжиж саналаа хүргүүлсэн. ТСАХ зөв зүйтэй байх, хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлд үр нөлөөтэй байхад хамгийн чухал зүйл нь ямар үндэслэлийн эсрэг, юуны эсрэг мэтгэлцэх ёстой вэ гэдгээ оролцогч талууд мэдэх тодорхой байх шаардлага байгаа. Энэ дээр хуульд тодорхой зааж өгөөгүйгээс болоод маргаан мэтгэлцээн өрнөх энэ боломжууд хязгаарлагдаж байна.

Шүүх дээр энэ төрлийн ТСАХ авах санал хэдийн хэмжээнд ирээд ямар хэмжээгээр ханган шийдвэрлэгдсэн, татгалзан шийдвэрлэгдсэн талаар судалж үзсэн үү? Мөн ТСАХ-г шийдвэрлэж байгаа нэг талын шийдвэрүүд нэлээн давамгайлсан болов уу? Энэ нь хуулийн төсөл боловсруулахад хэрэгцээ шаардлагад ач холбогдолтой болов уу? Гэж бодож байна. Нөгөө талаас нь бизнесийн орчныг дэмжих, хүний эрхийг хамгаалах, бизнест зүй бус хязгаарлалт тогтоохгүй байх төрийн бодлогод нийцэж байгаа гэж бодож байна. Яагаад гэвэл хуулийн этгээдийн үйл ажиллагааг түдгэлзүүлэхтэй холбоотой үр дагавар нь тухайн хуулийн этгээдэд төдийгүй хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүст шууд нөлөө үзүүлэх, нөгөө талаасаа хуулийн этгээдүүд өөрсдөө үйл ажиллагаа явуулахдаа зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа тохиолдолд энэ үр дагавар нь маш хүндээр тусаад эргээд тухайн ААН дампуурах үр дагаврыг үүсгэх магадлал маш их гарч байна. Учир нь зээлийн эх үүсвэр дээр тулаад очвол ТСАХ аваад үйл ажиллагаа нь түдгэлзэж байгаа нь бол цаад эх үүсвэрийг гаргасан банк болон банк бус санхүүгийн байгууллага төдийлөн хамаагүй. Та нарын ямар асуудалд холбогдоод яаж байгаа нь бид нарт хамаагүй л гэдэг болов уу? Тийм учраас энэ үр дагаврыг харгалзан үзэх шаардлагатай гэж бодож байна.

Мөн цаг хугацааны асуудал дээр их анхаарч үзэх шаардлагатай. 6 сар, 10 хоног, 7 хоног гэж яригдаж байна. Энэ бол энэ хугацаа хүртэл гэж дээд хугацааны таазыг тавьж байгаа асуудал биш. Энэ нь тухай бүр ТСАХ авагдсан нөхцөл байдал арилсан эсэхийг хөндлөнгийн институт болох шүүхээр шийдүүлнэ гэсэн асуудал байгаа юм. Тийм учраас хугацааны хувьд богино гэж болгоомжлох шаардлага байхгүй гэж бодож байна. Мөн ТСАХ-ий тухайд шүүхээр гэм буруутай нь тогтоогдоод ногдуулдаг ял шийтгэлтэй тэнцүү хэмжээний үр нөлөө, дагаврыг үзүүлдэг дээр асуудал байгаа юм. Энэтэй адилхан ТСАХ нь шүүхээс гарсан шийдвэртэй нь тэнцүү үр дагавар үзүүлдэг зарим ТСАХ бий. Цагдан хорихын тухайд бол тухайн холбогдож байгаа яллагдагчид ногдох үр дагавар байгаа. Гэтэл хуулийн этгээдэд холбогдох хариуцлага болохоор тухайн байгууллагад ажиллаж байгаа ажилчид, хэвийн үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг учраас үр дагаврыг харгалзаж шийдвэрлэх болов уу гэж бодож байна. Мөн Эрүүгийн хуульд зааснаар хуулийн этгээдэд ногдох хариуцлага дангаараа байдаггүй. Тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, удирдлагыг давхар татаж байдаг. Дангаар хуулийн этгээдийг татаад хуулийн хариуцлага хүлээлгэх нөхцөл байхгүй учраас тухайн үүсгэн байгуулагч болон яллагдагчид хамаарах ТСАХ-ий хүрээнд хөрөнгө хамгаалах, шилжих хөдөлгөөн хязгаарлах арга хэмжээнүүд бас давхар хэрэгжүүлэх боломж байдаг. Энийг бас харгалзаж үзэх хэрэгтэй болов уу гэж харж байна.

Батбаяр хуульч: 2023, 2024 оны шүүхийн практикаас шүүхээр хэдэн хэрэг шийдэгдсэн гэдэг судалгаа байгаа юм. ТСАХ-ий хувьд бол хэдэн санал, өмгөөлөгчөөс хэдэн хүсэлт орж ирээд хэдийг татгалзсан гэдэг судалгаа бол бид нарт байхгүй. Саналуудаа явуулсан боловч ирээгүй. Тухайн судалгаа нь цаанаа хийгддэггүй юм болов уу гэж ойлгосон. 26.1 болон 26.2 дээр прокурорын байгууллага дээр шийдэгдэж байгаа учраас шүүхийн шийдвэрийн цахим санд ч байхгүй тодорхойгүй юм байна лээ. Тэгэхээр бид нар хэрэгцээ шаардлага, процессын тодорхой байдал гэдэг утгаараа ийм хэмжээний хэрэг маргаан шийдэгдэж байна тэгэхээр хэрэг маргаан дээр тодорхой төрлийн ТСАХ хуулийн дагуу авагдаж байгаа. Хуулийн дагуу авагдахдаа 14.4.5-д заасны дагуу хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг энэ зүйлд заасны дагуу авч болно гэдэг ганцхан зохицуулалтын хүрээнд бүгд шахагдаж байгаа. Тэгэхээр хуулийн этгээдэд ямар ч сонголт байхгүй. Барьцаа байршуулах, бусад хувийн баталгаа гаргах гээд хүнд хамаатай байдаг. Хуулийн этгээд хэрэгт шалгагдах л юм бол сонголт байхгүй нэг л ТСАХ авхуулах болно. Тэр нь тодорхой төрлийн үйл ажиллагаагаа зогсоолгох юм. Хууль дээр ядаж тодорхой төрлийн ч гэж байхгүй тодорхой үйл ажиллагаа гэж байгаа. Тэгэхээр яг ямар төрлийн гэдгийг ялгаагүй учраас хохиролтой тусаад байгаа юм. Мөн лавшруулаад хэлэхэд цагдан хорих ТСАХ авагдсан хүн бол сүүлд нь эрүүгийн хариуцлага хүлээгээд ял авахдаа цагдан хоригдсон хоногоо үндсэн ялаасаа хасуулж тооцуулдаг. Гэтэл тодорхой төрлийн үйл ажиллагаагаа 2 жил хасуулсан хуулийн этгээд дараа нь шүүхээс 2 жилийн тодорхой төрлийн үйл ажиллагаагаа хасуулах ял авахдаа нийт 4 жилийн хугацааны ял авч байгаа юм. Тэгэхээр ТСАХ нь яг ялтайгаа адил. Тэгээд саналууд дээрээс харахад ТСАХ-тэй холбоотой хугацааг шүүхийн хяналтад аваачъя гэсэн бидний хүсэл байгаа яг цагдан хорио шиг сардаа юм уу хүсвэл гомдол гаргаад хянуулчхаж байя. Хуулийн этгээдэд авсан ТСАХ-ий үндэслэл арилсан, тодорхой мөнгийг дансанд байршуулсан, одоо манай үйл ажиллагаа явуулдаг дансыг чөлөөлөөд өгөөч гэдэг дээр тэрийг хянахгүй тогтолцоотой. Тэгэхээр бид нар шүүхийн тогтолцоонд үүнийг аваачсанаар ТСАХ-ий үндэслэл арилсан тохиолдолд хүчингүй болгох нөхцөл байдал руу орох давуу талтай хуулийн төсөл явж байгаа. Энийг зөвхөн процесс хуулийн 15.1-ээр хүсэлт гаргахаар зохицуулъя гэхээр холбооны ерөнхийлөгчийн хэлдгээр үндэслэж маргах зүйл нь байхгүй

учраас ямар ч утга байхгүй. Тэгэхээр бид өргөн агуулгаараа мэтгэлцэх сууриа хийж өгөхөөр энэ хуулийн төсөлд тодорхой үндэслэлүүдийг оруулж өгсөн.

Компаний хуулийн зөвлөх Серикбай: Компаниуд бол энэ хугацааг урт байна гээд байгаа. Яагаад гэвэл үйл ажиллагааг зогсоогоод зарим компани дампуурна харин төрийн байгууллагуудаас хугацааг богино гээд байна. Тэгэхээр энийг шийдэхийн тулд интервал тавивал яасан юм бэ? Энэ хэрэг дээр тэдээс тэд гэдэг байдлаар. Тэгвэл шийдэл гарчих юм шиг санагдлаа.

Батбаяр хуульч: Миний түрүүний хэлсэнчлэн эрүүгийн хуульд нийт 34 төрлийн гэмт хэрэг дээр эрүүгийн хуулийн хариуцлага оногдуулж байгаа. Тэгэхээр энэ 34 төрлийн хуулийн этгээдтэй холбоотой хэргүүд нь хөнгөн хэргүүдэд харьяалагдаж байгаа юм. Эрүүгийн хуулийн интервал болохоор нь хэргийн хөнгөн хүндээс хамаараад 2-8 жилийн хорих ялтай, 5-12 жил, 8-15 жил бүх нас гээд явдаг. Тэгэхээр хуулийн этгээдтэй холбоотой хэргүүд бол бүгд хөнгөн төрлийн гэмт хэрэгт хамаардаг учраас дотор нь ялгахгаар хууль шүүхийн өмнө эрх тэгш байх яригдана байх энийг хийхэд хэцүү байх. Гэхдээ бол санаа бол байж болохгүй зүйл бол байхгүй.

Монголын Олон Улсын арбитрын арбитрч Хонгор: Арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа дээр олон улсын практикт завсрын арга хэмжээ гэсэн зохицуулалт байдаг. Өөрөөр хэлбэл талуудын хүсэлтээр арбитрын бүрэлдэхүүнд тухайн этгээдийн данс дахь хөрөнгийг царцаах, барьцаалах эсвэл дансыг нь хаах арга хэмжээнүүд авдаг. Тэгэхээр яг энэ харилцааны асуудал дээр мэтгэлцээний зарчим бас л хохирогч талын хүсэлтээр арга хэмжээнүүдийг авна уу гэхээс шүүх өөрийн санаачилгаар тухайн арга хэмжээнүүдийг авах статистик судалгаа байна уу?

Батбаяр хуульч: Арбитрын түр арга хэмжээ болохоор талуудын хүсэлтээр иргэний 69 дүгээр зүйлийн 1-д заасан арбитрын хувилбар тэгэхээр арбитраас гарах биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний хүрээнд хувийн эрх зүйн хэргийн оролцогч нарын хүсэлтээр явдаг. Гэмт хэрэг маань болохоор хувийн эрх зүйн харилцаа биш учраас төрийн нэрийн өмнөөс прокурор, МШБ, ажил хийдэг. Энэ хүмүүс маань нийт хохирсон этгээдийн хохирлыг буцааж сэргээх МША, гэмт хэргийг илрүүлж тогтоох гээд нарийн зүйл ихтэй. Тэгэхээр хэргийн оролцогч, хохирогчийн санаачилгаар энэ арга хэмжээг авах гэж оруулбал нэлээн явцуурах магадлалтай. Гэхдээ түр арга хэмжээтэй төстэй зохицуулалт хуулийн этгээдийн хувьд байж болно гэдэгтэй санал нэг байна. Яагаад гэвэл хуулийн этгээд бол хүн биш, албан тушаалтан биш, субъектив санаа зорилго байхгүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаж чадахгүй. Тийм учраас удирдлагатайгаа цуг зарим орнуудад удирдлага биш хуулийн этгээдийг төлөөлөөд хууль бус үйлдэл хийсэн байх юм бол, хуулийн этгээдийн ашиг сонирхолтойгоо нийцэж байх юм бол татдаг. Гол асуудал хуулийн этгээдийг хүн гэж харж байгаад учир байгаа юм. Тэгэхээр хохирогч нарын эрх, эрүүгийн хуулийн 7.5-д заасан улсын орлого болгохын нөгөө талд нь хуулийн этгээдийн ашиг сонирхол, үйл ажиллагаатай холбоотой бусад нийтийн ашиг сонирхлыг балансжуулах ёстой.

байна. Иймд, энэ асуудлыг бас хуулийн шинэчлэлээрээ шийдвэрлэх хэрэгтэй байна.

МҮХАҮТ-ын Ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Лхагважав:

Өнөөдрийн манай энэ татварын асуудал олон жил явж байна, Үндсэн хууль нь өөрөө асуудал үүсгэсэн, бид мухардалд орчихсон. Компаниуд ихээр татварын өрөнд орж байгаа нь манай нягтлан бодох бүртгэлтэй холбоотой. НӨАТ-ын мөнгөн сууриар явах байтал нягтлан бодох бүртгэлийн нарийвчилсан (assurance) сууриар тооцож байгаа нь компаниуд орж ирээгүй мөнгөндөө сар болгон тайлан гаргаж өгч, түүнээсээ алданги тооцуулж, өрөнд ордог асуудал үүсгэдэг. Үүнийг мэргэжлийн нягтлан бодох институт хийх ёстой байсан.

Скай хайпермаркет ХХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Жавзмаа:

1. Татварын давхардлыг арилгах шаардлагатай байна. Жишээлбэл, компани ашгийн татвар төлчихөөд байхад хувьцаа эзэмшигчдээс ногдол ашгийн татвар авч байна. Энэ нь компанийн дотоод асуудал байх ёстой байтал төр оролцоод байна.
2. Бүх аж ахуйн нэгж ижил тэгш татвараа төлдөг баймаар байна. Ийм байж улсын төсөв төвлөрнө. НӨАТ-ын буцаалт авах эсэхээс үл хамаарч НӨАТ-өө бүгд л төлдөг байх ёстой. НӨАТ бол далд эдийн засгийг ил болгох зорилготой хууль болохоос биш улсын төсөв төвлөрүүлэх зорилготой хууль биш юм. Хуулиудыг яг концепцын дагуу ашиглаж, санаачилмаар байна.

Монцемент бьюлдинг материал ХХК-ийн Үйл ажиллагаа эрхэлсэн захирал Ц.Халиун:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг санаачлаад явж байгааг дэмжиж байна. Та бүхний мэдэж байгаагчлан улс төрийн явуулгын шинжтэй хяналт, шалгалт, үйл ажиллагаа зогсоох, тасалдуулах явдалд хамгийн их өртдөг нь манай Монполимет групп байгаа юм. Сүүлийн жил гарангийн хугацаанд ийм акцаас болж барагцаагаар тооцоход 20 тэрбумын алдагдал хүлээсэн байна. Гэтэл, ийм нөхцөлд хүргэчихээд юу ч болоогүй юм шиг хаядаг. Яаж хохирол барагдуулах, яаж нэр төрийг нь сэргээх зэргийг ямар ч хуульд тусгаагүй байдаг. Энэ асуудлыг аль нэг хуульдаа тусгасан байх ёстой гэж бодож байна.
2. Бид өнөөдөр эрчим хүчний дутагдалд орчихоод байгаа мөртлөө сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлтийг НӨАТ-аас чөлөөлсөн байсныг болиулж байгаа, мөн зөвшөөрлийн тухай хуулийн дагуу энэ төрлийн зөвшөөрөл авах гэж 1 жил гаруй болж байгаад логик алга байна. Хуулийн нэмэлт, өөрчлөлтдөө үүнийг анхаарч тусгамаар байна.

Артисан ХХК-ийн Бизнес хөгжлийн газрын захирал Х.Нямсүрэн: Бидний хэлэлцэж байгаа бүх хуулийн төслүүд бүгд бизнесийн орчинг сайжруулах зорилготой гэж харлаа. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон хуулийн 57 орчим нь бизнесийн орчинд нөлөөлдөг, хамааралтай хууль гэж санаж байна. Гэтэл, бид энэ 57 хуулиа тойроод л яриад байгаагаас биш Худалдааны хууль гэж ярихгүй, энэ чиглэлээр ажлын хэсэг байгуулагдаад ажиллахаараа алга болчихдог асуудал байна. Бид чөлөөт эдийн засагтай болоод 30 гаруй жил болчихоод худалдааны хууль хэрэгтэй байна. Олон тархай бутархай хуулийг нэгтгэж, нэг малгай хуультай болох хэрэгтэй байна.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.ЭНХТҮВШИН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Улаанбаатар хот, 14201, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,

Цахим шуудан: info@police.gov.mn,

Цахим хуудас: www.police.gov.mn

2025. 11. 20 № 01/1510
танай 2025. 11.07 -ны № 9ЦХ-03/12748Т

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингээс санаачилсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлтэй танилцаж дараах саналыг тусгуулахаар хүргүүлэв. Үүнд:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “14.4 дүгээр зүйлийн 6.1 дэх заалт”-ын “Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь бусдын” гэснийг “Хүний” гэж өөрчлөх;

2.Төслийн мөн зүйлийн 3 дахь хэсгийн “14.4 дүгээр зүйлийн 6.2 дахь заалт”-ын “Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь тухайн хуулийн этгээдийн” гэснийг хасах, “эх үүсвэрийг хаах,” гэсний дараа “эзэмшигчийн амьжиргаанд шууд нөлөөлөх,” гэж нэмэх;

3.Төслийн мөн зүйлийн 6 дахь хэсгийн “14.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг”-ийн “6 сараас” гэснийг “18 сараас” гэж өөрчлөх;

Тайлбар: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан цагдан хорих нийт хугацаатай нийцүүлэх нь зүйтэй.

4.Төслийн мөн зүйлийн 9 дэх хэсгийн “26.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг”-ийн “хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах” гэсний дараа “арилжааны банкинд эзэмшдэг, хамтран эзэмшдэг дансыг хязгаарлах” гэж нэмэх;

5.Төслийн мөн зүйлийн 10 дахь хэсгийн “26.1 дүгээр зүйлийн 3.1 дэх заалт”-ын “Бусдын” гэснийг “Хүний” гэж өөрчлөх;

6.Төслийн мөн зүйлийн 11 дэх хэсгийн “26.1 дүгээр зүйлийн “3.2 дахь заалт”-ын “эх үүсвэрийг хаах,” гэсний дараа “эзэмшигчийн амьжиргаанд шууд нөлөөлөх,” гэж нэмэх;

8.Төслийн мөн зүйлийн 12 дахь хэсгийн “26.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг”-ийн “6 сараас” гэснийг “18 сараас” гэж өөрчлөх;

9.Төсөлд хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг хугацаатай хэрэгжүүлэх талаарх ойлголтыг тус хуульд заасан яллагдагч, шүүгдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээнүүдийн төрлүүдэд хэрэглэх зохицуулалтыг нэмэлтээр тусгах нь зүйтэй байна.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Ж.БОЛД

1522 07 5949



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011 0251, Факс: (976) 7011 0251
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2025.11.18 № 01/19569.


танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ЭНХТҮВШИН ТАНАА

Таны 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн УИХ-03/12749 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль”-ийн төсөл, төслийн танилцуулга, үзэл баримтлал, хэрэгцээ, шаардлагыг урьдчилсан тандан судалсан тайлан, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээтэй танилцлаа.

Хуулийн төслийг бүхэлд нь дэмжих боломжгүй байна.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



З ДАШДАВАА

142503034420



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

Хуульчдын гудамж 15/1, Бага тойруу,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0027
Утас: 26 08 55, Факс: (976-51) 26 37 39,
Цахим шуудан: gro@prosecutor.mn,
Цахим хуудас: prosecutor.mn

2025. 12. 03 № 02/5249
танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.ЭНХТҮВШИН ТАНАА**

Таны 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн
УИХ-03/12750 дугаар албан бичгээр ирүүлсэн
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаад,
саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 4 хуудастай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ М.ЧИНБАТ

15010407483

Улсын ерөнхий прокурорын газрын
2025 оны А-дугаар сарын 13-ны өдрийн
12/30 дугаартай албан бичгийн
хавсралт

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ГАРГАСАН САНАЛ**

№	Зүйл, хэсэг, заалт	Гаргасан санал		Саналын үндэслэл, хэрэгцээ, шаардлага
		Өөрчлөх	Хасах	
0	1	2	3	4
1	<p>Хуулийн төсийн 1 дүгээр зүйл. 1/14.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг. “6. Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг дараах нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ.” 2/14.4 дүгээр зүйлийн 6.1 дэх заалт: “6.1. Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, бусад хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах эсэх.” 3/14.4 дүгээр зүйлийн 6.2 дахь заалт: “6.2. Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх нь тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэх эсэх.”</p>	<p>Уг таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхэд харгалзан үзэх нөхцөл байдлыг нарийвчлан тодорхойлж томъёолох.</p>		<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 дүгээр зүйлд “Тодорхой үйл ажиллагаа явуулахыг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ”-ний зорилгыг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцөлийг хангах” гэсэн агуулгаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн тодорхойлсон. Хуулийн төсөлд энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхэд харгалзан үзэх нэмэлт нөхцөлийг хэт ерөнхий агуулгаар буюу субьектив шалгуурыг тусгасан байна. Өөрөөр хэлбэл, эрүүгийн эрх зүйн процессын шинжтэй хэм хэмжээ, түүнийг хэрэглэх үндэслэл, шалгуурыг объектив байдлаар буюу нарийвчлан тодорхойлох нь хуулийг нэг мөр хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм. Харгалзан үзэх нөхцөлийг ерөнхий байдлаар өргөн хүрээнд хуульчилж, хууль хэрэглээний хэт хязгаарлагдмал байдлыг үүсгэх нь энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээний зорилго, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилтод нийцэхгүй. Иймд таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхэд харгалзан үзэх нөхцөл байдлыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.</p>

2	<p>Хуулийн төсийн 1 дүгээр зүйл. 4/14.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг: "7. хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг авах үндсэн хугацаа 1 сар хүртэл байна." 5/14.4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг: "8. Шүүх хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл арилаагүй гэж үзвэл хуулийн этгээдэд авсан тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгаж болно." 6/14.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг: "9. Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах нийт хугацаа 6 сараас хэтэрч болохгүй." 7/14.4 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг: "10. Мөрдөгч хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах хугацааг сунгах тухай саналаа дуусахаас 7-оос доошгүй хоногийн өмнө прокурорт хүргүүлэх ба прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах саналаа даруй шүүхэд хүргүүлнэ." 8/14.4 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг: "11. Шүүх Хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах хугацааг сунгах тухай прокурорын саналыг хугацаа дуусахаас 4-өөс доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 14.13 дугаар зүйлд зааснаар хянан</p>	<p>Хугацаа заасан зохицуулалтыг өөрчлөн томьёолох.</p>	<p>Таслан сэргийлэх арга хэмжээний зорилго нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн, шуурхай явагдахад бодитойгоор саад учруулж буй, эсхүл саад учруулж болзошгүй үйлдлийг гаргуулахгүй байх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, түүнчлэн хуулийг үндэслэлтэй, шударгаар хэрэгжүүлэх явдлыг хангах, хэргийн бодит байдлыг тал бүрээс нь бодитой тогтооход чиглэгддэг. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг тодорхой хугацаагаар прокурорын саналыг харгалзан шүүх шийдвэрлэхээр заасан.</p> <p>Хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд шууд, эсхүл шууд бусаар ноцтой хор хохирол учруулж болох нөхцөл байдал үүссэн үед хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түр түдгэлзүүлэх нь хууль зүйн үндэслэлтэй юм.</p> <p>Мөрдөн шалгах ажиллагааны явцад эрх бүхий байгууллагаас гарах шинжээчийн дүгнэлт, аудитын дүгнэлт гэх мэт нөхцөл байдлаас шалтгаалж мөрдөн шалгах ажиллагаа удаашрах тохиолдол гардаг.</p> <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх, хүчингүй болгуулах тухай хүсэлтийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд гаргах эрхтэй. Иймд уг таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа заасан зохицуулалтад өөрчлөлт оруулж, үндэслэл, үр дагавар арилсан тохиолдолд таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгохоор томьёолох нь зүйтэй.</p>
---	---	--	---

	<p>хэлэлцэж, тухайн таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа сунгах, эсхүл сунгахыг татгалзах тухай шийдвэр гаргана."</p> <p>Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 9/26.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг: "3.Прокурор нь хуулийн этгээдэд холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ. 10/26.1 дүгээр зүйлийн 3.1 дэх хэсэг: "3.1.Бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, бусад хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах эсэх," 11/26.1 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсэг: "3.2.Тухайн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн бүтээгдэхүүн түргэн муудах, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэх эсэх," 12/26.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: "4.Хуулийн этгээдэд холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулах нийт хугацаа 6 сараас хэтэрч болохгүй."</p>			<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.1 дүгээр зүйлд заасан "Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах" мөрдөн шалгах ажиллагаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны "хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх" зорилт, Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан "Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ"-г шүүх хэрэглэх урьдчилсан нөхцөлийг хангахад чиглэсэн, прокурорын зөвшөөрлийн үндсэн дээр явагдах ажиллагаа юм.</p> <p>Хуульд зааснаар аливаа иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлд буй хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагаа явуулахад, тухайн хөрөнгө нь гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон, эсхүл хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байх урьдчилсан нөхцөлийг хангасан байх шаардлага тавигддаг.</p> <p>Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааны улмаас хүн, хуулийн этгээд хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн, хөндөгдсөн, мөн хуулийн төсөлд тусгагдсан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу хүсэлт, гомдол гаргах замаар хязгаарлалтыг цуцлах эсэх асуудлыг шийдвэрлүүлэх боломжтой.</p> <p>Мөн хуулийн 1.7 дугаар зүйлийн 1-д "мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй", 2-т "Хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч ...яллах, цагаатгах, ...нөхцөл байдлыг эргэлзээгүй</p>
3			<p>Бүхэлд нь хасах.</p>	

				<p>ТОГТООНО” гэж хуульчилсан. Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах, хэргийн бодит байдлыг тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл арилах хүртэл хугацаанд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах шаардлагатай тул уг заалтыг бүхэлд нь хасах.</p>
--	--	--	--	---

---oOo---



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

Ц.Жигжиджавын гудамж 7/1, Бага тойруу, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 15 44,
Цахим шуудан: info@supremecourt.mn

2026 01.16

№ 01/197

танай

-ны №

-т

Хуулийн төслийг буцаан хүргүүлэх талаар

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингээс санаачлан боловсруулсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл”-д санал авахаар 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 1/2307 дугаартай,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагаас санаачлан боловсруулсан “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-д санал авахаар 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 1/2492 дугаартай,

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон Эрүүл мэндийн яамнаас хамтран боловсруулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” болон “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-д санал авахаар 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 1/1335 дугаар албан бичгүүдийг тус тус ирүүлснийг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд уг хуулийн төслүүдэд Улсын дээд шүүхээс санал өгөх боломжгүй гэж үзсэнийг уламжилъя.

Танаас ирүүлсэн 1/2307, 1/2492, 1/1335 дугаартай албан бичигт Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, 21.4 дэх хэсгүүдийг баримтлан “байгууллага, албан тушаалтан” нь “төсөлд өгөх санал”-ыг “10 өдрийн дотор бэлтгэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” талаар заасан байна.

Улсын дээд шүүхээс хуулийн төсөлд санал авах харилцааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлээр зохицуулаагүй гэж дараах үндэслэлээр үзэж хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж дахин ирүүлэх саналтайгаар төслийг буцаасан болно.

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хуулийн төсөлд Засгийн газар, түүний харьяа агентлаг, байгууллагуудаас санал, дүгнэлт авах харилцааг зохицуулсан,

- Төрийн бусад эрх мэдлийн байгууллагуудаас хуулийн төсөлд санал авах журмыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд тусгасан,

- Тухайлбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хуулийн төсөлд Улсын дээд шүүхээс санал авах хугацааг 21 дүгээр зүйлээс ялгаатайгаар тусгайлан тогтоосон,

151601900624

- Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.2-т "... тусгайлан заасан асуудлаар хууль тогтоомжийн төслийг зөвхөн Засгийн газар санаачлах" -аар,

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7.1-д " эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн төсөл"-ийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаар батлахаар тус тус зохицуулсан,

- Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Х.Болормаа нар нь санаачлан боловсруулсан хуулийн төслөө Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасан журмын дагуу танайд хүргүүлж байгаагаа дурдсан зэрэг болно.

Үүнээс үзэхэд, Улсын дээд шүүхээс санал өгөх хуулийн төсөлд тавигдах шаардлага, санал өгөх хугацааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаас хууль тогтоогч ялгаатай буюу мөн хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулагдаж буй Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлтэй адилтган 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгээр тогтоосон атал хуульд маш тодорхой заасан шат дамжлагуудыг алгасан 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасан "Засгийн газрын бусад гишүүн, холбогдох байгууллага"-д Улсын дээд шүүхийг хамааруулан төслийг шууд ирүүлсэн нь төрийн эрх мэдлийг хуваарилах онол болон хууль бүтээх үйл ажиллагааны үндсэн зарчмуудад нийцэхгүй байна. Тодруулбал, хуулийн төсөлд тавигдах шаардлагууд бүрэн хангагдаагүй өөрөөр хэлбэл, үзэл баримтлал бүрэн тогтоогүй, хэрэгцээ, шаардлага тодорхойгүй, үр нөлөө үнэлэгдээгүй, хэрэгжилтийн зардлын эх сурвалж, холбогдох тооцоо, судалгаа хийгдээгүй, эдгээр нь эрх бүхий байгууллагаар хянагдан баталгаажаагүйн улмаас таамаглал, төсөөллийн түвшинд боловсруулагдсан "түүхий" төслүүдэд хуулийг тайлбарлаж хэрэглээний нэгдмэл практик тогтоох үүрэг бүхий институт болох шүүхийг төлөөлөх дээд байгууллага төслийг эхлэн боловсруулах үеэс санал өгч ажлын хэсэгт орж ажиллах байдлаар хуулийн эцэслэгдсэн төсөлд хууль хэрэглээний асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааны хүрээ, хязгаараас хальж оролцож буй нь зөвхөн хууль тогтоох, санаачлах зэрэг бүрэн эрхдээ үл хамаарах асуудлаар хууль тогтоомжийг бүтээлцэж буй хэрэг болно гэж үзэж байна.

Цаашид Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон бусад хуулийн төслийг Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиас гадна дээр заасан хууль бүтээх техник, энэ талаарх түгээмэл онол, нийтлэг арга зүйд нийцсэн журмын дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд заасан заавал хангагдах шалгуурыг биелүүлсний дараа Улсын дээд шүүхэд ирүүлж байх нь зүйтэй.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс боловсруулсан

- хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах болон хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагаа явуулах үндэслэл, хугацааны талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн",
- "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл" болон "Эрүүгийн хууль", "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн",

- “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-үүд нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох Засгийн газрын үндсэн чиглэлд нийцсэн эсэхийг тодорхойлж, үзэл баримтлал, хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, үр нөлөө, гарах зардлын тооцоог эрх бүхий байгууллагуудаас эцэслэн баталгаажуулсны дараа Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу ирүүлж байх нь шүүн таслах ажиллагааны нэгдсэн бодлого, процессын шударга байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийг нэгдмэл хэрэглэх шүүхийн практикийг өөрчлөн тогтооход алдаа гарахаас урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэйг дурдах нь зүйтэй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингээс санаачлан боловсруулсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл”, Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагаас санаачлан боловсруулсан “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”, Хууль зүй, дотоод хэргийн яам болон Эрүүл мэндийн яамнаас хамтран боловсруулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-үүдийг танайд буцаан хүргүүлэв.

Хувийг: Хууль санаачлагч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Х.Болормаа нарт

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



Д. ГАНЗОРИГ